

САНГИЙН САЙДЫН ТУШААЛ

2022 оны ... дүгээр
сарын ... -ны өдөр

Дугаар

Улаанбаатар хот

Даатгалын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж,
байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох
бүртгэлийн журам батлах тухай

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.3 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. "Даатгалын байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн заавар, журам"-ыг 1 дүгээр, "Даатгалын байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны жагсаалт"-ыг 2 дугаар, "Даатгалын байгууллагын санхүүгийн тайлангийн маягт, тодруулга"-ыг 3 дугаар, "Даатгалын байгууллагын санхүүгийн тайлан, тодруулга бэлтгэх аргачлал"-ыг 4 дүгээр хавсралтаар тус тус баталсугай.

Хоёр. Батлагдсан заавар, журам, маягт, аргачлалыг даатгалын байгууллагуудын нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдүүлэх, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газар /Б.Болормаа/-т үүрэг үүрэг болгосугай.

Гурав. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Сангийн сайдын 2020 оны 132 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД

Б.ЖАВХЛАН

ДААТГАЛЫН БАЙГУУЛЛАГАД МӨРДӨХ НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ЗААВАР, ЖУРАМ

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (цаашид СТОУС гэх) болон Монгол Улсын нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, холбогдох бусад хууль, тогтоомжинд нийцүүлэн боловсруулсан энэхүү зааврын зорилго нь Даатгалын байгууллагын үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлд тусгаж, санхүүгийн тайланг үнэн зөв бэлтгэхэд оршино.

Монгол Улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж байгаа даатгалын байгууллагууд нь энэхүү дансны жишиг жагсаалт, зааварт үндэслэн СТОУС болон Монгол Улсад мөрдөгдөж буй хууль, дүрэм, журамд бүрэн нийцсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг, дансны дэлгэрэнгүй жагсаалтыг боловсруулж мөрдөнө.

Энэ зааварт нягтлан бодох бүртгэлийн үндсэн зарчмыг тусгаж, дансдын нийтлэг бичилтүүдийг үзүүлсэн бөгөөд энд тусгагдаагүй зүйлсийг бүртгэхдээ холбогдох СТОУС-ын заалтыг дагаж мөрдөнө. Энэ зааварт тусгагдаагүй шинэ бүтээгдэхүүн, арилжааг бүртгэх дансны харилцаа, бүртгэлийн зарчмыг Санхүүгийн зохицуулах хороонд урьдчилан мэдэгдэж, зөвшөөрөл авна.

Даатгалын байгууллага нь нягтлан бодох бүртгэлээ аккрузл сууриар хөтөлнө.

Нягтлан бодох бүртгэлийн үзүүлэлт буюу тайлагналын нэгж нь Монгол улсын үндэсний мөнгөн тэмдэгт төгрөг, мөнгө байна.

Гадаад валютаар илэрхийлэгдсэн хөрөнгө, өр төлбөрийг Монголбанкнаас зарласан албан ханшаар үнэлж, ханшийг тэгшитгэж, толилуулна.

Даатгалын байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэл хөтлөлт, санхүүгийн тайлан бусад мэдээ баримтыг тогтсон загварын дагуу үнэн зөв бэлтгэж, заасан хугацаанд багтаан гаргах үүргийг холбогдох хууль тогтоомжийн дагуу хүлээнэ.

Өмнөх тайлант хугацаанд хамаарах мэдээллийг өөрчилж тайлагнах тохиолдолд Санхүүгийн зохицуулах хороонд урьдчилан мэдэгдэнэ.

ХОЁР. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ЗАРЧИМ

2.1 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ЗАРЧИМ

Компани нь санхүүгийн тайлагналын олон улсын стандартыг нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа мөрдөнө.

Компани нь Санхүүгийн зохицуулах хорооноос батлан гаргасан нягтлан бодох бүртгэлийн заавар, зарчмыг тууштай мөрдөнө.

Компани нь санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ зэрэг санхүүгийн тайлангуудыг үнэн зөв бодитойгоор илэрхийлсэн байна. Санхүүгийн тайланд тоон болон чанарын үзүүлэлтүүдийг харгалзан, шаардлагатай бол нэмэлт тайлбар, тодруулгуудыг бэлтгэнэ.

Санхүүгийн тайланд тусгагдах мэдээллийн найдвартай байдлыг хангахын тулд мэдээллийг иж бүрнээр нь тусгана.

Компанийн удирдлага нь санхүүгийн тайланг бэлтгэх явцад өөрийн компанийн үйл ажиллагааг тасралтгүй байх зарчмын дагуу үргэлжлүүлэх чадварт үнэлэлт дүгнэлт өгнө. Компанийг татан буулгах, түүний үйл ажиллагааг зогсоох шийдвэр гараагүй тохиолдолд удирдлага нь тасралтгүй байх зарчмын дагуу санхүүгийн тайлангаа бэлтгэнэ.

Компанийн үйл ажиллагаанд гарсан томоохон хэмжээний өөрчлөлтөөс бусад тохиолдолд санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүдийн илэрхийлэл болон түүний ангиллыг нэг тайлант үеэс нөгөө тайлант үед өөрчлөхгүй.

Энэхүү бүртгэлийн заавар нь СТОУС-ын шаардлагын дагуу компанийн санхүүгийн тайлангийн тоон мэдээллийг арга зүйн хувьд бүх тайлант хугацааны тоон мэдээллийг хооронд нь харьцуулж болохоор зохион байгуулна.

Мэдээллийг хэрэглэгчдийн шийдвэрт нөлөөлөх боломжтой хугацаанд болон Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон хугацаанд багтаан санхүүгийн тайланг бэлтгэж толилуулна. СТОУС-д шаардсан эсвэл зөвшөөрснөөс бусад тохиолдлуудад хөрөнгө ба өр төлбөр, орлого болон зардлыг нэгтгэж, цэвэр дүнгээр тайлагнахгүй.

2.2 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ӨӨРЧЛӨЛТ, АЛДААНЫ ЗАЛРУУЛГА

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримтын өөрчлөлт

Компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн өөрчлөлт нь Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан журам, заавар, аргачлалтай зөрчилдөж байгаа тохиолдолд Санхүүгийн зохицуулах хороонд урьдчилан мэдэгдэж зөвшөөрөл авна.

Нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлт

Хөрөнгөөс хүлээгдэж буй ирээдүйн үр өгөөж болон өр төлбөрийн явц нь тухайн санхүүгийн нөхцөл байдалд үнэлгээ хийсний үр дүнд хөрөнгө, өр төлбөрийн дансдын үлдэгдэл болон хөрөнгийн хэрэглээний зарцуулалтын дүн өөрчлөгдөхийг нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлт гэнэ.

Нягтлан бодох бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлтийг ирээдүйн тайлант үеүдэд хүлээн зөвшөөрнө.

Шинэ нягтлан бодох бүртгэлийн бодлогыг хэрэгжүүлж эхэлсэн өдрөөс хойших цаг хугацаанд ажил гүйлгээ болон өөр бусад үйл явдлын тооцооллын өөрчлөлтийн нөлөөг гарсан тайлант хугацаа эсвэл ирээдүйн тайлант хугацаанд хүлээн зөвшөөрч бүртгэхийг хүлээгдэж буй хандлага гэнэ.

Нягтлан бодох бүртгэлийн алдааны залруулга

Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүдийг хүлээн зөвшөөрөх, үнэлэх, толилуулах, тодруулахтай холбоотойгоор алдаа гарч болзошгүй бөгөөд нягтлан бодох бүртгэлийн алдааг тухайн тайлант хугацаанд багтаан илрүүлж, санхүүгийн тайланг хэвлэн нийтлэхээс өмнө залруулсан байвал зохино.

СТОУС-д өөрөөр заагаагүй тохиолдолд өмнөх тайлант хугацаанд хамаарах нягтлан бодох бүртгэлийн алдааг илрүүлсэн тайлант хугацаанд нь буцаан үйлчлэх горимоор залруулна.

Нягтлан бодох бүртгэлийн алдааны залруулгыг хийхдээ Санхүүгийн зохицуулах хороонд урьдчилан мэдэгдэж, зөвшөөрөл авсан байна.

ГУРАВ. ХӨРӨНГӨ

3.1. МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ

А. ШУУД ХОЛБОГДОХ СТАНДАРТУУД

- СТОУС 7 Санхүүгийн хэрэглүүр: Тодруулга
- СТОУС 9 Санхүүгийн хэрэглүүр
- СТОУС 13 Бодит үнэ цэнийн хэмжилт
- НББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулга
- НББОУС 7 Мөнгөн гүйлгээний тайлан
- НББОУС 21 Гадаад валютын ханшийн өөрчлөлтийн үр нөлөө
- НББОУС 32 Санхүүгийн хэрэглүүр: Толилуулга
- НББОУС 39 Санхүүгийн хэрэглүүр: Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт

Б. ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨЛТ

Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийг эзэмшиж, захиран зарцуулах эрх даатгалын байгууллагад үүссэн нөхцөлд хүлээн зөвшөөрнө.

В. ХЭМЖИЛТ БА ҮНЭЛГЭЭ

Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөхдөө бодит үнэ цэнээр бүртгэнэ. Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийг тайлагналын өдөр хорогдуулсан өртгөөр үнэлж тусгана. Иймд энэхүү хөрөнгөтэй холбоотой хуримтлуулан тооцсон хүүний авлагыг мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн дансны дүнд оруулж, санхүүгийн тайланд толилуулна. Төгрөгөөр байршуулсан мөнгөн хөрөнгийн бодит үнэ цэн нь нэрлэсэн үнэ байна.

Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийг Монголбанкны албан ханшаар тооцон төгрөгт хөрвүүлэн хүлээн зөвшөөрөх ба төгрөг, валютаар давхар бүртгэнэ. Тайлагналын өдөр гадаад валютыг тухайн өдрийн албан ханшаар дахин үнэлэх ба ханшийн тэгшитгэлээр үүссэн зөрүүг тайлант хугацааны орлого, зардлаар хүлээн зөвшөөрнө.

Хугацаа хэтэрсэн буюу үнэ цэн буурсан санхүүгийн хэрэглүүр нь мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн тодорхойлолтод нийцэхгүй тул үүнийг мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгөөс хасч, холбогдох ангилалд шилжүүлэн бүртгэнэ (авлага гэх мэт).

Г. БҮРТГЭЛ

Бэлэн мөнгө

Бэлэн мөнгө дараах зүйлсээс бүрдэнэ. Үүнд:

- Касс дахь бэлэн мөнгө
- Замд яваа мөнгө

Касс дахь бэлэн мөнгө: Үндэсний болон гадаадын цаасан мөнгөн тэмдэгт, зоос, бутархай мөнгө.

Касс бэлнээр орлого тушаавал

Дебит: Бэлэн мөнгө

Кредит: Холбогдох данс

Кассаас бэлэн мөнгө зарлагадвал

Дебит: Холбогдох данс

Кредит: Бэлэн мөнгө

Замд яваа мөнгө: Даатгалын байгууллага болон банкны хооронд бэлэн мөнгийг шилжүүлэх хугацаанд түр бүртгэсэн бэлэн мөнгө.

Даатгалын байгууллага нь банкинд цүнхээр мөнгө тушаавал

Мөнгө хүлээлгэн өгөхдөө

Дебит: Замд яваа мөнгө

Кредит: Бэлэн мөнгө

Харилцах дансны хуульыг үндэслэн

Дебит: Харилцах данс

Кредит: Замд яваа мөнгө

Харилцах, хугацаагүй хадгаламж

Банкинд байршуулсан төгрөг, гадаад валютын харилцах, хугацаагүй хадгаламжийн дансууд багтана. Банк, санхүүгийн байгууллагад харилцах, хадгаламжийн данс нээхдээ тухайн банктай байгуулсан гэрээ, хэлцэл, компанийн удирдлагын шийдвэрийг үндэслэнэ.

Харилцах, хугацаагүй хадгаламжийн дансандаа бэлэн мөнгө тушаавал

Дебит: Харилцах, хугацаагүй хадгаламж

Кредит: Бэлэн мөнгө

Харилцах, хугацаагүй хадгаламжийн данснаас зарлага хийвэл

Дебит: Холбогдох данс

Кредит: Харилцах, хугацаагүй хадгаламж

Харилцах, хугацаагүй хадгаламжийн дансанд хүү тооцож орлогодвол

Дебит: Харилцах, хугацаагүй хадгаламжийн данс

Кредит: Хүүний орлого

Мөнгөтэй адилтгах хөрөнгө

Банк санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгөд 3 хүртэлх сарын хугацаатай хадгаламж, хадгаламжийн сертификат, Монголбанк болон Засгийн газраас гаргасан үнэт цаас хамаарна. Мөн мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгөнд хуримтлуулж тооцсон хүүний авлагыг хамруулна.

Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан 3 хүртэлх сарын хугацаатай хадгаламжийн сертификат, хадгаламжид орлого хийвэл

Дебит: 3 хүртэлх сарын хугацаатай хадгаламжийн сертификат, хадгаламж

Кредит: Холбогдох данс

Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан 3 хүртэлх сарын хугацаатай хадгаламжид хүү тооцож хуримтлуулахад

Дебит: 3 хүртэлх сарын хугацаатай хадгаламжийн сертификат, хадгаламж хүүний авлага

Кредит: Хүүний орлого

Хуримтлуулсан хүү төлөгдөхөд

Дебит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

Кредит: 3 хүртэлх сарын хугацаатай хадгаламжийн сертификат, хадгаламж хүүний авлага

Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан 3 хүртэлх сарын хугацаатай хадгаламжийн сертификат, хадгаламжийн хугацаа дууссан үед

Дебит: Холбогдох данс

Кредит: 3 хүртэлх сарын хугацаатай хадгаламжийн сертификат, хадгаламж

Монголбанк болон Засгийн газраас гаргасан үнэт цаасыг худалдан авахад

Дебит: Монголбанк болон Засгийн газрын үнэт цаас

Кредит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

Монголбанк болон Засгийн газраас гаргасан үнэт цаасанд хүү тооцоолж, хуримтлуулахад

Дебит: Монголбанк болон Засгийн газрын үнэт цаасны хуримтлуулж тооцсон хүүний авлага

Кредит: Хөрөнгө оруулалтын хүүний орлого

Хуримтлуулсан хүү төлөгдөхөд

Дебит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

Кредит: Монголбанк болон Засгийн газрын үнэт цаасны хуримтлуулж тооцсон хүүний авлага

Монголбанк болон Засгийн газраас гаргасан үнэт цаасны хугацаа дуусах үед

Дебит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

Кредит: Монголбанк болон Засгийн газрын үнэт цаас

Д. ТОДРУУЛГА

Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн хувьд дараах зүйлсийг санхүүгийн тайлангийн тодруулгад тусгана.

- Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн бүрэлдэхүүн, ангилал.
- Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн бодит үнэ цэнэ.
- Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн хүү буюу бусад өгөөж.
- Тайлагналын өдрөөрх гадаад валютын ханшийг тодруулна.
- Даатгалын байгууллагын эзэмшилд байгаа боловч компани өөрөө ашиглах боломжгүй, хязгаарлагдмал мөнгөн хөрөнгийг тодруулна.

- Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн үлдэгдэлд гарсан өөрчлөлтийг тайлбарын хамт тодруулна. Тайлбараа мөнгөн гүйлгээний тайлангийн үзүүлэлтүүдийг хамруулан хийж болно.
- СТОУС 7-д заасан бусад тодруулгад холбогдох үнэлгээний аргачлалыг ашиглан тооцсон банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгийн үнэ цэнийн бууралтыг тодруулна. Үнэлгээний аргачлалаар үнэ цэнийн бууралтыг тогтоох боломжгүй тохиолдолд хөрөнгийн чанарын талаар тодруулж, тайлбарлана.

Е. ХЯНАЛТ

- Ажилтнуудын ажил үүргийг зааглан тусгаарлана.
- Гүйлгээний баримтын бүрдлийг хангана.
- Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө тус бүрийн дэлгэрэнгүй бүртгэлийг хөтөлнө.
- Дэлгэрэнгүй бүртгэлийг дансны гүйлгээ, үлдэгдэлтэй тохируулна.
- Кассын хадгалалт хамгаалалт, аюулгүй байдлыг хангана.
- Кассын үлдэгдэлд гэнэтийн болон тогтмол шалгалт хийнэ.
- Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн ажил гүйлгээг улирал бүр тулган баталгаажуулна.
- Даатгалын байгууллагын касс нь Групп компанийн кассаас тусдаа байна.

3.2. ДААТГАЛЫН АВЛАГА

А. ШУУД ХОЛБОГДОХ СТАНДАРТУУД

- СТОУС 4 Даатгалын гэрээ
- СТОУС 7 Санхүүгийн хэрэглүүр: Тодруулга
- СТОУС 9 Санхүүгийн хэрэглүүр
- СТОУС 13 Бодит үнэ цэнийн хэмжилт
- НББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулга
- НББОУС 21 Гадаад валютын ханшийн өөрчлөлтийн үр нөлөө
- НББОУС 32 Санхүүгийн хэрэглүүр: Толилуулга
- НББОУС 39 Санхүүгийн хэрэглүүр: Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт

Б. ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨЛТ

Даатгалын хураамжийн авлагыг даатгалын гэрээ байгуулагдаж, даатгалын хураамжийг орлогод хүлээн зөвшөөрөх үед бүртгэнэ.

Буруутай этгээдээс авах авлагыг буруутай этгээдээс авах нөхөн төлбөрийн орлогыг хүлээн зөвшөөрөх үед бүртгэнэ.

Давхар даатгаагчаас авах нөхөн төлбөрийн авлагыг нөхөн төлбөрийн зардлыг хүлээн зөвшөөрөх үед бүртгэнэ. Давхар даатгалын гэрээг үндэслэн нөхөн төлбөрийн давхар даатгагчид ногдох хэсгийг давхар даатгаагчаас авах нөхөн төлбөрийн авлагаар хүлээн зөвшөөрнө.

Давхар даатгаагчаас авах хураамжийн авлагыг давхар даатгалын гэрээ цуцлагдах үед хүлээн зөвшөөрнө.

Давхар даатгаагчаас авах шимтгэлийн авлагыг давхар даатгалын гэрээ байгуулагдсанаар хүлээн зөвшөөрч бүртгэнэ.

В. ХЭМЖИЛТ БА ҮНЭЛГЭЭ

Даатгалын хураамжийн авлагыг даатгалын гэрээнд заасан даатгалын хураамжийн дүнгээр бүртгэнэ. Даатгалын хураамжийн авлагыг даатгуулагчаас төлсөн дүнгээр бууруулна.

Буруутай этгээдээс авах авлагыг буруутай этгээдээс авах нөхөн төлбөрийг орлогоор хүлээн зөвшөөрсөн дүнгээр бүртгэнэ.

Давхар даатгаагчаас авах нөхөн төлбөрийн авлагыг даатгуулагчид олгохоор шийдвэрлэсэн нөхөн төлбөрийн давхар даатгагчид ногдох дүнгээр бүртгэнэ.

Давхар даатгаагчаас авах хураамжийн авлагыг давхар даатгалын гэрээ цуцалсны улмаас давхар даатгаагчаас буцаан авах дүнгээр бүртгэнэ.

Давхар даатгаагчаас авах шимтгэлийн авлагыг давхар даатгалын гэрээнд заасан дүнгээр бүртгэнэ.

Даатгалын авлагыг эрсдэлийн сан хассан цэвэр дүнтэй тэнцэх хорогдуулсан өртгөөр хэмжинэ. Гадаад валютаар илэрхийлэгдсэн авлагыг тайлант хугацааны эцэст Монголбанкнаас зарласан албан ханшаар төгрөгт хөрвүүлэн тэгшитгэнэ.

Тайлант хугацааны эцэст СТОУС-ын дагуу даатгалын авлагад үнэ цэнийн бууралтыг тооцож бүртгэнэ. СТОУС-ын дагуу үнэ цэнийн бууралтыг хэмжихдээ санхүүгийн тайлагналын өдрөөр хөрөнгийн үнэ цэнэ буурсан эсэхийг шалгах ба үнэ цэнэ буурсан шинж тэмдэг байгаа бол тухайн хөрөнгийн бодит үнэ цэнийг тооцож, дансны үлдэгдэлтэй харьцуулан, хөрөнгийн бодит үнэ цэнээс хэтэрсэн дансны үлдэгдлээр эрсдэлийн сан байгуулна. Эрсдэлийн сангийн зардлыг буцаах нөхцөл хангагдсан үед эрсдэлийн сангийн зардлын буцаалтыг анх бүртгэсэн эрсдэлийн сангийн зардлаас хэтрүүлэлгүйгээр бүртгэнэ.

Үнэ цэнийн бууралтыг тооцох СТОУС-д нийцэх аргачлалыг компани дотооддоо боловсруулж, мөрдөж болно.

Г. БҮРТГЭЛ

Гэрээ байгуулагдаж даатгалын хураамж бүрэн төлөгдсөн бол

Дебит: Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

Кредит: Даатгалын хураамжийн орлого

Даатгалын гэрээ байгуулагдсан ба гэрээний хариуцлага эхэлснээр

Дебит: Даатгалын хураамжийн авлага

Кредит: Даатгалын хураамжийн орлого

Даатгалын авлага төлөгдөхөд

Дебит: Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

Кредит: Даатгалын хураамжийн авлага

Даатгалын гэрээ байгуулагдаж даатгалын хураамжийг хэсэгчлэн төлсөн бол

Дебит: Даатгалын хураамжийн авлага

Дебит: Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

Кредит: Даатгалын хураамжийн орлого

Дараагийн хэсэгчилсэн төлбөр төлөгдөхөд

Дебит: Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

Кредит: Даатгалын хураамжийн авлага

Буруутай этгээдээс авах авлага үүсгэхэд

Дебит: Буруутай этгээдээс авах авлага

Кредит: Буруутай этгээдийн хариуцсан нөхөн төлбөр

Буруутай этгээдээс авах авлага төлөгдөхөд

Дебит: Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

Кредит: Буруутай этгээдээс авах авлага

Давхар даатгаагчаас авах нөхөн төлбөрийн авлага үүсгэхэд

Дебит: Давхар даатгаагчаас авах нөхөн төлбөрийн авлага

Кредит: Давхар даатгаагчийн хариуцсан нөхөн төлбөр

Давхар даатгаагчаас авах нөхөн төлбөрийн авлага төлөгдөхөд

Дебит: Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

Кредит: Давхар даатгаагчаас авах нөхөн төлбөрийн авлага

Давхар даатгаагчаас авах хураамжийн авлага үүсгэхэд

Дебит: Давхар даатгаагчаас авах хураамжийн авлага

Кредит: Давхар даатгалын хураамжийн буцаалт

Давхар даатгаагчаас авах хураамжийн авлага төлөгдөхөд

Дебит: Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

Кредит: Давхар даатгаагчаас авах хураамжийн авлага

Давхар даатгалын шимтгэлийг хойшлогдсон орлогод бүртгэхэд

Дебит: Давхар даатгаагчаас авах шимтгэлийн авлага

Кредит: ДД-ын хойшлогдсон шимтгэлийн орлого

Тайлагналын өдрөөр давхар даатгалын шимтгэлийн ногдох хэсгийг орлогод бүртгэхэд

Дебит: ДД-ын хойшлогдсон шимтгэлийн орлого

Кредит: Давхар даатгалын шимтгэлийн орлого

Давхар даатгалын шимтгэл төлөгдөхөд

Дебит: Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

Кредит: Давхар даатгаагчаас авах шимтгэлийн авлага

Хэвийн ангилалд байсан Даатгалын авлагын ангилал буурвал

Дебит: Хугацаа хэтэрсэн-Даатгалын авлага

Кредит: Даатгалын авлага (хэвийн)

Даатгалын авлагад эрсдэлийн сан байгуулах болон дутуу байгуулсан эрсдэлийн санг нэмж байгуулахад

Дебит: Холбогдох эрсдэлийн сангийн зардал

Кредит: Даатгалын авлагын эрсдэлийн сан (Даатгалын хураамжийн авлагын эрсдэлийн сан, Буруутай этгээдээс авах авлагын эрсдэлийн сан, Давхар даатгаагчаас авах нөхөн төлбөрийн авлагын эрсдэлийн сан, Давхар даатгаагчаас авах хураамжийн авлагын эрсдэлийн сан, Давхар даатгаагчаас авах шимтгэлийн авлагын эрсдэлийн сан)

Илүү байгуулсан эрсдэлийн санг буцаахад

Дебит: Даатгалын авлагын эрсдэлийн сан

Кредит: Холбогдох эрсдэлийн сангийн зардал

Хэрэв эрсдэлийн санг буцаах дүн нь тухайн өдрөөрх холбогдох эрсдэлийн сангийн зардлын үлдэгдлээс хэтэрсэн бол

Дебит: Даатгалын эрсдэлийн сан

Кредит: Бусад орлого

Даатгалын авлагыг эрсдэлийн сангаас хаахад

Дебит: Даатгалын эрсдэлийн сан

Кредит: Даатгалын авлага

Хаасан даатгалын авлагын дүнгээр тэнцлийн гадуурх дансанд орлогодож, даатгалын авлагыг эргүүлэн төлүүлэх ажиллагааг үргэлжлүүлнэ.

Эрсдэлийн сангаас хаагдсан даатгалын авлагаас төлөгдөхөд

Дебит: Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

Кредит: Бусад орлого-Эрсдэлийн сангаас хаагдсан авлагын эргэн төлөлт

Төлөгдсөн авлагын дүнгээр тэнцлийн гадуурх данснаас зарлагадна (бүртгэлийг тэнцлийн гадуурх бүртгэл хэсгээс үзнэ үү).

Д. ТОДРУУЛГА

Санхүүгийн тайлангийн тодруулгад дараах зүйлсийг тусгана.

- Даатгалын авлагын үлдэгдлийг авлагын ангилал болон насжилтыг харуулсан тайлан (даатгалын авлагын ангилал, активын ангилал)
- Даатгалын авлагын эрсдэлийн сангийн өөрчлөлтийн тайлан (эхний үлдэгдэл, нэмэгдсэн, хасагдсан, эцсийн үлдэгдэл)
- Холбоотой талаас авах даатгалын авлага

- Даатгалын авлагын үлдэгдэлд гарсан өөрчлөлтийг тайлбарын хамт тодруулна.
- Даатгалын авлагын эрсдэлийн сан тооцоолсон аргыг тодруулна.

Е. ХЯНАЛТ

- Ажилтнуудын ажил үүргийг зааглан тусгаарлана.
- Даатгуулагч бүрээр дэлгэрэнгүй бүртгэл хөтөлнө.
- Дэлгэрэнгүй бүртгэлийг дансны гүйлгээ, үлдэгдэлтэй тохируулна.
- Даатгалын гэрээ, гэрээт баталгаа, буруутай этгээд болон гуравдагч талтай байгуулсан гэрээ, давхар даатгалын гэрээг найдвартай газарт хадгална.
- Ангилал буурсан даатгалын авлага тус бүрээр хувийн хэрэг хөтөлнө.
- Авлагыг холбогдох журмын дагуу ангилан бүртгэж, авлагын эрсдэлийн санг шаардлагатай хэмжээгээр байгуулна.
- Материаллаг үлдэгдэлтэй даатгалын авлагыг харилцагч бүрээр нь тооцоо нийлсэн актыг үйлдэнэ.
- Данснаас хассан авлагуудыг холбогдох шийдвэртэй нь тулган шалгана.
- Буруутай этгээдээс нэхэмжлэх авлагыг холбогдох шийдвэртэй нь тулган шалгана.

3.3. БУСАД САНХҮҮГИЙН БА САНХҮҮГИЙН БУС ХӨРӨНГӨ

А. ШУУД ХОЛБОГДОХ СТАНДАРТУУД

- СТОУС 7 Санхүүгийн хэрэглүүр: Тодруулга
- СТОУС 9 Санхүүгийн хэрэглүүр
- СТОУС 13 Бодит үнэ цэнийн хэмжилт
- СТОУС 16 Түрээс
- НББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулга
- НББОУС 2 Бараа материал
- НББОУС 23 Зээлийн өртөг
- НББОУС 36 Хөрөнгийн үнэ цэнийн бууралт
- НББОУС 39 Санхүүгийн хэрэглүүр: Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт

Б. ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨЛТ

СТОУС-д заасан хөрөнгө хүлээн зөвшөөрөх үндсэн шалгуурыг хангаж, уг хөрөнгийг эзэмших хүчин төгөлдөр эрх даатгагчид үүссэн тохиолдолд бусад санхүүгийн ба санхүүгийн бус хөрөнгийг хүлээн зөвшөөрнө.

Бусад авлагыг даатгалын байгууллага нэхэмжлэх хууль ёсны эрх үүссэн, авлагын дүнг тооцоолох боломжтой ба авлага цуглуулагдах магадлалтай үед хүлээн зөвшөөрнө.

Санхүүгийн түрээсийн авлагыг гэрээнд даатгалын байгууллага түрээслүүлэгч болж байгаа бол санхүүгийн түрээсээр түрээслүүлсэн хөрөнгөө санхүүгийн байдлын тайланд авлага байдлаар харуулна. Санхүүгийн түрээсээр хөрөнгийн эзэмшилтэй холбоотой бүх эрсдэл, өгөөжийг түрээслэгчид шилжүүлдэг ба түрээслүүлэгч өөрийн хөрөнгө оруулалт, үйлчилгээг нөхөхийн тулд эргүүлэн төлөх үндсэн төлбөр болон санхүүгийн орлогыг түрээсийн авлагад бүртгэнэ.

Салбар хоорондын тооцоог хураамжийн орлого төвлөрүүлэлт, үйл ажиллагааны зардлын санхүүжилт (төв компани даатгалын хураамжийн орлогыг төвлөрүүлж, салбарын үйл ажиллагааны санхүүжилтийг олгодог бол), нөхөн төлбөрийн олголт (төв компаниас салбараас ирүүлсэн нөхөн төлбөрийн материалыг судлан, олгохоор шийдвэрлэсэн нөхөн төлбөрийг гүйцэтгэсэн бол), салбарын цалин олголт, ХХОАТ, НДШ-ийн төлөлт (салбарын өмнөөс нэгдсэн журмаар татвар, НДБ-ийн тооцоо хийдэг бол, энэ тохиолдолд салбар нь орон нутгийн татвар, даатгалын байгууллагатай сар бүр тооцоо нийлж, акт үйлдэнэ), төсвийн дагуу хийгдэх бараа материалын худалдан авалт (бизнес төлөвлөгөөний төсвийн дагуу төв компани нэгдсэн журмаар худалдан авалтыг зохион байгуулдаг бол), гэрээгээр гүйцэтгүүлсэн ажлын зардал (салбарын өмнөөс барилгын засварын ажлын гэрээг байгуулан гүйцэтгэсэн бол), хөрөнгө оруулалт, засвар шинэчлэлт гэх мэтийг хүлээн зөвшөөрч бүртгэнэ. Салбар хоорондын тооцооны данс зөвхөн компанийн бүтцэд хамаарагдах салбар, нэгжид хэрэглэгдэнэ.

Татвар, НДШ-ийн авлагыг сар, улирал ба жилийн эцэс дэх татвар, нийгмийн даатгалын шимтгэлийг тайлагнаснаар хүлээн зөвшөөрнө.

Бараа материалын орлогыг бараа материал хүлээн авсан үед, бараа материалын зарлагыг бараа материалыг борлуулсан болон ашиглалтад тавьж олгосон үед хүлээн зөвшөөрч бүртгэнэ. Бараа материалын үнэ цэн буурсан үед үнэ цэнийн бууралтыг тайлангийн үеийн гарзаар хүлээн зөвшөөрч бүртгэнэ.

Урьдчилж төлсөн зардал/ тооцоог хууль тогтоомжийн дагуу төлөх татвар, шимтгэл болон байгууллага, хүмүүстэй хийсэн гэрээгээр үйл ажиллагааны зардлыг урьдчилан төлбөл урьдчилж төлсөн зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэнэ. Урьдчилж төлсөн зардлын тайлант хугацаанд ногдох хэсгийг холбогдох зардалд бүртгэнэ.

Өмчлөх бусад хөрөнгийг нөхөн төлбөрийн тооцоонд хөрөнгө хүлээн авч захиран зарцуулах эрхийг даатгагч шилжүүлэн авснаар хүлээн зөвшөөрч бүртгэнэ. Өмчлөх бусад хөрөнгийг бусдад худалдахаар гэрээ хийж, өмчлөх эрхийг шилжүүлснээр данснаас хасна. Өмчлөх бусад хөрөнгийг борлуулахад үүсэх олз, гарзыг тайлант хугацаанд хүлээн зөвшөөрнө.

В. ХЭМЖИЛТ БА ҮНЭЛГЭЭ

Бусад авлагыг эрсдэлийн сан хассан цэвэр дүнтэй тэнцэх хорогдуулсан өртгөөр хэмжинэ. Гадаад валютаар төлөгдөх авлага болон тооцоог Монголбанкнаас зарласан албан ханшаар төгрөгт хөрвүүлэн төгрөг, гадаад валютаар давхар бүртгэх ба ханшийн хэлбэлзлээс үүсэх орлого, зардлыг гадаад валютын ханшийн тэгшитгэлийн олз, гарзаар хүлээн зөвшөөрнө.

Санхүүгийн түрээсийн авлагыг түрээсэлсэн хөрөнгийн бодит үнэ цэнэ ба түрээсийн төлбөрийн аль багаар үнэлж, бүртгэнэ. Түрээслүүлэгч түрээстэй холбоотой санхүүгийн орлогыг түрээсийн хугацаанд системтэй бөгөөд үндэслэлтэй сууриар хуваарилна. Орлогыг хуваарилахдаа санхүүгийн түрээст багтсан түрээслүүлэгчийн цэвэр хөрөнгө оруулалтын тогтмол өгөөжийг тусгасан шинж чанарт үндэслэнэ.

Салбар хоорондын тооцоог төв, салбар хооронд хийгдсэн дүнгээр хэмжинэ. Тайлагналын өдрөөр төв болон салбар хоорондын авлага, өглөгийг цэвэршүүлсэн дүнгээр тайлагнана.

Татвар, НДШ-ийн авлагыг татвар Нийгмийн даатгалын байгууллагад тайлагнасан дүнгээр бүртгэнэ. Тайлагналын өдрөөр аливаа татварын авлага, өглөгийг цэвэршүүлсэн дүнгээр тайлагнана. Тайлант хугацааны татварын илүү төлөлт (авлага) болон хойшлогдсон татварын хөрөнгийг хүлээн зөвшөөрч, хэмжих талаар энэ зааврын "Орлогын албан татвар" бүлгээс үзнэ үү.

Бараа материалын орлогыг худалдаж авсан өртгөөр бүртгэнэ. Бараа материалын өртөгт худалдан авалтын өртөг, хувиргалтын зардал болон одоогийн байршил ба нөхцөлд бараа материалыг авчрахтай холбогдож гарсан бүх зардал орно. Бараа материалын өртөгт худалдан авсан үнэ, импортын хураамж болон бусад татвар (татварын эрх бүхий байгууллагаас дараагийн үеүдэд тухайн аж ахуйн нэгжид нөхөн олгохоос бусад) худалдан авахтай шууд холбогдон гарах бусад зардлууд орно. Худалдааны хөнгөлөлт, урамшуулал болон бусад адилтгах зүйлсийг хасч худалдан авалтын өртгийг тодорхойлно. Бараа материалын өртгийг эхэлж авсныг эхэлж зарлагдах арга эсвэл дундаж өртгийн аргаар гүйцэтгэнэ. Бараа материалын үлдэгдлийг өртөг ба цэвэр боломжит үнэ цэнийн аль багаар үнэлнэ. Гадаад валютаар худалдан авсан бараа материал, хангамжийн зүйлийг бүртгэлд тусгах өдрийн Монголбанкнаас зарласан албан ханшаар төгрөгт хөрвүүлэн бүртгэнэ.

Урьдчилж төлсөн зардал/тооцоог мөнгөөр төлсөн дүнгээр хэмжинэ. Тухайн тайлант хугацаанд ногдох хэсгийг тооцоолон холбогдох зардлаар бүртгэнэ.

Өмчлөх бусад хөрөнгийг нөхөн төлбөрийн тооцоонд авч байгаа дүн ба уг хөрөнгийн тухайн үеийн борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнийн аль багаар нь анх үнэлж бүртгэнэ. Өмчлөх бусад хөрөнгийг анх хүлээн зөвшөөрсний дараах тайлант хугацаанд хэрхэн хэмжиж, ангилах нь хөрөнгийн онцлог шинж, компанийн бодлого, төлөвлөгөөнөөс шалтгаална. Хэрэв даатгалын байгууллага олж авсан үндсэн хөрөнгийг ашиглахаар шийдвэрлэсэн бол нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн дагуу үндсэн хөрөнгийн холбогдох дансанд шилжүүлж, ангиллыг өөрчилнө. Хэрэв өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгийг өөрөө ашиглалгүйгээр бусдад түрээслүүлэх болон капиталын өгөөж хүртэх зорилгоор эзэмшилдээ үлдээхээр шийдвэрлэсэн бол хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн дансанд шилжүүлж, ангиллыг өөрчилнө. Өмчлөх бусад хөрөнгийг борлуулах, засварлах, хадгалах, хамгаалахтай холбогдон гарах урсгал зардлыг тайлант үеийн зардлаар, хэрэв засварласны үр дүнд түүний хүчин чадал, чанар сайжирч, үнэ цэнэ нь өсч байвал холбогдох засварын зардлыг капиталжуулж бүртгэнэ.

Тайлант хугацааны эцэст СТОУС-ын дагуу өмчлөх бусад хөрөнгө болон бусад авлагад үнэ цэнийн бууралтыг тооцож бүртгэнэ. СТОУС-ын дагуу үнэ цэнийн бууралтыг хэмжихдээ санхүүгийн тайлагналын өдрөөр хөрөнгийн үнэ цэнэ буурсан эсэхийг шалгах ба үнэ цэнэ буурсан шинж тэмдэг байгаа бол тухайн хөрөнгийн бодит үнэ цэнийг тооцож, дансны үлдэгдэлтэй харьцуулан, хөрөнгийн бодит үнэ цэнээс хэтэрсэн дансны үлдэгдлээр эрсдэлийн сан байгуулна. Эрсдэлийн сангийн зардлыг буцаах нөхцөл хангагдсан үед эрсдэлийн сангийн зардлын буцаалтыг анх бүртгэсэн эрсдэлийн сангийн зардлаас хэтрүүлэлгүйгээр бүртгэнэ. Үнэ цэнийн бууралтыг тооцох СТОУС-д нийцэх аргачлалыг компани дотооддоо боловсруулж, мөрдөж болно.

Г. БҮРТГЭЛ

Бусад авлага

Бусад авлага үүсэх үед

Дебит: Бусад авлага

Кредит: Холбогдох данс

Бусад авлага төлөгдсөн үед

Дебит: Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

Кредит: Бусад авлага

Бусад авлагад авлагын ангилал бууруулахад

Дебит: Хугацаа хэтэрсэн бусад авалга

Кредит: Бусад авлага /хэвийн/

Бусад авлагад эрсдэлийн сан нэмж байгуулахад

Дебит: Эрсдэлийн сангийн зардал

Кредит: Бусад авлагын эрсдэлийн сан

Бусад авлагад эрсдэлийн сан бууруулахад

Дебит: Бусад авлагын эрсдэлийн сан

Кредит: Эрсдэлийн сангийн зардал

Бусад авлагыг төлүүлж чадахгүй данснаас хасах үед

Дебит: Бусад авлагын эрсдэлийн сан

Кредит: Бусад авлага

Данснаас хассан бусад авлага төлөгдсөн бол

Дебит: Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

Кредит: Бусад орлого - Эрсдэлийн сангаас хаагдсан авлагын эргэн төлөлт

Санхүүгийн түрээс

Түрээсийн гэрээгээр хөрөнгө (мөнгө) шилжүүлэх үед:

Дебит: Санхүүгийн түрээсийн авлага

Кредит: Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө эсвэл Үндсэн хөрөнгө

Санхүүгийн түрээсийн хүүг хуримтлуулан тооцох үед:

Дебит: Санхүүгийн түрээсийн хүүний авлага

Кредит: Хөрөнгө оруулалтын хүүний орлого

Түрээс, хүүний төлбөрийг авах үед:

Дебит: Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

Кредит: Санхүүгийн түрээсийн хүүний авлага

Кредит: Санхүүгийн түрээсийн авлага

Салбар хоорондын тооцоо

Салбар хоорондын тооцоогоор үүссэн өглөг, авлагыг салбар нэгж бүр дээр нэрийн данс нээж бүртгэнэ. Салбар хоорондын тооцоо нь зөвхөн даатгалын байгууллагын төвөөр дамжиж хийгдэнэ.

Салбар хоорондоо тооцоо шилжүүлсэн бол Төв компани

Дебит: Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

Кредит: Салбар хоорондын тооцоо өглөг /шилжүүлэгч салбар/

Дебит: Салбар хоорондын тооцоо авлага /хүлээн авагч салбар/

Кредит: Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

Татвар, НДШ-ийг урьдчилж төлөхөд

Дебит: Татвар, НДШ-ийн авлага

Кредит: Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

Татвар, НДШ-ийг тайлагнах үед

Дебит: Холбогдох данс

Кредит: Татвар, НДШ-ийн авлага

Бараа материал

Бараа материал, хангамжийн зүйлс худалдаж авахад

Дебит: Бараа материал

Кредит: Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

Бараа материал, хангамжийн зүйлийг зарцуулах үед

Дебит: Зардлын холбогдох данс

Кредит: Бараа материал

Урьдчилж төлсөн зардал/тооцоо

Урьдчилж төлсөн зардал/тооцоо үүсэх үед

Дебит: Урьдчилж төлсөн зардал/тооцоо

Кредит: Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

Урьдчилж төлсөн зардал/тооцооноос илүү зарцуулсан бол

Дебит: Урьдчилж төлсөн зардал/тооцоо

Кредит: Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

Урьдчилж төлсөн зардал/тооцооноос дутуу зарцуулсан бол

Дебит: Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

Кредит: Урьдчилж төлсөн зардал/тооцоо

Урьдчилж төлсөн зардал/тооцоо хаахад

Дебит: Холбогдох данс

Кредит: Урьдчилж төлсөн зардал/тооцоо

Өмчлөх бусад хөрөнгө

Өмчлөх бусад хөрөнгийг анх бүртгэхдээ

Дебит: Өмчлөх бусад хөрөнгө

Кредит: Холбогдох данс

Өмчлөх бусад хөрөнгийг ангилал бууруулахад

Дебит: Хугацаа хэтэрсэн өмчлөх бусад хөрөнгө

Кредит: Өмчлөх бусад хөрөнгө /хэвийн/

Өмчлөх бусад хөрөнгөнд эрсдэлийн санг байгуулахад

Дебит: Өмчлөх бусад хөрөнгийн эрсдэлийн сангийн зардал

Кредит: Өмчлөх бусад хөрөнгийн эрсдэлийн сан

Өмчлөх бусад хөрөнгийг борлуулах, засварлах, хадгалах, хамгаалахтай холбогдон гарах урсгал зардлыг бүртгэхэд

Дебит: Холбогдох зардал

Кредит: Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө/тооцоо

Өмчлөх бусад хөрөнгийг худалдсан бол

Дебит: Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

Дебит: Өмчлөх бусад санхүүгийн хөрөнгийн эрсдэлийн сан

Кредит: Өмчлөх бусад хөрөнгө

Өмчлөх бусад хөрөнгийг олзтой худалдсан үед дансны үнээс хэтэрсэн зөрүүг дараах байдлаар бүртгэнэ

Кредит: Бусад орлого – Хөрөнгө борлуулсны олз

Өмчлөх бусад хөрөнгийг гарзтай худалдсан үед дансны үнийн хэтэрсэн зөрүүг дараах байдлаар бүртгэнэ

Дебит: Бусад зардал - Хөрөнгө борлуулсны гарз

Худалдсан өмчлөх бусад хөрөнгийн эрсдэлийн санг буцаана

Дебит: Өмчлөх бусад хөрөнгийн эрсдэлийн сан

Кредит: Өмчлөх бусад хөрөнгийн эрсдэлийн сангийн зардал эсвэл Бусад орлого

Өмчлөх бусад хөрөнгийг борлуулах боломжгүй бол холбогдох журамд заасны дагуу компанийн удирдлагын шийдвэрээр данснаас хасна. Уг шийдвэрт үндэслэн дараах байдлаар бүртгэнэ:

Дебит: Өмчлөх бусад хөрөнгийн эрсдэлийн сан

Кредит: Өмчлөх бусад хөрөнгө

Д. ТОДРУУЛГА

Бусад авлага, урьдчилгаа тооцоотой холбогдуулан дараах зүйлсийг тодруулна:

- Бусад авлагын үлдэгдлийг авлагын ангилал болон насжилтыг харуулсан тайлан
- Бусад авлагын эрсдэлийн сангийн өөрчлөлтийн тайлан (эхний үлдэгдэл, нэмэгдсэн, хасагдсан, эцсийн үлдэгдэл)
- Холбоотой талаас авах бусад авлага
- Бусад авлагын үлдэгдэлд гарсан өөрчлөлтийг тайлбарын хамт тодруулна.
- Бусад авлагад эрсдэлийн сан байгуулсан аргыг тодруулна.

Бараа материал, хангамжийн зүйлтэй холбогдуулан дараах зүйлсийг тодруулж болно:

- Хөрөнгийн үнэ цэнийн бууралт
- Материал үнэ бүхий зүйлсийг данснаас хасахад үүссэн олз, гарз
- Өмчлөх бусад хөрөнгийн хувьд хөрөнгийн үлдэгдэл, тайлант хугацаанд бүртгэсэн өмчлөх бусад хөрөнгийн дүн, данснаас хассан хөрөнгийн дүн, тайлант хугацаанд худалдан борлуулсан өмчлөх бусад хөрөнгийн дүн, уг арилжаанаас үүссэн олз, гарзыг гаргаж өгнө
- Санхүүгийн тайлангийн тодруулгад багтах бусад тодруулгыг санхүүгийн тайлан, тодруулга бэлтгэх аргачлал (Хавсралт 4)-д заасан. Даатгалын байгууллага иж бүрэн, үнэн зөв тодруулга бэлтгэхийн тулд энэ зааврын Хавсралт 4-өөс гадна энэ зааварт багтсан санхүүгийн хэрэглүүрүүдэд хамаарах бусад стандарт, СТОУС 7-г дагаж мөрдөнө.

Е. ХЯНАЛТ

- Ажилтнуудын ажил үүргийг зааглан тусгаарлана.
- Авлага, урьдчилгааг тооцоо үүссэн субъект бүрээр, бараа материал үнэ бүхий зүйлийг нэр төрлөөр нь дэлгэрэнгүй бүртгэл хөтөлнө.
- Дэлгэрэнгүй бүртгэлийг дансны гүйлгээ, үлдэгдэлтэй тохируулна.
- Салбар хоорондын тооцоог төв, салбарын хооронд байнга нийлүүлж тохируулна.
- Санхүүгийн тайланд салбар хоорондын тооцоог цэвэршүүлж үзүүлнэ.
- Гүйлгээний баримтын бүрдлийг хангана.
- Авлага, урьдчилгааг тайлангийн үеийн эцэст холбогдох талтай тулган баталгаажуулна.
- Орлого, зарцуулалтын баримтын бүрдлийг хангана.
- Ажилтнуудын ажил, үүргийг зааглан тусгаарлана.
- Хөрөнгийн нэр, төрлөөр дэлгэрэнгүй бүртгэл хөтөлнө.
- Гүйлгээний баримтын бүрдлийг хангана.
- Нөхөн төлбөрийн зөрүүнд авсан өмчлөх бусад хөрөнгийн үнэлгээг зах зээлийн үнэлгээтэй уялдуулан бодитойгоор тогтооно.

3.4. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

3.4.1 ХАДГАЛАМЖ, ХАДГАЛАМЖИЙН СЕРТИФИКАТ

А. ШУУД ХОЛБОГДОХ СТАНДАРТУУД

- СТОУС 7 Санхүүгийн хэрэглүүр: Тодруулга
- СТОУС 9 Санхүүгийн хэрэглүүр
- СТОУС 13 Бодит үнэ цэнийн хэмжилт
- НББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулга
- НББОУС 32 Санхүүгийн хэрэглүүр: Толилуулга
- НББОУС 36 Хөрөнгийн үнэ цэнийн бууралт
- НББОУС 39 Санхүүгийн хэрэглүүр: Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт

Б. ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨЛТ

Хадгаламж, хадгаламжийн сертификат /3 сараас дээш/-ыг эзэмшиж, захиран зарцуулах эрх даатгалын байгууллагад үүссэн нөхцөлд хүлээн зөвшөөрнө.

В. ХЭМЖИЛТ БА ҮНЭЛГЭЭ

Хадгаламж, хадгаламжийн сертификатыг анх удаа хүлээн зөвшөөрөхдөө бодит үнэ цэнээр бүртгэнэ. Бодит үнэ цэнэ нь гэрээний дагуу байршуулсан хөрөнгийн дүнтэй тэнцүү байна. Хадгаламж, хадгаламжийн сертификатын хөнгөлөлт урамшууллыг үр ашигт хүүгийн аргаар тооцно. Санхүүгийн тайланд хадгаламж, хадгаламжийн сертификатыг тайлагналын өдөр хорогдуулсан өртгөөр үнэлж, тайлагнана. Хадгаламж, хадгаламжийн сертификатын хорогдуулсан өртөг нь анх хүлээн зөвшөөрч хэмжсэн дүнг (бодит үнэ цэнэ)-ээс тайлант хугацаанд нэмэгдсэн хадгаламж, хадгаламжийн сертификатын орлого, тайлант хугацаанд хийгдсэн зарлагын гүйлгээ, холбогдох шимтгэлийг хасч, түүний үлдэгдэлд тооцсон хүүний авлагыг нэмж тодорхойлно. Хүүний авлагыг гэрээнд заасан хувиар тооцоолж, хуримтлуулан бүртгэнэ. Гадаад валютаар байршуулсан хөрөнгийг Монголбанкнаас зарласан албан ханшаар тооцож төгрөгт хөрвүүлэн, төгрөг, гадаад валютаар давхар бүртгэх ба ханшийн хэлбэлзлээс үүсэх орлого, зардлыг гадаад валютын ханшийн тэгшитгэлийн орлого, зардлаар хүлээн зөвшөөрнө.

Г. БҮРТГЭЛ

Дотоод болон гадаадын банк санхүүгийн байгууллагад байршуулсан 3 сараас дээш хугацаатай хадгаламжийн сертификат худалдан авах болон хадгаламжид орлого хийвэл

Дебит: Хадгаламж, хадгаламжийн сертификат

Кредит: Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

Дотоод болон гадаадын банк, санхүүгийн байгууллагад байршуулсан 3 сараас дээш хугацаатай хадгаламж, хадгаламжийн сертификатын хүү тооцож хуримтлуулахад

Дебит: Хадгаламж, хадгаламжийн сертификатын хүүний авлага

Кредит: Хүүний орлого

Хуримтлагдсан хүү төлөгдөхөд

Дебит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

Кредит: Хадгаламж, хадгаламжийн сертификатын хүүний авлага

Дотоод болон гадаад банк, санхүүгийн байгууллагад байршуулсан 3 сараас дээш хугацаатай хадгаламжийн сертификат, хадгаламжийн хугацаа дуусах үед

Дебит: Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

Кредит: Хадгаламж, хадгаламжийн сертификат

Дотоод болон гадаадын банк санхүүгийн байгууллагад байршуулсан 3 сараас дээш хугацаатай хөнгөлөлттэй хадгаламжийн сертификат худалдан авахад

Дебит: Хадгаламжийн сертификат

Кредит: Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

Кредит: Хадгаламжийн сертификатын хөнгөлөлт

Дотоод болон гадаадын банк, санхүүгийн байгууллагад байршуулсан 3 сараас дээш хугацаатай хадгаламжийн сертификатын хөнгөлөлтийг орлогод хүлээн зөвшөөрөхөд

Дебит: Хадгаламжийн сертификатын хөнгөлөлт

Кредит: Хүүний орлого

Дотоод болон гадаад банк, санхүүгийн байгууллагад байршуулсан 3 сараас дээш хугацаатай хадгаламжийн сертификатын хугацаа дуусах үед

Дебит: Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

Кредит: Хадгаламжийн сертификат

Д. ТОДРУУЛГА

Дотоод болон гадаадын банк санхүүгийн байгууллагад байршуулсан 3 сараас дээш хугацаатай хадгаламж, хадгаламжийн сертификатын хувьд дараах зүйлсийг санхүүгийн тайлангийн тодруулгад тусгана.

- Дотоод болон гадаадын банк санхүүгийн байгууллагад байршуулсан 3 сараас дээш хугацаатай хадгаламж, хадгаламжийн сертификатын бүрэлдэхүүн, ангилал
- Дотоод болон гадаадын банк санхүүгийн байгууллагад байршуулсан 3 сараас дээш хугацаатай хадгаламж, хадгаламжийн сертификатын бодит үнэ цэнэ болон хорогдуулсан өртөг
- Дотоод болон гадаадын банк санхүүгийн байгууллагад байршуулсан 3 сараас дээш хугацаатай хадгаламж, хадгаламжийн сертификатын хүү буюу бусад өгөөж
- Даатгалын байгууллагын эзэмшилд байгаа боловч компани өөрөө ашиглах боломжгүй, хязгаарлагдмал хадгаламж, хадгаламжийн сертификат
- Дотоод болон гадаадын банк санхүүгийн байгууллагад байршуулсан 3 сараас дээш хугацаатай хадгаламж, хадгаламжийн сертификатын үлдэгдэлд гарсан өөрчлөлтийг тайлбарын хамт тодруулна.
- СТОУС 7-д заасан бусад тодруулгад холбогдох үнэлгээний аргачлалыг ашиглан тооцсон дотоод болон гадаадын банк санхүүгийн байгууллагад байршуулсан 3 сараас дээш хугацаатай хадгаламж, хадгаламжийн сертификатын үнэ цэнэ бууралтыг тодруулна. Үнэлгээний аргачлалаар үнэ цэнийн бууралтыг тогтоох боломжгүй тохиолдолд хөрөнгийн чанарын талаар тодруулж, тайлбарлаж болно.

Е. ХЯНАЛТ

- Ажилтнуудын ажил үүргийг зааглан тусгаарлана.
- Гүйлгээний баримтын бүрдлийг хангана.
- 3 сараас дээш хугацаатай хадгаламж, хадгаламжийн сертификат тус бүрийн дэлгэрэнгүй бүртгэлийг хөтөлнө.
- Дэлгэрэнгүй бүртгэлийг дансны гүйлгээ, үлдэгдэлтэй тохируулна
- 3 сараас дээш хугацаатай хадгаламж, хадгаламжийн сертификатын бодит үлдэгдэлд гэнэтийн болон тогтмол шалгалт хийнэ.

3.4.2 ҮНЭТ ЦААС

А. ШУУД ХОЛБОГДОХ СТАНДАРТУУД

- СТОУС 7 Санхүүгийн хэрэглүүр: Тодруулга
- СТОУС 9 Санхүүгийн хэрэглүүр
- СТОУС 13 Бодит үнэ цэнийн хэмжилт
- НББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулга
- НББОУС 32 Санхүүгийн хэрэглүүр: Толилуулга
- НББОУС 36 Хөрөнгийн үнэ цэнийн бууралт
- НББОУС 39 Санхүүгийн хэрэглүүр: Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт

Б. ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨЛТ

Үнэт цаасыг эзэмших эрх үүссэн болон гэрээний нэг тал болсон үед санхүүгийн тайландаа хүлээн зөвшөөрч бүртгэнэ. Даатгалын байгууллага бодитой нотолгоо бүрдүүлсний үндсэн дээр үнэт цаасыг тохирох ангиллаар ангилж бүртгэнэ. Тухайлбал, хугацааны эцэс хүртэл эзэмших үнэт цаасны хувьд хугацааг нь дуустал эзэмших нотолгоо, арилжааны үнэт цаасны хувьд богино хугацаанд эзэмшиж, ашиг олох нотолгоо баримт гэх мэт. Үнэт цаасны хугацаа дуусч, үнэт цаас гаргагч төлбөрөө бүрэн төлсөн эсвэл үнэт цаасанд хамаарах бүх эрсдэл, өгөөж бусдад шилжсэн үед хөрөнгө оруулалтыг

данснаас хасна. Даатгалын компани санхүүгийн хөрөнгийг шилжүүлсэн нөхцөлд тухайн санхүүгийн хөрөнгийн өмчлөлтэй холбоотойгоор үлдсэн эрсдэл, өгөөжийг харгалзан хөрөнгийн үнэлгээг хийнэ.

Энэ тохиолдолд хэрэв компани санхүүгийн хөрөнгийн өмчлөлтэй холбоотой бүх эрсдэл, өгөөжийг бүрэн шилжүүлээгүй бол уг санхүүгийн хөрөнгийн зарим хэсгийг өөртөө үлдээж, үлдсэн хэсгийг нь данснаас хасч бүртгэнэ. Өөрт үлдээх хэсгийг дараах байдлаар тогтооно:

1. Хэрэв компанийн хяналтыг өөртөө үлдээгээгүй бол уг санхүүгийн хөрөнгийг данснаас хасна.
2. Хэрэв компани хяналтыг өөртөө үлдээсэн бол уг санхүүгийн хөрөнгөөс хяналтын хувь хэмжээгээр тооцоолсон өөрт харгалзах хэсгийг бүртгэлдээ үлдээнэ.

Ногдол ашиг авах эрх компанид үүсч, авах магадлалтай гэж үзвэл ногдол ашгийн орлогод бүртгэнэ.

В. ХЭМЖИЛТ БА ҮНЭЛГЭЭ

Үнэт цаасны үнэлгээ нь түүний ангиллаас шалтгаалах тул эхлээд үнэт цаасны ангиллыг тодорхойлно. Үнэт цаасыг дөрвөн ангиллын аль нэгээр ангилж, бүртгэнэ. Санхүүгийн хөрөнгийг анхны удаад хүлээн зөвшөөрсний дараа түүний ангиллаас шалтгаалан тайлагналын өдрөөр хийгдэх үнэлгээ, холбогдох орлого, зардлыг хэрхэн бүртгэх нь хамаарна. Үнэт цаасны бодит үнэ цэн гэж тухайн өдрийн идэвхтэй зах зээлийн жишиг үнийг ойлгоно. Өөрөөр хэлбэл, олон улсын болон дотоодын зах зээл дээр идэвхтэй арилжаалж буй үнэт цаасны үнэ нь бодит үнэ цэн юм. Хэрэв үнэт цаасны зах зээл идэвхтэй биш бол үнэлгээний аргыг ашиглан бодит үнэ цэнийг тогтооно. Тухайлбал, дискаунтчилсан мөнгөн гүйлгээний шинжилгээ, опционы үнийн загвар гэх мэт тухайн төрлийн үнэт цаасанд түгээмэл ашиглагддаг аргачлалыг сонгон бодит үнэ цэнийг тодорхойлно. Компани үнэт цаасны бодит үнэ цэнийг тооцоолох аргачлалаа өөрийн дотоод журмаар тогтоож, мөрдөнө.

1. Арилжааны үнэт цаас буюу Ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр илэрхийлэх үнэт цаас

Арилжааны үнэт цаас буюу ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр илэрхийлэх үнэт цаасыг анх хүлээн зөвшөөрөхдөө бодит үнэ цэнээр үнэлнэ. Энэ нь тухайн үнэт цаасыг худалдан авахад төлсөн мөнгөн дүн юм.

Энэ ангиллын үнэт цаасыг тайлагналын өдөр бодит үнэ цэнээр нь дахин үнэлэх ба бодит үнэ цэнд гарсан өсөлт, бууралтыг хөрөнгө оруулалтын үнэлгээний олз, гарзад бүртгэнэ. Үр ашигт хүүгийн аргыг ашиглан арилжааны үнэт цааснаас тооцсон хүүг тухайн тайлант хугацааны орлогоор хүлээн зөвшөөрнө.

Энэ ангиллын хөрөнгийг данснаас хасах үед үүсэх хөрөнгө оруулалт борлуулсны олз, гарз болон хөрөнгийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийг тухайн тайлант хугацааны хөрөнгө оруулалтын үнэлгээний олз, гарзад бүртгэнэ.

Энэ бүлгийн бүртгэлийн хэсэгт заасны дагуу хөрөнгө оруулалтын үнэлгээний олз, гарзыг хөрөнгө оруулалт борлуулсны олз, гарзаас салгаж бүртгэнэ.

Компанийн удирдлагын шийдвэрт үндэслэн арилжааны үнэт цаасны зориулалтыг өөрчилж, бусад ангилалд шилжүүлж болох бөгөөд арилжааны үнэт цаасыг тухайн өдрийн бодит үнэ цэнээр үнэлж, бүртгэнэ. Өмнө нь хүлээн зөвшөөрч бүртгэсэн орлого, зардлыг хуримтлуулах буюу буцаах бичилт хийхгүй.

Үнэт цаасыг арилжааны үнэт цааснаас бусад ангилалд шилжүүлэн, өөрчлөх тохиолдолд дараах зарчмыг баримтална:

- Хэрэв үнэт цаасны ангиллыг өөрчлөх гэж буй өдөр уг үнэт цаас зээл ба авлагын тодорхойлолтод нийцэж байгаа бөгөөд компани тухайн өдөр уг хөрөнгийг ойрын хугацаанд худалдахгүй эсвэл уг үнэт цаасыг хугацааны эцэс хүртэл эзэмших зорилготой байгаа бол зээл ба авлага ангиллын үнэт цаасаар бүртгэнэ.
- Үнэт цаасыг арилжаалдаг зах зээл идэвхтэй эсвэл уг үнэт цаас нь зээл ба авлага болохгүй хөрөнгийн багцад багтдаг тохиолдолд компани уг үнэт цаасыг зээл ба авлагаар ангилахгүй.
- Зээл, авлагын тодорхойлолтод нийцэхгүй бусад санхүүгийн хөрөнгийн хувьд ойрын хугацаанд худалдах зорилгоор эзэмшээгүй нөхцөлд хугацааны эцэс хүртэл эзэмших үнэт цаасаар ангилна.

2. Хугацааны эцэс хүртэл эзэмших үнэт цаас

Хугацааны эцэс хүртэл эзэмшихээр ангилсан үнэт цаасыг анх хүлээн зөвшөөрөхдөө бодит үнэ цэн дээр холбогдох шууд зардлыг нэмсэн дүнгээр бүртгэнэ.

Хугацааны эцэс хүртэл эзэмших үнэт цаасыг санхүүгийн тайланд хорогдуулсан өртгөөр үнэлж, толилуулна.

Үнэт цаасны хорогдуулсан өртгийг тооцохдоо анх хүлээн зөвшөөрсөн үнээс үндсэн төлбөрийн төлөлтийг хасч, үр ашигт хүүний аргаар тооцоолсон урамшууллын хорогдуулалтыг хасах эсвэл хөнгөлөлтийн хорогдуулалтыг нэмнэ. Үнэт цаасны хорогдуулсан өртөгт уг үнэт цаасанд хуримтлуулан тооцсон хүүний авлага мөн багтана.

Үр ашигт хүүний аргаар үнэт цаасны урамшуулал, хөнгөлөлтийн хорогдуулалтыг тооцоолохдоо анхны үнээс тооцсон үр ашигт хүүгээс хүүний төлбөрийг хасна. Урамшуулал, хөнгөлөлтөөс тайлант хугацаанд ногдох хорогдуулсан дүнг хүүний орлогод бүртгэнэ.

Хугацааны эцэс хүртэл эзэмшихээр ангилсан үнэт цаасны ангиллыг борлуулахад бэлэн ангилалд шилжүүлж болно. Ийнхүү ангиллыг өөрчлөх болон хугацааны эцэс хүртэл эзэмших үнэт цаасыг хугацаанаас нь өмнө худалдах үед компанийн удирдлагын зорилго болон багцын бүтцийг өөрчлөх болдог. Иймд хугацааны эцэс хүртэл эзэмших хөрөнгө оруулалтыг мэдэгдэхүйц их дүнгээр худалдан борлуулах эсвэл ангиллыг нь өөрчлөх үед хугацааны эцэс хүртэл эзэмших хөрөнгө оруулалтын дансанд үлдсэн бусад үнэт цаасны ангиллыг өөрчилж, борлуулахад бэлэн ангилалд шилжүүлнэ. Энэ тохиолдолд үнэт цаасыг бодит үнэ цэнээр нь үнэлж, үүссэн үнэлгээний зөрүүг бусад дэлгэрэнгүй орлогод бүртгэнэ.

Тайлант хугацааны эцэст СТОУС-ын дагуу үнэ цэнийн бууралтыг тооцож бүртгэнэ. СТОУС-ын дагуу үнэ цэнийн бууралтыг хэмжихдээ санхүүгийн тайлагналын өдрөөр хөрөнгийн үнэ цэн буурсан эсэхийг шалгах ба үнэ цэн буурсан шинж тэмдэг байгаа бол тухайн хөрөнгийн бодит үнэ цэнийг тооцож, дансны үлдэгдэлтэй харьцуулан, хөрөнгийн бодит үнэ цэнээс хэтэрсэн дансны үлдэгдлээр эрсдэлийн сан байгуулна. Эрсдэлийн сангийн зардлыг буцаах нөхцөл хангагдсан үед эрсдэлийн сангийн зардлын буцаалтыг анх бүртгэсэн эрсдэлийн сангийн зардлаас хэтрүүлэлгүйгээр бүртгэнэ. Үнэ цэнийн бууралтыг тооцох СТОУС-д нийцэх аргачлалыг компани дотооддоо боловсруулж, мөрдөж болно.

3.Зээл ба авлага гэж ангилсан үнэт цаас

Зээл ба авлагаар ангилсан үнэт цаасны үнэлгээ, бүртгэл нь хугацааны эцэс хүртэл эзэмших үнэт цаастай адил хорогдуулсан өртгийн аргаар бүртгэнэ. НББОУС 39-ийн дагуу энэ ангиллын үнэт цаасыг анхны удаад бодит үнэ цэн дээр тухайн үнэт цаасыг худалдан авахтай шууд холбоотой арилжааны шимтгэлийг нэмсэн дүнгээр буюу үнэт цаасыг олж авахын тулд төлсөн зардлыг хасч цэвэр дүнгээр хүлээн зөвшөөрч, бүртгэнэ. Ийм үнэт цаасыг тайлагналын өдөр хорогдуулсан өртгөөр үнэлнэ.

Компани зээл ба авлагын тодорхойлолтыг хангаж буй үнэт цаасыг анх авах үедээ борлуулахад бэлэн гэж ангилж болох боловч зээл, авлага гэж ангилсан үнэт цаасыг борлуулахад бэлэн үнэт цаасны ангиллаас бусад ангилалд шилжүүлэн бүртгэж болохгүй.

Үнэт цаасыг зээл ба авлагаар ангилж, бүртгэсний дараа уг үнэт цаасны зах зээлийн жишиг үнийг тодорхойлох боломжтой болж, улмаар зээл ба авлагын тодорхойлолтыг хангахгүй болсон тохиолдолд компани уг хөрөнгийн ангиллыг өөрчлөх эсвэл хэвээр үлдээх эсэхээ өөрөө сонгож, шийдвэрлэх ба сонгосон бодлогоо тууштай мөрдөнө. Хэрэв компани өөрийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримтдаа ангиллыг өөрчилнө гэж заасан бол идэвхтэй зах зээлийн жишиг үнэтэй болсон үед бүх зээл ба авлагыг борлуулахад бэлэн үнэт цаасны ангиллаар ангилна.

4.Борлуулахад бэлэн үнэт цаас

Борлуулахад бэлэн үнэт цаасыг анх хүлээн зөвшөөрөхдөө бодит үнэ цэн дээр холбогдох шууд зардлыг нэмсэн дүнгээр бүртгэнэ. Энэ нь үнэт цаасыг худалдан авахад төлсөн цэвэр дүнгээр илэрхийлэгддэг.

Санхүүгийн тайланд борлуулахад бэлэн үнэт цаасыг бодит үнэ цэнээр нь үнэлж, толилуулах ба бодит үнэ цэнэд гарсан өсөлт, бууралтыг үнэт цаасны дахин үнэлгээний нэмэгдэл дансанд

хуримтлуулна. Үнэт цаасыг бусдад худалдах буюу шилжүүлэн данснаас хасах үед дахин үнэлгээний санг тайлант үеийн орлого, зардалд шилжүүлэн бүртгэнэ.

Үнэт цаасны зах зээлийн үнийг ашиглан бодит үнэ цэнийг тодорхойлох ба харин жишиг үнэ байхгүй тохиолдолд үнэлгээний аргачлалыг ашиглан бодит үнэ цэнийг тодорхойлно.

Борлуулахад бэлэн үнэт цаасны бодит үнэ цэнийг хэмжих боломжгүй тохиолдолд өртгөөр нь бүртгэнэ. Гэхдээ энэ заалт нь зөвхөн жишиг үнэгүй өмчийн хэрэглүүрт хамаарна.

Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнийн өөрчлөлтөөс үүссэн үнэлгээний орлого, зардлыг доорхоос бусад тохиолдолд олз, гарзаар бүртгэнэ:

- Үр ашигт хүүний аргаар тооцоолсон хүүг орлого, зардалд бүртгэнэ. НББОУС 18-д заасны дагуу борлуулахад бэлэн өмчийн хэрэглүүрийн ногдол ашгийг авах эрх Даатгалын компанид үүссэн өдөр тайлант хугацааны холбогдох орлогод бүртгэнэ.
- Мөнгөн хэлбэртэй санхүүгийн хөрөнгийн ханшийн тэгшитгэлийн орлого, зардлыг тайлант хугацааны орлого, зардалд бүртгэнэ.
- Эрсдэлийн сангийн зардлыг тайлант хугацааны зардалд бүртгэнэ. Өрийн хэрэгслийн эрсдэлийн сангийн зардлын буцаалтыг орлого, зардлын дансанд бүртгэх боловч өмчийн хэрэглүүрийн эрсдэлийн сангийн зардлын буцаалтыг доор тайлбарласан байдлаар бүртгэнэ.

Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнийн өсөлт, бууралтын тохируулгыг өөрийн хөрөнгийн "Үнэт цаасны дахин үнэлгээний нэмэгдэл" дансанд бүртгэж, бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрнө. Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг үнэн зөв тооцоолж гаргахын тулд санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийг тухайн өдрөөрх хорогдуулсан өртөгтэй нь харьцуулна. Энэ тооцоололд хуримтлуулан тооцсон хүүний авлагын дүнг оруулахгүй. Ийм төрлийн санхүүгийн хэрэглүүрийг санхүүгийн тайланд бодит үнэ цэнээр бүртгэж, харуулах боловч хүлээн зөвшөөрөх хүүний орлогын дүнг гаргах зорилгоор уг хэрэгслийн хорогдуулсан өртгийг үр ашигт хүүний аргаар тооцно.

Санхүүгийн хөрөнгийг данснаас хасах үед уг хөрөнгөтэй холбоотойгоор хуримтлуулж, дахин үнэлгээний нэмэгдэлд бүртгэсэн дүнг тайлант хугацааны орлого, зардалд шилжүүлэн бүртгэж, тохируулна.

Тайлант хугацааны эцэст СТОУС-ын дагуу үнэ цэнийн бууралтыг тооцож бүртгэнэ. СТОУС-ын дагуу үнэ цэнийн бууралтыг хэмжихдээ санхүүгийн тайлагналын өдрөөр хөрөнгийн үнэ цэн буурсан эсэхийг шалгах ба үнэ цэн буурсан шинж тэмдэг байгаа бол тухайн хөрөнгийн бодит үнэ цэнийг тооцож, дансны үлдэгдэлтэй харьцуулан, хөрөнгийн бодит үнэ цэнээс хэтэрсэн дансны үлдэгдлээр эрсдэлийн сан байгуулна. Эрсдэлийн сангийн зардлыг буцаах нөхцөл хангагдсан үед эрсдэлийн сангийн зардлын буцаалтыг анх бүртгэсэн эрсдэлийн сангийн зардлаас хэтрүүлэлгүйгээр бүртгэнэ. Үнэ цэнийн бууралтыг тооцох СТОУС-д нийцэх аргачлалыг компани дотооддоо боловсруулж, мөрдөж болно.

Байнгын зөрүүг дараа үеүүдэд буцаахгүй бөгөөд энэ нь тухайн тайлант үеийн татварын зардлыг тооцоолох үед залруулагдана. Иймд тайлант үеийн татварын зардал нь байнгын зөрүүг залруулж тодорхойлсон ашгийг татварын хувь хэмжээгээр үржүүлээд гарсан дүнтэй тэнцүү байна. Байнгын зөрүү нь тохируулагдахгүй зөрүү тул үүнийг хойшлуулан бүртгэхгүй, тайлант үеийн татварын зардалд хамруулна. Байнгын зөрүүг татварын хөрөнгө буюу өр төлбөрөөр бүртгэхгүй.

2. Түр зөрүү

Түр зөрүү нь орлогө, зардлыг орлогын тайлан ба татварын тайланд хүлээн зөвшөөрөх цаг хугацааны ялгаанаас үүсэх тул үүнийг хойшлуулан бүртгэнэ.

Түр зөрүү нь татвар ногдуулах орлогоос ирээдүйд хасагдах зардал, ирээдүйд татвар ногдуулах орлого зэргээс шалтгаалан үүснэ. Түр зөрүү нь тодорхой хугацааны дараа нөхөгдөж үлдэгдэлгүй болно.

Түр зөрүү = Хөрөнгө, өглөгийн дансны үнэ - Хөрөнгө, өглөгийн татварын суурь
Хойшлогдсон татварын хөрөнгө, өглөг = Түр зөрүү * Татварын хувь (%)

Хойшлогдсон татварын хөрөнгө, өглөгийг тооцохдоо хүчин төгөлдөр үйлчилж буй татварын хувь хэмжээг ашиглана. Тайлант хугацааны эцэст хойшлогдсон татварын өглөг ба хойшлогдсон татварын хөрөнгийн хэмжилт нь хөрөнгө, өр төлбөрийн дансны үнийг нөхөх буюу барагдуулах арга хэлбэрээс үүсэж байгаа татварын үр нөлөөг хойшлогдсон татварын хөрөнгийн дүнд тусгана. Хойшлогдсон татварын хөрөнгө, өглөгийг дискаунтчилж өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэхгүй.

Г. БҮРТГЭЛ

ААНОАТатварыг урьдчилж төлөхөд татварын авлагад бүртгэх үед.

Дебит: ААНОАТатварын авлага

Кредит: Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

Татварын хувь хэмжээгээр тооцоолсон тайлант хугацаанд хамаарах татварыг ААНОАТ-ын өглөгт бүртгэх үед.

Дебит: ААНОАТатварын зардал

Кредит: ААНОАТатварын өглөг

Татварын авлага, өглөгийг хааж цэвэршүүлсэн бол

Дебит: ААНОАТатварын өглөг

Кредит: ААНОАТатварын авлага

Татварын түр зөрүүгийн нөлөөгөөр хойшлогдсон татварын хөрөнгө үүсэх үед

Дебит: Хойшлогдсон татварын хөрөнгө

Кредит: Хойшлогдсон татварын зардал/орлого/

Хойшлогдсон татварын хөрөнгийг бууруулж тохируулах үед

Дебит: Хойшлогдсон татварын зардал/орлого/

Кредит: Хойшлогдсон татварын хөрөнгө

Татварын түр зөрүүгийн нөлөөгөөр хойшлогдсон татварын өглөг үүсэх үед

Дебит: Хойшлогдсон татварын зардал/орлого/

Кредит: Хойшлогдсон татварын өглөг

Хойшлогдсон татварын өглөгийг татварын зөрүүгээр бууруулж тохируулах үед

Дебит: Хойшлогдсон татварын өглөг

Кредит: Хойшлогдсон татварын зардал/орлого/

Алдагдлыг ирээдүйд шилжүүлэн хойшлогдсон татварын хөрөнгийг бүртгэх үед

Дебит: Хойшлогдсон татварын хөрөнгө

Кредит: Хойшлогдсон татварын зардал/орлого/

Хойшлогдсон татварын хөрөнгийг ААНОАТатвараас суутган тооцох үед

Дебит: Хойшлогдсон татварын зардал/орлого/

Кредит: Хойшлогдсон татварын хөрөнгө

Д. ТОДРУУЛГА

Хойшлогдсон татварын хөрөнгө болон хойшлогдсон татварын өр төлбөрийг санхүүгийн тайланд нэгтгэсэн цэвэр дүнгээр толилуулна.

НББОУС 12-д заасан дараах дэлгэрэнгүй тодруулгыг тусад нь харуулна:

- Татварын зардлыг бүрдүүлж буй гол элементүүдийг тусад нь тодруулна
- Тайлант үеийн татварын зардал (орлого)
- Өмнөх тайлант хугацааны татварт хамаарах боловч энэ тайлант хугацаанд хийгдсэн тохируулга
- Хойшлогдсон татварын дансыг хаах болон өмнө хаасан дансыг буцаах үед үүссэн хойшлогдсон татварын зардал буюу түр зөрүүг үүсгэх ба буцаахтай холбоотой хойшлогдсон татварын зардлын дүн
- Тайлант үеийн татварын зардлыг бууруулахад ашиглагдах, өмнөх хугацааны бүртгээгүй татварын алдагдал, татварын хөнгөлөлт, түр зөрүүнээс үүссэн өгөөжийн дүн
- Өмнө нь хүлээн зөвшөөрсөн татварын алдагдал, татварын хөнгөлөлт, хойшлогдсон татварын зардлыг бууруулахад ашиглагдах өмнөх хугацааны түр зөрүүнээс үүссэн өгөөжийн дүн
- Өөрийн хөрөнгөнд шууд бүртгэсэн буюу кредитлэсэн зүйлстэй холбоотой тайлант үеийн болон хойшлогдсон татварын нийт дүн
- Бусад дэлгэрэнгүй орлогын төрөл тус бүрд харгалзах орлогын албан татварын дүн

5.6. АШИГ, АЛДАГДАЛ

Тайлант жилийн эцэст орлого, зарлагын дансдын үлдэгдлийг орлого, зарлагын нэгдсэн дансанд хааж, үр дүнг тооцон хуримтлагдсан ашиг дансанд хаалтын бичилт хийнэ.

Орлогын дансыг хаах үед:

Дебит: Орлогын дансууд

Кредит: Орлого, зардлын нэгдсэн данс

Зардлын дансыг хаах үед:

Дебит: Орлого, зарлагын нэгдсэн данс

Кредит: Зардлын дансууд

Орлого, зарлагын нэгдсэн дансны зөрүүгээр тайлангийн үеийн ашиг, алдагдлыг тодорхойлж:

Ашигтай бол:

Дебит: Орлого, зарлагын нэгдсэн данс

Кредит: Тайлант үеийн ашиг, алдагдал
Алдагдалтай бол:
Дебит: Тайлант үеийн ашиг, алдагдал
Кредит: Орлого, зарлагын нэгдсэн данс.

5.7. ЗОГСООСОН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Компани үйл ажиллагааныхаа тодорхой хэсгийг хаах эсвэл худалдан борлуулахаар болсон бол зогсоосон үйл ажиллагаа гэж үзнэ.

Зогсоосон үйл ажиллагаатай холбоотой хөрөнгө, өр төлбөрийг үлдээсэн бол үүнийг СТОУС 5-ын шалгуурууд хангагдсан нөхцөлд борлуулах зориулалттай хөрөнгө ба борлуулах өр төлбөрт тус тус бүртгэхээр заасан байдаг. Даатгалын компанийн хувьд ийм хөрөнгө, өр төлбөрийг өмчлөх бусад хөрөнгөн ба бусад санхүүгийн бус өр төлбөрөөр ангилж, бүртгэнэ. /Бүртгэлийг өмчлөх бусад хөрөнгө болон бусад санхүүгийн бус өр төлбөр хэсгээс харна уу/

ЗУРГАА. ТЭНЦЛИЙН ГАДУУРХ ДАНС

Тэнцлийн гадуурх дансууд нь тайлант хугацаанд хүчинтэй байгаа Фронтинг гэрээний даатгалын зүйлийн үнэлгээ болон хураамж, тайлант хугацаанд хүчинтэй байгаа даатгалын гэрээний зүйлийн үнэлгээ болон давхар даатгалтай даатгалын зүйлийн үнэлгээ, даатгалын гэрээ, гэрээт баталгааны тоо болон давхар даатгалд даатгуулсан гэрээ, гэрээт баталгааны тоо, бүрэн сүйрсэн даатгалын хөрөнгө, шүүхээр шийдвэрлэгдээгүй байгаа нөхөн төлбөр, бусдын өмнө өөрийн хөрөнгөөр хариуцсан хариуцлага, барьцаанд авсан хөрөнгө, тэнцлээс хассан хөрөнгө, дериватив болон хадгалж буй үнэ бүхий зүйлийг бүртгэх данс юм.

Тэнцлийн гадуурх бүртгэл нь эхний үлдэгдэл, орлого, зарлага, эцсийн үлдэгдэл гэсэн хэлбэртэй байна. Энэхүү бүртгэл нь тухайн тэнцлийн гадуурх зүйлийн тайлангийн хугацааны хөдлөгөөнийг харуулна.

6.1. ФРОНТИНГ ГЭРЭЭНИЙ ХУРААМЖ БОЛОН ФРОНТИНГ ГЭРЭЭНИЙ ДААТГАЛЫН ЗҮЙЛИЙН ҮНЭЛГЭЭ

А. ХЭМЖИЛТ БА ҮНЭЛГЭЭ

Фронтинг гэрээнд заасан даатгалын зүйлийн үнэлгээний дүн болон хураамжийн дүнгээр бүртгэнэ.

Б. БҮРТГЭЛ

Фронтинг давхар даатгалын гэрээ байгуулагдсан тухай бүрд нь даатгалын зүйлийн үнэлгээ болон хураамжийг тэнцлийн гадуурх дансанд орлогодно. Фронтинг гэрээний хугацаа дууссан, цуцлагдсанаар тэнцлийн гадуурх данснаас зарлагадна.

6.2. ДААТГАЛЫН ГЭРЭЭНИЙ ЗҮЙЛИЙН ҮНЭЛГЭЭ БОЛОН ДАВХАР ДААТГАЛТАЙ ДААТГАЛЫН ЗҮЙЛИЙН ҮНЭЛГЭЭ

А. ХЭМЖИЛТ БА ҮНЭЛГЭЭ

Даатгалын болон давхар даатгалын гэрээнд заасан даатгалын зүйлийн үнэлгээний дүнгээр бүртгэнэ.

Б. БҮРТГЭЛ

Даатгалын болон давхар даатгалын хураамжийг хүлээн зөвшөөрөх үед гэрээнд заасан даатгалын зүйлийн үнэлгээний нийт дүнгээр тэнцлийн гадуурх дансанд орлогодно. Даатгалын болон давхар даатгалын гэрээний хугацаа дууссан, цуцлагдсан болон даатгуулсан хөрөнгө бүрэн сүйрч нөхөн төлбөр олгосон гэх мэт даатгагчийн болон давхар даатгагчийн үүрэг хариуцлага дуусгавар болсон бол тэнцлийн гадуурх данснаас зарлагадна. Харин нөхөн төлбөр авсан буюу даатгагчийн хариуцлага бүрэн хэмжээгээр бус хэсэгчлэн буурсан бол тэнцлийн гадуурх данснаас төлөгдсөн хариуцлагын хэмжээгээр зарлагдаж болно.

6.3. ДААТГАЛЫН ГЭРЭЭНИЙ ТОО, ДАВХАР ДААТГАЛТАЙ ДААТГАЛЫН ГЭРЭЭНИЙ ТОО

А. ХЭМЖИЛТ БА ҮНЭЛГЭЭ

Даатгалын гэрээ болон гэрээт баталгааны тоогоор бүртгэх ба хэрэв нэг даатгалын гэрээнд олон гэрээт баталгаа агуулагдаж байгаа бол зөвхөн даатгалын гэрээт баталгааны тоог бүртгэх бөгөөд тухайн гэрээг бүртгэхгүй.

Б. БҮРТГЭЛ

Даатгалын болон давхар даатгалын хураамжийг хүлээн зөвшөөрөх үед гэрээ болон гэрээт баталгааны тоо ширхэгээр тэнцлийн гадуурх дансанд орлогодно. Даатгалын болон давхар даатгалын гэрээний хугацаа дууссан, цуцлагдсан болон даатгуулсан хөрөнгө бүрэн сүйрч нөхөн төлбөр олгосон гэх мэт даатгагчийн болон давхар даатгагчийн үүрэг хариуцлага дуусгавар болсон бол тэнцлийн гадуурх данснаас зарлагадна.

6.4. БҮРЭН СҮЙРСЭН ДААТГАЛЫН ХӨРӨНГӨ

А. ХЭМЖИЛТ БА ҮНЭЛГЭЭ

Тухайн бүрэн сүйрсэн хөрөнгийг хүлээн авснаар тэнцлийн гадуурх дансанд тоо ширхэгээр орлогд бүртгэнэ.

Б. БҮРТГЭЛ

Даатгалын тохиолдол болж даатгалын зүйл бүрэн сүйрч даатгалын компани даатгуулагчид нөхөн төлбөрийг олгосноор даатгалын компани бүрэн сүйрсэн хөрөнгийг хүлээн авах эрх үүсэх бөгөөд бүрэн сүйрсэн хөрөнгө нь ирээдүйд орлого олох боломжтой бол тэнцлийн гадуурх дансанд тоо ширхэгээр нь орлогодно. Бүрэн сүйрсэн даатгалын хөрөнгийг борлуулсан үед тэнцлийн гадуурх данснаас зарлагадна. Мөн бүрэн сүйрсэн хөрөнгийг борлуулж ирээдүйд орлого олох боломжгүй гэж үзсэн тохиолдолд эрх бүхий албан тушаалтны шийдвэрийг үндэслэн тэнцлийн гадуурх данснаас зарлагадна.

6.5. ШҮҮХЭЭР ШИЙДВЭРЛЭГДЭЭГҮЙ БАЙГАА НӨХӨН ТӨЛБӨР

А. ХЭМЖИЛТ БА ҮНЭЛГЭЭ

Даатгуулагч шүүхэд нэхэмжлэл гаргаж шүүхээс уг нэхэмжлэлийг хүлээн авч хэрэг үүсгэснийг даатгагчид албан ёсоор мэдэгдсэн үед шүүхэд нэхэмжилсэн дүнгээр бүртгэнэ.

Б. БҮРТГЭЛ

Даатгуулагчийн гаргасан нэхэмжлэлийг шүүх хүлээн авч хэрэг үүсгэснийг даатгагчид албан ёсоор мэдэгдэж шүүхийн зарлан дуудах хуудас ирсэн үед тэнцлийн гадуурх дансанд орлогодно.

Тухайн даатгуулагчийн нэхэмжлэл эцэслэн шийдвэрлэгдэснээр тэнцлийн гадуурх данснаас зарлагадна.

6.6. БУСДЫН ӨМНӨ ӨӨРИЙН ХӨРӨНГӨӨР ХАРИУЦСАН ХАРИУЦЛАГА

А. ХЭМЖИЛТ БА ҮНЭЛГЭЭ

Тухайн баталгаа, батлан даалтын гэрээний дүнгээр бүртгэнэ.

Б. БҮРТГЭЛ

Даатгалын компани холбогдох журмын дагуу баталгаа, батлан даалт гаргах үед үндэслэн тэнцлийн гадуурх дансанд орлогдож, баталгаа батлан даалтын хугацаа дууссан болон төлбөр төлөгдөх үед зарлагадна.

Даатгалын компани өөрийн хөрөнгийн тодорхой хэсгийг гэрээний дагуу барьцаа болгосон бол тэнцлийн гадуурх дансанд орлогодно. Барьцааны гэрээний хугацаа нь дууссан болон барьцааны үүргийн биелэлт хангагдсанаар тэнцлийн гадуурх данснаас зарлагадна.

6.7. ТЭНЦЛЭЭС ХАССАН ХӨРӨНГӨ

А. ХЭМЖИЛТ БА ҮНЭЛГЭЭ

Тэнцлээс хассан дүнгээр нь бүртгэнэ.

Б. БҮРТГЭЛ

Хөрөнгийн эргэн төлөгдөх нөхцөл байдлыг үнэлэн холбогдох эрсдэлийн сангаар нь хаасан бол үүнийг тэнцлийн гадуурх "Тэнцлээс хассан хөрөнгө" бүлгийн холбогдох дансанд бүртгэнэ.

Хэрэв тухайн тэнцлээс хассан хөрөнгө нь дараагийн тайлант үед эргэн төлөгдөх нөхцөл байдал бий болсон тохиолдолд даатгалын компаний удирдлага тэдгээрийн нөхөгдөх дүнг дахин үнэлж болно. Энэ тохиолдолд даатгалын компаний удирдлага тэдгээр хөрөнгө нь бүхлээрээ буюу хэсэгчлэн нөхөгдөх боломжтой гэж дүгнэсэн бол тэдгээрийн нөхөгдөх дүнг балансанд эргүүлэн хүлээн зөвшөөрч бүртгэх шийдвэр гаргаж болно. Ийм тохиолдолд харгалзах хөрөнгийг тэнцлийн гадуурх данснаас зарлагдах бөгөөд түүнийг нөхөгдөх дүнгээр нь санхүүгийн байдлын тайлангийн холбогдох дансанд бүртгэнэ.

6.8. ДЕРИВАТИВ

А. ХЭМЖИЛТ БА ҮНЭЛГЭЭ

Даатгалын компани гэрээ, хэлцэлд тал болон оролцож, хэлцэл хүчин төгөлдөр болсноор хэлцлээр үүссэн авлага, өглөгийг хэлцлийн дуусах хугацаа хүртэл тэнцлийн гадуур холбогдох дансанд бүртгэнэ.

Санхүүгийн хэрэгслийн үнэ өөрчлөгдвөл дахин үнэлэх ба гарах үр дүнг орлого, зардлын дансанд бүртгэж, толилуулна.

Б. БҮРТГЭЛ

Деривативын авлага, өглөгийг нийт нэрлэсэн дүнгээр нь ажил гүйлгээ тус бүрт тэнцлийн гадуурх дансанд толилуулна. Холбогдох деривативын бодит үнэ цэнийг санхүүгийн байдлын тайланд дериватив санхүүгийн хөрөнгө, дериватив санхүүгийн өр төлбөр болгон толилуулна. Деривативын бодит үнэ цэнэд гарч буй өөрчлөлтийг орлогын тайланд хүлээн зөвшөөрч бүртгэнэ.

Хөрөнгийг худалдах буюу худалдан авах дериватив гүйлгээ эхэлсэн өдөр даатгалын компани тухайн гүйлгээнээс үүссэн авлага, өглөгийг тэнцлийн гадуурх дансанд орлогодно.

Хэлцлийн хугацаа дуусч хэрэгжихэд эдгээр авлага, өглөгийг тэнцлийн гадуурх данснаас зарлагадна. Үүнтэй зэрэгцээд деривативын бодит үнэ цэнийг санхүүгийн байдлын тайлангаас зарлагадна.

6.9. ХАДГАЛЖ БУЙ ҮНЭ БҮХИЙ ЗҮЙЛ

А. ХЭМЖИЛТ БА ҮНЭЛГЭЭ

Хадгалж буй үнэ бүхий зүйлийг нэрийн данс нээж тоо ширхэгээр бүртгэнэ.

Б. БҮРТГЭЛ

Хадгалж буй үнэ бүхий зүйлийг эзэмшиж эхлэх үед тэнцлийн гадуурх дансанд орлогодно.

Хадгалж буй үнэ бүхий зүйл ажил хэргийн шаардлага хангахгүй болох, алга болох үед шалтгааныг тодорхой бичиж тэнцлийн гадуурх данснаас зарлагадна.

6.10. ТОДРУУЛГА

Тэнцлийн гадуурх дансанд бүртгэлтэй зүйлсийг нэр төрлөөр нь ангилж санхүүгийн тайланд тодруулна.

6.11. ХЯНАЛТ

- Үүрэг хүлээж болзошгүй үйл ажиллагааг эрх бүхий удирдлагын зөвшөөрлөөр хийсэн эсэх.
- Гүйлгээний баримтанд компанийн холбогдох ажилтан, албан тушаалтнууд гарын үсэг зурж баталгаажуулна.
- Батлан даалт гаргагч болон гаргуулагчийн харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг нарийвчлан заасан эсэх.
- Дансдын үлдэгдлийг байнга тохируулж байх.

ДОЛОО. УРТ ХУГАЦААНЫ ДААТГАЛЫН КОМПАНИЙН БҮРТГЭЛИЙН ЗААВАР

7.1. ЕРӨНХИЙ ЗАРЧИМ

Урт хугацааны даатгалын компанийн нягтлан бодох бүртгэлд дараах зарчмуудыг баримтална.

1. Урт хугацааны даатгалын компани нь нягтлан бодох бүртгэлдээ (мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө, хөрөнгө оруулалт, эздийн өмчийн бүртгэл гэх мэт) ердийн даатгалын компанийн нягтлан бодох бүртгэлийн зааврыг ашиглах ба зөвхөн урт хугацааны даатгалын бүтээгдэхүүний бүртгэлд доорх зарчмуудыг баримтална.
2. Урт хугацааны даатгалын бүтээгдэхүүнийг нягтлан бодох бүртгэлийн зориулалтаар дараах ангилалд хуваах ба ангилал тус бүрийн дагуу бүртгэлийг хөтөлнө. Үүнд:
 - Даатгалын гэрээ
 - Богино хугацаат даатгал
 - Тогтмол болон баталгаат нөхцөлтэй урт хугацаат даатгал
 - Хувь оролцооны нөхцөлтэй урт хугацаат даатгал
 - Хөрөнгө оруулалтын гэрээ
 - Хувь оролцооны нөхцөлтэй хөрөнгө оруулалтын гэрээ
 - Тогтмол болон баталгаат нөхцөлтэй хөрөнгө оруулалтын гэрээ
 - Тогтмол бус нөхцөлтэй хөрөнгө оруулалтын гэрээ

7.2. АНГИЛЛЫН ЗАРЧИМ

7.2.1 УРТ ХУГАЦААНЫ ДААТГАЛ БА ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГЭРЭЭ

Урт хугацааны даатгалын компанийн бүтээгдэхүүний гэрээ бүрийн хувьд нөхөн төлбөрийн хэмжээнээс хамааран дээрх хоёр ангилалд хуваагдана. Даатгалын тохиолдол болсон үед даатгуулагч эсвэл даатгуулагчийн хүлээн зөвшөөрсөн талд төлөх нийт нөхөн төлбөр нь даатгалын тохиолдол болоогүй үед төлөх нийт нөхөн төлбөрөөс 10 болон түүнээс дээш хувиар илүү байх тохиолдолд уг гэрээг нягтлан бодох бүртгэлийн зориулалтаар даатгалын гэрээ гэж ангилна. Энэ хувь нь 10-аас бага байх тохиолдолд хөрөнгө оруулалтын гэрээ гэж ангилна. Энэхүү ангиллыг гэрээ байгуулах үед тооцоолон тодорхойлно. Гэрээ байгуулагдах үед даатгалын гэрээ гэж ангилсан гэрээг тухайн гэрээ дуусгавар болох хүртэл энэхүү ангиллыг нь өөрчлөхгүй. Харин анхлан хөрөнгө оруулалтын гэрээ гэж ангилагдсан гэрээ нь дараагийн тайлант хугацаанд даатгалын гэрээний тодорхойлолтыг хангаж эхэлвэл даатгалын гэрээний ангилал руу шилжүүлж болно.

Жишээ тайлбар: Амь насны даатгалын гэрээ нь нөхөн төлбөрийн хэмжээнээс шалтгаалан дараах ангилалд орж болно.

Д/д	Даатгалын тохиолдол болсон үед нөхөн олговор болгон төлөх төлбөр	Даатгалын тохиолдол болоогүй буюу гэрээний эцэст төлөх төлбөр	Нягтлан бодох бүртгэлийн зориулалтаарх ангилал
1	5,000,000 ₮	0₮	Даатгалын гэрээ
2	5,000,000 ₮	4,000,000₮	Даатгалын гэрээ
3	5,000,000 ₮	5,000,000₮	Хөрөнгө оруулалтын гэрээ

Дээрх 3 гэрээний даатгалын хураамж нь даатгалын тохиолдол болоогүй буюу гэрээний эцэст төлөх төлбөрийн хэмжээнээс шууд хамааран өснө.

7.2.2 УРТ БОЛОН БОГИНО ХУГАЦААТ ГЭРЭЭ

Урт хугацааны даатгалын компанийн бүтээгдэхүүний гэрээний хугацаа нь 12 сараас дээш байвал урт хугацаат, түүнээс богино байвал богино хугацаат гэрээ гэж ангилна. Гэрээг 12 сараас дээш хугацаатай байгуулсан боловч даатгалын хураамжийн хувь хэмжээг шинэчлэх үед даатгалын хураамжийг шинээр тооцоолж байгаа бол тухайн гэрээг хураамж шинээр тооцоолох хүртэлх хугацаанаас хамааруулан богино болон урт хугацаат гэрээ гэж ангилна.

7.2.3 ХУВЬ ОРОЛЦООНЫ НӨХЦӨЛТЭЙ ГЭРЭЭ ЭСЭХ

Гэрээнд заасан баталгаат нөхөн төлбөрөөс гадна дараах нөхцлийг хангасан нэмэлт төлбөр эсвэл бонус төлөх нөхцөлтэй гэрээг хувь оролцооны нөхцөлтэй гэрээ гэж ангилна.

Үүнд:

1. Энэхүү нэмэлт төлбөр эсвэл бонус нь гэрээний дагуух нийт нөхөн төлбөрийн хэмжээний ихээхэн хэсгийг бүрдүүлэх магадлалтай ба
2. Энэхүү нэмэлт төлбөр эсвэл бонусыг төлөх хэмжээ эсвэл хугацаа нь даатгагчийн шийдвэр байх ба
3. Гэрээнд заасны дагуу дараах зүйлсийн аль нэгнээс хамаарсан байх:
 - Тухайлан заасан гэрээнүүдийн багц эсвэл тодорхой төрлийн гэрээний өгөөжийн гүйцэтгэл, эсвэл
 - Даатгагчийн эзэмшиж буй тухайлан заасан хөрөнгийн багцын хэрэгжсэн ба/эсвэл хэрэгжээгүй/ хөрөнгө оруулалтын өгөөж, эсвэл
 - Тухайн гэрээг гаргагч даатгагч, сан эсвэл бусад хуулийн этгээдийн ашиг/алдагдал.

Даатгалын болон хөрөнгө оруулалтын гэрээний аль аль нь хувь оролцооны нөхцөлтэй байж болно.

7.3. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ЗАРЧИМ

7.3.1 БОГИНО ХУГАЦААТ ДААТГАЛ

А. БҮРТГЭЛ

Богино хугацаат даатгал гэж ангилагдсан гэрээний бүртгэлд ердийн даатгалын компанийн бүртгэлийн зарчмыг баримтална.

7.3.2 ТОГТМОЛ БОЛОН БАТАЛГААТ НӨХЦӨЛТЭЙ УРТ ХУГАЦААТ ДААТГАЛ

А. БҮРТГЭЛ

Даатгалын хураамжийн орлогыг гэрээнд заасан төлөх хугацаанд нь гэрээнд заасан төлбөл зохих дүнгээр хүлээн зөвшөөрнө. Гэрээний дагуу төлөх нөхөн төлбөрийг нөхөн төлбөр үүссэн хугацаанд нь зардлаар хүлээн зөвшөөрнө. Гэрээний дагуу ирээдүйд төлөгдөх нөхөн төлбөрийн дүнг харгалзах хураамжийн орлогыг хүлээн зөвшөөрөх хугацаанд хувь тэнцүүлэн хүлээн зөвшөөрнө.

Хэрэв даатгалын хураамжийн орлого нь нэг удаа төлөгдөх эсвэл нөхөн төлбөр хуримтлагдах хугацаанаас ихээхэн хэмжээгээр богино хугацаанд төлөгдөхөөр байвал энэхүү илүү төлөгдсөн хураамжийн орлогыг даатгалын гэрээний хугацаанд хувь тэнцүүлэн бүртгэх зарчмын дагуу орлогод тооцоогүй хураамжийн орлогын нөөцийг хүлээн зөвшөөрнө.

7.3.3 ХУВЬ ОРОЛЦООНЫ НӨХЦӨЛТЭЙ УРТ ХУГАЦААТ ДААТГАЛ

А. БҮРТГЭЛ

Даатгалын хураамжийн орлогыг шууд өр төлбөрөөр хүлээн зөвшөөрнө. Өр төлбөрийн хэмжээг универсал урт хугацааны даатгалын хувьд (universal life insurance) хүүний хэмжээгээр эсвэл нэгж хөрөнгө оруулалтанд уялдуулсан урт хугацааны даатгалын хувьд (unit-linked contract) нэгжийн үнийн өөрчлөлтөөр өсгөх ба эргүүлэн төлсөн дүн (withdrawal), нас баралтын нөхөн төлбөр (mortality charge) болон цуцлалтын үеийн үнэ цэнийн зардал (surrender charge)-аар бууруулна.

Орлого нь нас баралтын төлбөр, гэрээний удирдлагын зардал болон цуцлалтын үеийн үнэ цэнийн зардлаас бүрдэх ба өр төлбөрийг бууруулж хүлээн зөвшөөрнө. Өр төлбөрт кредитлэсэн хүү болон нэгж хөрөнгө оруулалтын үнийн өөрчлөлтийн дүнгээр зардал хүлээн зөвшөөрнө.

7.3.4 ХУВЬ ОРОЛЦООНЫ НӨХЦӨЛТЭЙ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГЭРЭЭ

А. БҮРТГЭЛ

Энэ ангиллын гэрээний орлого болон өр төлбөрийг хувь оролцооны нөхцөлтэй универсал урт хугацааны даатгалын гэрээний орлого болон өр төлбөрийн бүртгэлтэй адилаар бүртгэнэ. Үүссэн өр төлбөрийн хэмжээ нь гэрээний баталгаат нөхөн төлбөрийн хорогдуулсан өртөг болон гэрээнд агуулагдсан цуцлалтын үеийн үнэ цэнийн нуугдмал үнэ цэнэ хоёрын нийлбэрээс бага байвал зөрүүг орлогоор нэмж хүлээн зөвшөөрнө.

7.3.5 ТОГТМОЛ БОЛОН БАТАЛГААТ НӨХЦӨЛТЭЙ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГЭРЭЭ

А. БҮРТГЭЛ

Тогтмол болон баталгаат нөхцөлтэй хөрөнгө оруулалтын гэрээг санхүүгийн хэрэглүүрийн хорогдуулсан өртгийн аргыг ашиглан бүртгэнэ. Өр төлбөрийг анхлан бодит үнэ цэнээс нь тухай гэрээтэй шууд хамааралтай өсөн нэмэгдэх зардал (transaction cost)-ыг хассан дүнгээр хүлээн зөвшөөрнө. Дараагийн тайлант хугацаанд үр ашигт хүүгийн аргыг ашигласан хорогдуулсан өртгөөр нь бүртгэнэ. Тайлант хугацаа бүрийн эцэст гэрээтэй холбоотой хүлээгдэж буй ирээдүйн мөнгөн урсгалын таамаглалыг хийх ба уг мөнгөн урсгалыг анхны үр ашигт хүүний хувийг ашиглан хорогдуулж өр төлбөрийн дүнтэй харьцуулах ба үүссэн зөрүү нь нэмэх байвал орлого, хасах байвал зардлаар хүлээн зөвшөөрнө.

7.3.6 ТОГТМОЛ БУС НӨХЦӨЛТЭЙ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГЭРЭЭ

А. БҮРТГЭЛ

Энэ ангиллын хөрөнгө оруулалтын гэрээ нь холбогдох санхүүгийн хөрөнгө, үүсмэл санхүүгийн хэрэглүүр ба/эсвэл хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн бодит үнэ цэнээс өөрийх нь үнэ цэнэ нь хамаарсан санхүүгийн өр төлбөр ба анхлан хүлээн зөвшөөрөх үедээ бодит үнэ цэнийн өөрчлөлт нь орлого үр дүнгийн тайланд санхүүгийн өр төлбөр гэж бүртгэгдэнэ. Анхлан хүлээн зөвшөөрөхдөө бодит үнэ цэнээрээ бүртгэгдэх ба энэ нь ихэвчлэн гүйлгээний төлбөр байна. Хэрэв бодит үнэ цэнэ нь гүйлгээний төлбөрөөс өөр байгаа нь батлагдаж байвал анхлан хүлээн зөвшөөрөлтийн үеийн ашиг/алдагдлыг хүлээн зөвшөөрнө. Дараагийн тайлант хугацаанд бодит үнэ цэнээрээ бүртгэгдэх ба бодит үнэ цэнийн өөрчлөлтийг орлогын тайланд бүртгэнэ. Тогтмол бус нөхцөлтэй хөрөнгө оруулалтын гэрээний санхүүгийн өр төлбөрийн бодит үнэ цэнийг гэрээний нэгж хөрөнгө оруулалтыг илэрхийлсэн хөрөнгө оруулалтын өнөөгийн үнэ цэнээр хэмжинэ.

**ДААТГАЛЫН КОМПАНИУДАД МӨРДӨХ НЯГТЛАН БОДОХ
 БҮРТГЭЛИЙН ДАНСНЫ ЖАГСААЛТ**

Толгой данс, нэр	Ерөнхий данс	Ерөнхий дансны нэр
10 Касс	1010	Бэлэн мөнгө төгрөг
	1020	Бэлэн мөнгө валют
	1030	Замд яваа мөнгө
1110-1199 Харилцах, хадгаламж /3 сар хүртэлх хугацаатай/	1110	Дотоодын банкин дахь харилцах төгрөг
	1111	Дотоодын банкин дахь харилцах валют
	1112	Гадаадын банкин дахь харилцах
	1120	Дотоодын банкин дахь хугацаагүй хадгаламж /төгрөг/
	1121	Дотоодын банкин дахь хугацаагүй хадгаламж /валют/
	1130	Санхүүгийн байгууллагад байршуулсан 3 сараас бага хугацаатай хөрөнгө /төгрөг/
	1131	Санхүүгийн байгууллагад байршуулсан 3 сараас бага хугацаатай хөрөнгө /валют/
	1132	Гадаадын санхүүгийн байгууллагад
	1140	Дотоодын банкин дахь 3 сар хүртлэх хугацаатай хадгаламж, хадгаламжийн сертификат /төгрөг/
	1141	Дотоодын банкин дахь хадгаламж, 3 сар хүртэлх хугацаатай хадгаламж, хадгаламжийн сертификат /валют/
	1142	Гадаадын банкин дахь 3 сар хүртэлх хугацаатай хадгаламж, хадгаламжийн сертификат
	1150	3 сар хүртэлх хугацаатай Үнэт цаас /төгрөг/
	1151	3 сар хүртэлх хугацаатай Үнэт цаас /валют/
	1170	Дотоодын банкинд байршуулсан 3 сар хүртэлх хугацаатай хөрөнгө оруулалтын хүү, хямдруулалтын авлага /төгрөг/
	1171	Дотоодын банкинд байршуулсан 3 сар хүртэлх хугацаатай хөрөнгө оруулалтын хүү, хямдруулалтын авлага /валют/
	1173	Гадаадын банкинд байршуулсан 3 сар хүртэлх хугацаатай хөрөнгө оруулалтын хүү, хямдруулалтын авлага
	1180	Үнэт цаасанд хуримтлуулж тооцсон хүү /төгрөг/
	1181	Үнэт цаасанд хуримтлуулж тооцсон хүү /валют/
1210-1259 Даатгалын авлага	1210	Даатгалын хураамжийн авлага
	1219	Даатгалын хураамжийн авлага эрсдэлийн сан
	1220	Буруутай этгээдээс авах авлага
	1229	Буруутай этгээдээс авах авлагын эрсдэлийн сан
	1230	Давхар даатгагчаас авах нөхөн төлбөрийн авлага
	1239	Давхар даатгагчаас авах нөхөн төлбөрийн авлагын эрсдэлийн сан
1210-1259 Даатгалын авлага	1240	Давхар даатгагчаас авах хураамжийн авлага
	1249	Давхар даатгагчаас авах хураамжийн авлагын эрсдэлийн сан
	1250	Давхар даатгагчаас авах шимтгэл
	1259	Давхар даатгагчаас авах шимтгэлийн эрсдэлийн сан
1260-1269 Бусад санхүүгийн хөрөнгө	1260	Бусад авлага
	1269	Бусад авлагын эрсдэлийн сан

1270-1289 Бусад санхүүгийн бус хөрөнгө	1270	Бусад татварын авлага
	1271	НДШ авлага
	1280	ААНОАТ авлага
	1290	Хойшлогдсон татварын хөрөнгө
1310 Банк санхүүгийн байгууллагд байршуулсан хөрөнгө оруулалт	1310	Банкинд байршуулсан 3 сараас дээш хугацаатай хадгаламж, хадгаламжийн сертификат
	1311	Гадаадын банкинд байршуулсан 3 сараас дээш хугацаатай хадгаламж, хадгаламжийн сертификат
	1312	Санхүүгийн байгууллагад байршуулсан 3 сараас дээш хугацаатай хөрөнгө оруулалт
	1317	Банкинд байршуулсан 3 сараас дээш хугацаатай хадгаламж, хадгаламжийн сертификатын хөнгөлөлт, урамшуулал, хямдруулалт
	1318	Банкинд байршуулсан 3 сараас дээш хугацаатай хадгаламж, хадгаламжийн сертификат, хүүний авлага
1320 Үнэт цаасаарх хөрөнгө оруулалт	1320	Хугацааны эцэс хүртэл эзэмших үнэт цаас-Дотоод
	1321	Борлуулахад бэлэн үнэт цаас-Дотоод
	1322	Арилжааны үнэт цаас
	1323	Зээл ба авлага гэж ангилсан үнэт цаас
	1327	Үнэт цаасны хөнгөлөлт, урамшуулал, хасагдуулга, хямдруулалт
	1328	Үнэт цаасны хуримтлуулж тооцсон авлага
1330 Хараат ба хамтын хяналттай, охин компаниудад оруулсан хөрөнгө оруулалт	1331	Охин компанид оруулсан хөрөнгө оруулалт
	1332	Хараат компанид оруулсан хөрөнгө оруулалт
	1333	Хамтын хяналттай компанид оруулсан хөрөнгө оруулалт
	1338	Ногдол ашгийн авлага
	1339	Хараат, хамтын хяналттай, охин компаниудад оруулсан хөрөнгө оруулалтын эрсдэлийн сан
1350 Үнэт металл, Дериватив	1350	Дотоодын Үнэт металл, Дериватив
	1351	Гадаадын Үнэт металл, Дериватив
14 Бараа материал	1410	Бичиг хэргийн материал
	1420	Хангамжийн материал
	1430	Түлш шатахуун
	1440	Сэлбэг хэрэгсэл
15 Урьдчилж төлсөн зардал, тооцоо	1510	Урьдчилж төлсөн тооцоо
	1510	Урьдчилж төлсөн зардал
16 Өмчлөх бусад хөрөнгө	1610	Өмчлөх бусад хөрөнгө
	1619	Өмчлөх бусад хөрөнгийн эрсдэлийн сан

18-19 Даатгалын хөрөнгө	1810	ДД-ын хойшлогдсон хураамж
	1820	Нөхөн төлбөрийн нөөцийн давхар даатгагчид ногдох хэсэг УБМХНС
	1821	Нөхөн төлбөрийн нөөцийн давхар даатгагчид ногдох хэсэг МБТХНС
	1910	Даатгалын орлогын шимтгэлийн хойшлогдсон зардал Зуучлагч
	1920	Даатгалын орлогын шимтгэлийн хойшлогдсон зардал Төлөөлөгч
	1930	Даатгалын орлогын шимтгэлийн хойшлогдсон бусад зардал
20 Үндсэн хөрөнгө	2010	Газрын сайжруулалт
	2020	Барилга байгууламж
	2030	Машин тоног төхөөрөмж
	2040	Тээврийн хэрэгсэл
	2050	Тавилга эд хогшил
	2060	Компьютер дагалдах хэрэгсэл
	2061	Газар сайжруулалтын хуримтлагдсан элэгдэл
	2062	Барилга байгууламж хуримтлагдсан элэгдэл
	2063	Машин тоног төхөөрөмж хуримтлагдсан элэгдэл
	2064	Тээврийн хэрэгсэл хуримтлагдсан элэгдэл
	2065	Тавилга эд хогшил хуримтлагдсан элэгдэл
	2066	Компьютер дагалдах хэрэгсэл хуримтлагдсан элэгдэл
	2067	Санхүүгийн түрээсийн хөрөнгө хуримтлагдсан элэгдэл
	2070	Санхүүгийн түрээсийн хөрөнгө
	2080	Дуусаагүй барилга
	2081	Хуримтлагдсан үнэ цэнийн бууралт
	2082	Барилга байгууламж хуримтлагдсан үнэ цэнийн бууралт
	2083	Машин тоног төхөөрөмж хуримтлагдсан үнэ цэнийн бууралт
	2084	Тээврийн хэрэгсэл хуримтлагдсан үнэ цэнийн бууралт
	2085	Тавилга эд хогшил хуримтлагдсан үнэ цэнийн бууралт
21 Биет бус хөрөнгө	2086	Компьютер дагалдах хэрэгсэл хуримтлагдсан үнэ цэнийн бууралт
	2087	Санхүүгийн түрээсийн хөрөнгө хуримтлагдсан үнэ цэнийн бууралт
	2110	Зохиогчийн эрх
	2120	Програм хангамж
	2130	Патент
	2140	Барааны тэмдэг
	2150	Газар эзэмших эрх
	2160	Бусад биет бус хөрөнгө
	2161	Зохиогчийн эрх хуримтлагдсан хорогдол
	2162	Програм хангамж хуримтлагдсан хорогдол
	2163	Патент хуримтлагдсан хорогдол
	2164	Барааны тэмдэг хуримтлагдсан хорогдол
	2165	Газар эзэмших эрх хуримтлагдсан хорогдол
	2166	Бусад биет бус хөрөнгө хуримтлагдсан хорогдол
	2181	Зохиогчийн эрх хуримтлагдсан үнэ цэнийн бууралт
	2182	Програм хангамж хуримтлагдсан үнэ цэнийн бууралт

21 Биет бус хөрөнгө	2183	Патент хуримтлагдсан үнэ цэнийн бууралт
	2184	Барааны тэмдэг хуримтлагдсан үнэ цэнийн бууралт
	2185	Газар эзэмших эрх хуримтлагдсан үнэ цэнийн бууралт
	2186	Бусад биет бус хөрөнгө хуримтлагдсан үнэ цэнийн бууралт
26 ХОЗҮХХ	2610	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө
29 Хоорондын тооцоо	2910	Салбар хоорондын тооцоо
31 Даатгалын өглөг	3110	Даатгалын хураамжийн буцаалтын өглөг
	3130	Даатгалын гэрээний шимтгэлийн өглөг
	3150	Давхар даатгагчид өгөх өглөг
	3151	Давхар даатгагчид өгөх хураамжийн өглөг
32 Бусад санхүүгийн өр төлбөр	3210	Зээлийн өглөг
	3220	Өрийн бичгийн өглөг, хүү
	3230	Санхүүгийн түрээсийн өр төлбөр
	3240	Ногдол ашгийн өглөг
	3250	Деривативын өр төлбөр
	3260	Бусад санхүүгийн өр төлбөр
33 Бусад санхүүгийн бус өр төлбөр	3310	Цалингийн өглөг
	3320	НДШ-ийн өглөг
	3321	Бусад татварын өглөг
	3330	ААНОАТатварын өглөг
	3340	Хойшлогдсон татварын өглөг
	3350	Урьдчилж орсон орлого
	3360	Нийгмийн хөгжлийн сангийн өр төлбөр
	3361	Хуулийн байууллагаар шийдэгдэж байгаа зүйлсийн өр төлбөр
	3362	Мөнгөөр төлөгдөх хувьцааны опцион
	3363	Тэтгэврийн сан (өр төлбөр)
	3380	Бусад санхүүгийн бус өр төлбөр
	3390	Хоёрдогч өглөг
	3391	Давуу эрхийн хувьцаа
34 Нөөц сан	3410	Орлогдот тооцоогүй хураамжийн нөөц
	3420	Учирсан боловч мэдэгдээгүй хохирлын НС
	3421	Учирсан боловч мэдэгдээгүй хохирлыг барагдуулахтай холбогдон гарах зайлшгүй зардал
	3430	Мэдсэн боловч төлөөгүй ХНС
35 Учирч болзошгүй хохирлын НС	3510	Учирч болзошгүй хохирлын НС
39 Хоорондын тооцоо	3910	Салбар хоорондын тооцоо

41 Хувь нийлүүлсэн хөрөнгө	4110	Энгийн хувьцаа
	4111	Давуу эрхийн хувьцаа
42 Нэмж төлөгдсөн капитал	4210	Энгийн хувьцаа
	4211	Давуу эрхийн хувьцаа
43 Халаасны хувьцаа	4310	Энгийн хувьцаа
	4311	Давуу эрхийн хувьцаа
44 Тогтвортой байдлын нөөц сан	4410	Тогтвортой байдлын нөөц сан
45 Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	4510	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл
46 Хуримтлагдсан ашиг, алдагдал	4610	Хуримтлагдсан ашиг, алдагдал
47 Бусад өөрийн хөрөнгө	4710	Тусгай зориулалттай сан
	4711	Хувьцаанд суурилсан төлбөр
	4712	Хувьцаа эзэмшигчдээс оруулсан бусад хөрөнгө
	4713	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц
	4714	Бусад
51 Даатгалын хураамжийн орлого	5110	Даатгалын хураамж
	5119	Даатгалын хураамжийн буцаалт
52 Даатгалын үйл ажиллагааны орлого	5210	Давхар даатгалын шимтгэлийн орлого
	5220	Давхар даатгагчийн хариуцсан нөхөн төлбөр
	5230	Буруутай этгээдийн хариуцсан нөхөн төлбөр
53 Хөрөнгө оруулалтын орлого	5310	Хөрөнгө оруулалтын орлого
	5320	Хөрөнгө оруулалтын олз, гарз
	5321	
54 Хараат ба хамтын хяналттай, охин компанид оруулсан хөрөнгө оруулалт	5410	Хараат ба хамтын хяналттай, охин компанид оруулсан хөрөнгө оруулалтын олз, гарз
55 Түрээсийн орлого	5510	Түрээсийн орлого
56 Үйл ажиллагааны бусад орлого	5610	Эрхийн шимтгэлийн орлого
	5611	Хүүгийн орлого (харилцах, хугацаагүй хадгаламж)
	5612	Санхүүгийн түрээсийн орлого
	5620	Эрсдэлийн сангаас хаагдсан авлагын эргэн төлөлт
57 Үйл ажиллагааны бус бусад олз, гарз	5710	Гадаад валютын ханшийн зөрүүний олз, гарз
	5711	
	5720	Биет болон биет бус хөрөнгө борлуулсан, данснаас хассаны олз, гарз
	5721	
	5730	Өрийн бичиг, Бонд эргэлтээс гаргалтын олз, гарз
	5740	Торгууль алдангийн олз, гарз
	5750	Хандивын олз
	5751	Бусад олз гарз

60 Давхар даатгалын зардал	6010	Давхар даатгалын хураамж
	6011	Давхар даатгалын хураамжийн буцаалт
61 Орлого тооцоогүй хураамжийн нөөцийн өөрчлөлт	6110	Орлого тооцоогүй хураамжийн нөөцийн өөрчлөлт
62 Хойшлогдсон ДД-ын хураамжийн өөрчлөлт	6210	ДД-ын хойшлогдсон хураамжийн өөрчлөлт
63 Нөхөн төлбөрийн зардал	6310	Нөхөн төлбөрийн зардал
65 Нөөцийн сангийн өөрчлөлт	6520	Учирсан боловч мэдэгдээгүй хохирлын НС-ийн өөрчлөлт
	6521	Учирсан боловч мэдэгдээгүй хохирлыг барагдуулахтай холбогдон гарах зайлшгүй зардлын өөрчлөлт
	6530	Мэдсэн боловч төлөөгүй хохирлын НС-ийн өөрчлөлт
66 Учирч болзошгүй хохиролын болон тогтвортой байдлын нөөц сангийн өөрчлөлт	6610	Учирч болзошгүй хохиролын болон тогтвортой байдлын нөөц сангийн өөрчлөлт
67 Нөхөн төлбөрийн нөөцийн давхар даатгагчид ногдох хэсгийн өөрчлөлт	6710	Нөхөн төлбөрийн нөөцийн давхар даатгагчид ногдох хэсгийн өөрчлөлт УБМХНС
	6720	Нөхөн төлбөрийн нөөцийн давхар даатгагчид ногдох хэсгийн өөрчлөлт МБТХНС
68 Даатгалын гэрээний зардал	6810	Даатгалын гэрээний зардал /зуучлагч/
	6820	Даатгалын гэрээний зардал /төлөөлөгч/
70 Еранхий ба удирдлагын зардал	7010	Ажиллагчдын цалингийн зардал
	7011	Аж ахуйн нэгжээс төлсөн НДШ-ийн зардал
	7012	Татвар, төлбөр, хураамжийн зардал
	7013	Томилолтын зардал
	7014	Бичиг хэргийн зардал
	7015	Шуудан холбооны зардал
	7016	Мэргэжлийн үйлчилгээний зардал
	7017	Сургалтын зардал
	7018	Сонин сэтгүүл захиалгын зардал
	7019	Даатгалын зардал
	7020	Ашиглалтын зардал
	7021	Засварын зардал
	7022	Элэгдэл, хорогдлын зардал
	7023	Түрээсийн зардал
	7024	Харуул, хамгааллын зардал
	7025	Цэвэрлэгээ, үйлчилгээний зардал
	7026	Тээврийн зардал
	7027	Шатахууны зардал
	7028	Хүлээн авалт, баяр ёслолын зардал
	7029	Зар сурталчилгааны зардал

71 Борлуулалт, маркетингийн зардал	7110	Ажиллагчдын цалингийн зардал
	7111	Байгууллагаас төлсөн НДШ-ийн зардал
	7112	Татвар, төлбөр, хураамжийн зардал
	7113	Томилолтын зардал
	7114	Бичиг хэргийн зардал
	7115	Шуудан холбооны зардал
	7116	Мэргэжлийн үйлчилгээний зардал
	7117	Сургалтын зардал
	7118	Сонин сэтгүүл захиалгын зардал
	7119	Даатгалын зардал
	7120	Ашиглалтын зардал
	7121	Засварын зардал
	7122	Элэгдэл, хорогдлын зардал
	7123	Түрээсийн зардал
	7124	Харуул, хамгаалалтын зардал
	7125	Цэвэрлэгээ, үйлчилгээний зардал
	7126	Тээврийн зардал
	7127	Шатахууны зардал
	7128	Хүлээн авалт, баяр ёслолын зардал
	7129	Зар сурталчилгааны зардал
72 Санхүүгийн зардал	7210	Санхүүгийн зардал
73 Үйл ажиллагааны бусад зардал	7310	Үйл ажиллагааны бусад зардал
74 Үйл ажиллагааны бус зардал	7410	Үйл ажиллагааны бус зардал
	7420	Эрсдэлийн сангийн зардал
	7430	Үйл ажиллагааны бус бусад зардал
91-92 ОАТатвар, ОЗНД	9110	ААН-ийн ОАТЗардал
	9210	ОЗНД
80 Фронтинг	8010	Фронтинг гэрээний хураамж
	8020	Фронтинг гэрээний даатгалын хариуцлага
81 Даатгалын хариуцлага	8110	Даатгалын зүйлийн үнэлгээ
	8120	Давхар даатгалтай даатгалын зүйлийн үнэлгээ
82 Даатгалын гэрээний тоо	8210	Даатгалын гэрээний тоо
	8220	Давхар даатгалтай даатгалын гэрээний тоо
83 Бүрэн сүйрсэн даатгалын хөрөнгө	8310	Бүрэн сүйрсэн даатгалын хөрөнгө
84 Шүүхээр шийдвэрлэгдээгүй байгаа нөхөн төлбөр	8410	Шүүхээр шийдвэрлэгдээгүй байгаа нөхөн төлбөр

85 Бусдын өмнө өөрийн хөрөнгөөр хариуцсан хариуцлага	8510	Баталгаа, батлан даалтад хамаарах үүрэг
	8520	Барьцаанд тавьсан хөрөнгө
86 Барьцаанд авсан хөрөнгө	8610	Барьцаанд авсан хөрөнгө
87 Тэнцлээс хассан хөрөнгө	8710	Тэнцлээс хассан хөрөнгө
88 Дериватив	8810	Спот, Форвард, Своп, Опцион, Фьючерс, бусад
89 Хадгалж буй үнэ бүхий зүйл	8910	Хадгалж буй үнэ бүхий зүйл

**ДААТГАЛЫН КОМПАНИЙН САНХҮҮГИЙН
ТАЙЛАНГИЙН МАЯГТ, ТОДРУУЛГА**

Регистрийн дугаар: _____

Хаяг: _____

Шуудангийн хаяг: _____

Утас: _____ Факс: _____

Өмчийн хэлбэр: Төрийн _____ хувь, хувийн _____ хувь



.....-ИЙН
..... ОНЫ ЖИЛИЙН
САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Хянаж хүлээн авсан байгууллагын нэр	Сар, Өдөр	Гарын үсэг

.....-ийн
оны-р сарын-ны өдрийн
санхүүгийн тайлангийн бодит байдлын
тухай мэдэгдэл

.....оны.....р сарын.....-ны өдөр

.....-ийн Захирал _____, Ерөнхий нягтлан бодогч /Санхүү хариуцсан захирал/ _____ бид тайлант хугацааны үйл ажиллагааны үр дүн, санхүүгийн байдлыг оны ...-р сарын-ны өдрөөр гаргасан санхүүгийн тайланд үнэн зөв, бүрэн тусгасан болохыг баталж байна. Үүнд:

1. Бүх ажил гүйлгээ бодитоор гарсан бөгөөд холбогдох анхан шатны баримтыг үндэслэн нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайланд үнэн зөв тусгасан.
2. Санхүүгийн тайланд тусгагдсан бүх тооцоолол үнэн зөв хийгдсэн.
3. Компанийн үйл ажиллагааны эдийн засаг, санхүүгийн бүхий л үйл явцыг иж бүрэн хамарсан.
4. Тайлант үеийн үр дүнд өмнөх оны ажил гүйлгээнээс шилжин тусгагдаагүй, мөн тайлант оны ажил гүйлгээнээс орхигдсон зүйл байхгүй.
5. Бүх хөрөнгө, өр төлбөр, өөрийн хөрөнгө, орлого, зардлыг холбогдох Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв тусгасан. Мөн хүлээж болзошгүй үүргийг үнэн зөв бүртгэж, толилуулсан.
6. Энэ тайланд тусгагдсан бүхий л зүйлийг манай компани албан ёсоор эзэмшдэг бөгөөд орхигдсон зүйл үгүй болно.
7. Хэлбэрээс агуулгыг чухалчлах: Эдийн засгийн шинж чанар ба эрх зүйн хувьд хэлбэрээрээ ялгаатай хөрөнгө, өр төлбөрийг тэдгээрийн эдийн засгийн шинж чанар буюу агуулгыг харгалзан бүртгэсэн.
8. Тайлант хугацаанд манай компани гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчөөгүй бөгөөд хууль тогтоомж зөрчсөн аливаа гүйлгээ хийгээгүй.
9. Компанийн тасралтгүй үйл ажиллагаа алдагдсан байж болзошгүй нөхцөл байдал үүсээгүй.
10. Тайлант хугацаанд манай компани Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон төлбөрийн чадварын зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг хангаж ажилласан.
11. Манай компани, компанийн удирдлага, захирлууд болон ажилтнууд Монгол Улсын хууль тогтоомж, Санхүүгийн зохицуулах хорооноос гаргасан заавар, журмыг бүрэн мөрдөж ажилласан болно.

(тамга, тэмдэг, гарын үсэг)

ЗАХИРАЛ...../...../
гарын үсгийн тайлал

ЕРӨНХИЙ НЯГТЛАН
БОДОГЧ...../...../
гарын үсгийн тайлал

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/компанийн нэр/

20...оны.....сарын.....өдөр

(төгрөг, мөнгөөр)

№	Үзүүлэлт	... оны 12-р сарын 31	... оны 12-р сарын 31
1	Хөрөнгө		
1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө		
1.1.1	Бэлэн мөнгө		
1.1.2	Харилцахад байгаа мөнгө		
1.1.3	Банк санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө		
1.1.4	Мөнгөн хөрөнгөнд хуримтлуулж тооцсон хүүний авлага		
1.1.5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн дүн		
1.2	Даатгалын авлага		
1.2.1	Даатгалын хураамжийн авлага		
1.2.2	Буруутай этгээдээс авах авлага		
1.2.3	Давхар даатгалаас авах авлага		
1.2.4	Даатгалын авлагын дүн		
1.3	Бусад санхүүгийн хөрөнгө		
1.3.1	Бусад авлага		
1.3.2	Бусад санхүүгийн хөрөнгийн дүн		
1.4	Бусад санхүүгийн бус хөрөнгө		
1.4.1	НДШ авлага, бусад татварын авлага		
1.4.2	ААНОАТатварын авлага		
1.4.3	Хойшлогдсон татварын хөрөнгө		
1.4.4	Бараа материал		
1.4.5	Урьдчилж төлсөн зардал/тооцоо		
1.4.6	Өмчлөх бусад хөрөнгө		
1.4.7	Бусад санхүүгийн бус хөрөнгийн дүн		
1.5	Хөрөнгө оруулалт		
1.5.1	Хадгаламж, хадгаламжийн сертификат		
1.5.2	Үнэт цаас		
1.5.3	Хараат, хамтын хяналттай, охин компанид оруулсан хөрөнгө оруулалт		
1.5.4	Дериватив санхүүгийн хэрэглүүр		
1.5.5	Хөрөнгө оруулалтын дүн		
1.6	Даатгалын хөрөнгө		
1.6.1	Хойшлогдсон давхар даатгалын хураамж		
1.6.2	Нөхөн төлбөрийн нөөцийн сангийн давхар даатгагчид ногдох хэсэг		
1.6.3	Даатгалын орлогын хойшлогдсон шимтгэлийн зардал		
1.6.4	Даатгалын хөрөнгийн дүн		
1.7	Үндсэн хөрөнгө /Цэвэр/		
1.8	Биет бус хөрөнгө /Цэвэр/		
1.9	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө		
1.11	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		

№	Үзүүлэлт	... оны 12-р сарын 31	... оны 12-р сарын 31
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	ӨР ТӨЛБӨР		
2.1.1	Даатгалын өглөг		
2.1.1.1	Даатгалын хураамжийн буцаалтын өглөг		
2.1.1.2	Нөхөн төлбөрийн өглөг		
2.1.1.3	Даатгалын гэрээний шимтгэлийн өглөг		
2.1.1.4	Давхар даатгагчид өгөх өглөг		
2.1.1.5	Даатгалын өглөгийн дүн		
2.1.2	Бусад санхүүгийн өр төлбөр		
2.1.2.1	Зээлийн өглөг, хүү		
2.1.2.2	Өрийн бичиг, хүү		
2.1.2.3	Санхүүгийн түрээсийн өр төлбөр		
2.1.2.4	Ногдол ашгийн өглөг		
2.1.2.5	Деривативын өр төлбөр		
2.1.2.6	Бусад өр төлбөр		
2.1.2.7	Бусад санхүүгийн өр төлбөрийн дүн		
2.1.3	Бусад санхүүгийн бус өр төлбөр		
2.1.3.1	Цалингийн өглөг		
2.1.3.2	НДШ-ийн өглөг		
2.1.3.3	ААНОАТатварын өглөг		
2.1.3.4	Хойшлогдсон татварын өглөг		
2.1.3.5	Урьдчилж орсон орлого		
2.1.3.6	Нийгмийн хөгжлийн сангийн өр төлбөр		
2.1.3.7	Хуулийн байууллагаар шийдэгдэж байгаа зүйлсийн өр төлбөр		
2.1.3.8	Мөнгөөр төлөгдөх хувьцааны опцион		
2.1.3.9	Тэтгэврийн сангийн өр төлбөр		
2.1.3.10	Санхүүгийн түрээсийн хэрэгжээгүй орлого		
2.1.3.11	Бусад санхүүгийн бус өр төлбөр		
2.1.3.12	Бусад санхүүгийн бус өр төлбөрийн дүн		
2.1.4	Хоёрдогч өглөг, хүү		
2.1.5	Давуу эрхийн хувьцаа (хөрвөхгүй)		
2.1.6	Орлогод тооцоогүй хураамжийн нөөц		
2.1.7	Нөхөн төлбөрийн нөөц сан		
2.1.7.1	Учирсан боловч мэдэгдээгүй хохирлын нөөц сан		
2.1.7.2	Мэдсэн боловч төлөөгүй хохирлын нөөц сан		
2.1.7.3	Учирч болзошгүй хохирлын нөөц сан		
2.1.7.4	Нөхөн төлбөрийн нөөц сангийн дүн		
2.1.9	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН		
2.2	ЭЗДИЙН ӨМЧ		
2.2.1	Эзэмшигчдийн өмч		
2.2.2	Нэмж төлөгдсөн капитал		
2.2.3	Тогтвортой байдлын сан		
2.2.4	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл		
2.2.5	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		
2.2.6	Эздийн өмчийн бусад хэсэг		
2.2.7	Хуримтлагдсан ашиг, алдагдал		
2.2.7	ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН		
2.3	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН		

ЗАХИРАЛ.....(.....)

гарын үсгийн тайлал

ЕРӨНХИЙ НЯГТЛАН

БОДОГЧ.....(.....)

гарын үсгийн тайлал

ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

/компанийн нэр/

20...оны.....сарын.....өдөр

(төгрөг, мөнгөөр)

№	Үзүүлэлт	... оны 12-р сарын 31	... оны 12-р сарын 31
1	Даатгалын үйл ажиллагаа		
2	Даатгалын хураамжийн нийт орлого		
3	Даатгалын хураамжийн буцаалт (-)		
4	Давхар даатгалын хураамжийн зардал (-)		
5	Даатгалын хураамжийн цэвэр орлого (2+3+4)		
6	Орлогод тооцоогүй хураамжийн нөөцийн өөрчлөлт (+, -)		
7	Хойшлуулсан давхар даатгалын хураамжийн өөрчлөлт (+,-)		
8	Орлогод тооцсон хураамж (5-6-7)		
9	Нийт нөхөн төлбөрийн зардал		
10	Давхар даатгагчийн хариуцсан нөхөн төлбөр (+)		
11	Буруутай этгээдээс авах нөхөн төлбөр (+)		
12	Нөхөн төлбөрийн цэвэр зардал (9-10-11)		
13	Нөхөн төлбөрийн нөөцийн сангийн өөрчлөлт (+, -)		
14	Нөхөн төлбөрийн нөөцийн сангийн давхар даатгагчид ногдох хэсгийн өөрчлөлт (+, -)		
15	Учирч болзошгүй хохирлын нөөцийн сангийн өөрчлөлт (+,-)		
16	Зардалд тооцсон нөхөн төлбөр (12+13+14+15)		
17	Даатгалын гэрээний зардал (-)		
18	Давхар даатгалын шимтгэлийн орлого (+)		
19	Хөрөнгө оруулалтын орлого (+)		
20	Даатгалын үйл ажиллагааны ашиг (алдагдал) (8-16+17+18+19)		
21	Түрээсийн орлого (+)		
22	Эрхийн шимтгэлийн орлого (+)		
23	Бусад орлого (+)		
24	Ерөнхий ба удирдлагын зардал (-)		
25	Борлуулалт, маркетингийн зардал (-)		
26	Санхүүгийн зардал (-)		
27	Бусад зардал (-)		
28	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз) (+, -)		
29	Биет болон биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз) (+, -)		
30	Бусад ашиг (алдагдал) (20+21+...+29)		
31	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал) (20+30)		
32	Орлогын татварын зардал		
33	Татварын дараах ашиг (алдагдал) (31-32)		
34	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал) (+,-)		
35	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) (33+34)		
36	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
37	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
38	Бусад		
39	Орлогын нийт дүн (35+36+37)		
40	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

ЗАХИРАЛ.....(.....)

гарын үсгийн тайлал

ЕРӨНХИЙ НЯГТЛАН

БОДОГЧ.....(.....)

гарын үсгийн тайлал

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/компанийн нэр/

20....оны.....сарын.....өдөр
(төгрөг, мөнгөөр)

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Нэмж төлөгдсөн капитал	Тогтвортой байдлын сан	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	20.... оны ...-р сарын ...-ний үлдэгдэл								
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга								
3	Залруулсан үлдэгдэл								
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)								
5	Бусад дэлгэрэнгүй орлого								
6	Өмчид гарсан өөрчлөлт								
7	Зарласан ногдол ашиг								
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн								
9	20.... оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл								
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга								
11	Залруулсан үлдэгдэл								
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)								
13	Бусад дэлгэрэнгүй орлого								
14	Өмчид гарсан өөрчлөлт								
15	Зарласан ногдол ашиг								
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн								
17	20.... оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл								

ЗАХИРАЛ.....(.....)
гарын үсгийн тайлал

ЕРӨНХИЙ НЯГТЛАН
БОДОГЧ.....(.....)
гарын үсгийн тайлал

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/компанийн нэр/

20....оны.....сарын.....өдөр

(төгрөг, мөнгөөр)

№	ҮЗҮҮЛЭЛТ	... оны 12-р сарын 31	... оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)		
1.1.1	Даатгалын хураамжийн орлого		
1.1.2	Давхар даатгалын нөхөн төлбөр		
1.1.3	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
1.1.4	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		
1.1.5	Буцаан авсан албан татвар		
1.1.6	Татаас, санхүүжилтийн орлого		
1.1.7	Бусад мөнгөн орлого		
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)		
1.2.1	Ажиллагчдад төлсөн		
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн		
1.2.3	Ашиглалтын зардалд төлсөн		
1.2.4	Давхар даатгагчид төлсөн давхар даатгалын хураамж		
1.2.5	Нөхөн төлбөрт төлсөн		
1.2.6	Үүнээс: Сайн дурын даатгалын		
1.2.7	Албан журмын даатгалын		
1.2.8	Даатгалын төлөөлөгчийн шимтгэл		
1.2.9	Даатгалын зуучлагчид төлсөн төлбөр		
1.2.10	Даатгалын хохирол үнэлэгчид төлсөн төлбөр		
1.2.11	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн		
1.2.12	Хүүний төлбөрт төлсөн		
1.2.13	Татварын байгууллагад төлсөн		
1.2.14	Даатгалын төлбөрт төлсөн		
1.2.15	Бусад мөнгөн зарлага		
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)		
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
2.1.3	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		
2.1.4	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого		
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого		
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг		
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)		
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		

2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)		
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
3.1.2	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
3.1.3	Төрөл бүрийн хандив		
3.1.4			
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)		
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
3.2.3	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн		
3.2.4	Төлсөн ногдол ашиг		
3.2.5			
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

ЗАХИРАЛ.....(.....)
гарын үсгийн тайлал

ЕРӨНХИЙ НЯГТЛАН
БОДОГЧ.....(.....)
гарын үсгийн тайлал

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

/компанийн нэр/

20....оны.....сарын.....өдөр

Үндсэн үйл ажиллагааны чиглэл /төрөл/:

- (a) _____
- (б) _____
- (в) _____

Туслах үйл ажиллагааны чиглэл /төрөл/:

- (a) _____
- (б) _____
- (в) _____

Салбар, төлөөлөгчийн газрын нэр, байршил:

- (a) _____
- (б) _____
- (в) _____

1. ТАЙЛАН БЭЛТГЭХ ҮНДЭСЛЭЛ

.....

.....

.....

.....

.....

.....

.....

2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГЫН ӨӨРЧЛӨЛТ

.....

.....

.....

.....

.....

.....

.....

3. МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	Бэлэн мөнгөний дүн		
	Касс дахь бэлэн мөнгө		
	Замд яваа мөнгө		
2	Харилцахад байгаа мөнгөний дүн		
	Дотоодын банк дахь харилцах		
	банк (дансны дугаар, дансны төрөл)		
	банк (дансны дугаар, дансны төрөл)		
	Гадаадын банк дахь харилцах		
	банк (дансны дугаар, дансны төрөл)		
	банк (дансны дугаар, дансны төрөл)		
	Дотоодын банкинд байгаа хугацаагүй хадгаламж		
	банк (дансны дугаар, дансны төрөл)		
	банк (дансны дугаар, дансны төрөл)		
3	Банк санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгийн дүн		
	Дотоодын санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө (3 с араас бага хугацаатай)		
	санхүүгийн байгууллага (дансны дугаар, дансны төрөл)		
	санхүүгийн байгууллага (дансны дугаар, дансны төрөл)		
	Гадаадын санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө (3 сараас бага хугацаатай)		
	санхүүгийн байгууллага (дансны дугаар, дансны төрөл)		
	санхүүгийн байгууллага (дансны дугаар, дансны төрөл)		
	Дотоодын банкинд байгаа хадгаламж, хадгаламжийн сертификат (3 хүртэл сарын хугацаатай)		
	банк (дансны дугаар, дансны төрөл)		
	банк (дансны дугаар, дансны төрөл)		
	Гадаадын банкинд байгаа хадгаламж, хадгаламжийн сертификат (3 хүртэл сарын хугацаатай)		
	банк (дансны дугаар, дансны төрөл)		
	банк (дансны дугаар, дансны төрөл)		
	Засгийн газрын үнэт цаас (3 хүртэл сарын хугацаатай)		
	Монгол банкнаас гаргасан үнэт цаас (3 хүртэл сарын хугацаатай)		
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгөнд хуримтлуулж тооцсон хүүгийн авлага		
5	МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН НИЙТ ДҮН		

Тэмдэглэл. (Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгөтэй холбоотой тайлбар, тэмдэглэлийг хийнэ)

.....
.....
.....

4. ДААТГАЛЫН АВЛАГА

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Нэмэгдсэн	Хасагдсан	Үүнээс		Эцсийн үлдэгдэл
					Төлөгдсөн	Найдваргүй болсон	
1	Даатгалын хураамжийн авлага						
2	Буруутай этгээдээс авах авлага						
3	Давхар даатгагчаас авах нөхөн төлбөрийн авлага						
4	Давхар даатгагчаас авах хураамжийн авлага						
5	Давхар даатгагчаас авах шимтгэлийн авлага						
6	Дүн						

Тэмдэглэл. (Холбоотой талаас авах даатгалын авлагыг тодруулна, Даатгалын авлагын үлдэгдэгарсан өөрчлөлтийг тайлбарлана. Гадаад валютаар илэрхийлэгдсэн авлагын талаар болон бусад тайлбар, тэмдэглэлийг хийнэ.)

.....

.....

.....

5. БУСАД САНХҮҮГИЙН БА САНХҮҮГИЙН БУС ХӨРӨНГӨ

5.1. БУСАД САНХҮҮГИЙН ХӨРӨНГӨ

5.1.1. Бусад авлага

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Нэмэгдсэн	Хасагдсан	Үүнээс		Эцсийн үлдэгдэл
					Төлөгдсөн	Найдваргүй болсон	
1	Бусад авлага						
2	Холбоотой талаас авах авалага						
3	Бусад авлагын нийт дүн						

Тэмдэглэл: (Холбоотой талаас авах авлагыг тодруулна, Бусад авлага, холбоотой талаас авах авлагын үлдэгдэлд гарсан өөрчлөлтийг тайлбарлана. Гадаад валютаар илэрхийлэгдсэн авлагын талаар болон бусад тайлбар, тэмдэглэлийг хийнэ.)

.....

.....

.....

.....

5.2. БУСАД САНХҮҮГИЙН БУС ХӨРӨНГӨ

- 2.7.6 Хөрөнгө оруулалт: Дотоод болон гадаадын банк санхүүгийн байгууллагад байршуулсан 3 сараас дээш хугацаатай хадгаламж, хадгаламжийн сертификат, мөн тэдгээрт хуримтлуулж тооцсон хүүгийн авлага, Засгийн газрын өрийн хэрэгсэл, Төв банкны үнэт цаас, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас, Орон нутгийн гаргасан өрийн бичиг, Компанийн бонд, ХБ-ийн I ба II ангиллын хувьцаа, вексель, хөрөнгө оруулалтын сангийн үнэт цаас /нэгж эрх/, гадаадын үнэт цаас, холбогдох этгээдээс бусад этгээдэд үл хөдлөх хөрөнгө барьцаасан богино хугацаат зээл, санхүүгийн түрээс, деривативт олон төрлийн гэрээ, хэлцэл, санхүүгийн хэрэгсэл бүхий гадаад валют, үнэт металлыг худалдах буюу худалдан авах форвард, своп, опшин, фьючерс хамруулна.
- 2.7.7 Бусад санхүүгийн хөрөнгө: Даатгалын үйл ажиллагааны хувьд туслах чанартай бөгөөд нийт хөрөнгийн дүнд бага хувь хэмжээтэй, санхүүгийн хөрөнгийн тодорхойлолтыг хангаж буй хөрөнгүүд болох бусад тооцооны авлага, салбар хоорондын тооцоо, бусад санхүүгийн хөрөнгийг хамруулна.
- 2.7.8 Бусад санхүүгийн бус хөрөнгө: Даатгалын үйл ажиллагааны хувьд туслах чанарын бөгөөд нийт хөрөнгийн дүнд бага хувь хэмжээтэй, санхүүгийн хөрөнгийн тодорхойлолтыг хангахгүй хөрөнгүүд болох тайлант хугацааны татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн илүү төлөлт бараа материал, урьдчилж төлсөн зардал/тооцоо, санхүүгийн бус хөрөнгийн хэлбэртэй өмчлөх бусад хөрөнгө, хойшлогдсон татварын хөрөнгийг хамруулна. Өмчлөх бусад хөрөнгөнд зээлдэгчдээс зээлийн төлбөрт авсан болон нөхөн төлбөрийн тооцоонд авсан, цаашид худалдан борлуулах зориулалттай хөдлөх ба үл хөдлөх хөрөнгө багтана.
- 2.7.9 Үндсэн хөрөнгө: Даатгалын ажил, үйлчилгээ үзүүлэх, бусдад түрээслүүлэх эсвэл захиргааны зориулалтаар ашиглах үүднээс даатгалын компани эзэмшиж байгаа бөгөөд нэгээс дээш жилээр ашиглагдаж буй газрын сайжруулалт, барилга байгууламж, машин тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл, тавилга, эд хогшил, компьютер, түүний дагалдах хэрэгсэл, санхүүгийн түрээсийн хөрөнгө, дуусаагүй барилга зэргийг хамарна.
- 2.7.10 Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө: Хөрөнгийн үнийг өсгөх, түрээсийн орлого олох зорилгоор эзэмшиж, өмчилж буй хөрөнгийг хэлэх бөгөөд компанийн үйл ажиллагаа, удирдлагын зорилгоор ашиглагдаагүй үл хөдлөх хөрөнгийг харуулна. Компани ашгийн бус зорилгоор буюу холбогдох зардлаа нөхөхийн тулд хөрөнгө оруулалтын зориулалттай хөрөнгийг эзэмшиж, өмчилж болно.

- 2.7.11 Биет бус хөрөнгө: Нэгээс дээш жилийн хугацаанд ашиглах компанийн үйл ажиллагаа, удирдлагын зориулалтаар ашиглаж буй биет шинж чанаргүй тодорхойлж болохуйц, мөнгөөр илэрхийлэгдээгүй, материаллаг дүнтэй зохиогчийн эрх, программ хангамж, патент, барааны тэмдэг, тусгай зөвшөөрөл, газар эзэмших эрх, бусад биет бус хөрөнгө зэрэг хамаарна.
- 2.8 Өр төлбөрийн дараах зүйлсийг тусад нь толилуулна:
- 2.8.1 Даатгалын компанийн үндсэн үйл ажиллагаатай холбоотой үүссэн өглөг буюу даатгалын хураамжийн буцаалтын өглөг, нөхөн төлбөрийн өглөг, даатгалын гэрээний шимтгэлийн өглөг, давхар даатгагчид өгөх өглөг хамаарна.
- 2.8.2 Бусад санхүүгийн өр төлбөр: Даатгалын компанийн үйл ажиллагааны хувьд туслах чанартай бөгөөд нийт өр төлбөрийн дүнд бага хувь хэмжээтэй, санхүүгийн өр төлбөрийн тодорхойлолтыг хангаж буй өр төлбөр ба үүнд зээлийн өглөг, өрийн бичиг, санхүүгийн түрээсийн өр төлбөр, ногдол ашгийн өглөг, деривативын өр төлбөр, бусад санхүүгийн өр төлбөр, салбар хоорондын тооцооны өглөг хамрагдана.
- 2.8.3 Бусад санхүүгийн бус өр төлбөр: Даатгалын компанийн үйл ажиллагааны хувьд туслах чанартай бөгөөд нийт өр төлбөрийн дүнд бага хувь хэмжээтэй, санхүүгийн өр төлбөрийн тодорхойлолтыг хангахгүй өр төлбөр ба үүнд: цалингийн өглөг, НДШ-ийн өглөг, бусад татварын өглөг, ААНОАТ-ын өглөг, хойшлогдсон татварын өглөг, урьдчилж орсон орлого, нийгмийн хөгжлийн сангийн өр төлбөр, хуулийн байгууллагаар шийдэгдэж байгаа зүйлсийн өр төлбөр, мөнгөөр төлөгдөх хувьцааны опцион, тэтгэврийн сангийн өр төлбөр, санхүүгийн түрээсийн хэрэгжээгүй орлого, бусад санхүүгийн бус өр төлбөр зэрэг хамрагдана.
- 2.8.4 Хоёрдогч өглөг: Санхүүгийн эх үүсвэр болгож хөрөнгө оруулагчдаас татан төвлөрүүлсэн хөрөнгө бөгөөд хувьцаагаар солих талаар холбогдох гэрээнд заасан өрийн бичгийг хэлнэ. Энэ нь өр төлбөрийн шинжийг хадгалсан хэвээр байдаг тул үүнийг санхүүгийн тайланд өр төлбөрөөр толилуулна.
- 2.8.5 Давуу эрхийн хувьцаа (өр төлбөр): НББОУС 32-д заасны дагуу өр төлбөр гэж үзэх давуу эрхийн хувьцааг өр төлбөрөөр толилуулна.
- 2.8.6 Орлогод тооцоогүй хураамжийн нөөц: Орлогод тооцоогүй хураамжийн нөөц (ОТХН) нь даатгалын гэрээний хугацаанаас хамааруулан орлогыг хувь тэнцүүлэн хуваарилах ба тайлант хугацаанд орлогод хүлээн зөвшөөрөгдөөгүй хураамжийн орлого байна.
- 2.8.7 Нөхөн төлбөрийн нөөц сан нь Учирсан боловч мэдэгдээгүй хохирлын нөөц сан (УБМХНС), Мэдсэн боловч төлөөгүй хохирлын нөөц сан (МБТХНС), Учирч болзошгүй хохирлын нөөц сан (УБХНС)-гуудаас бүрдэнэ.
- 2.8.7.1 Учирсан боловч мэдэгдээгүй хохирлын нөөц сан (УБМХНС) гэдэгт тайлагналын өдөр болон түүнээс өмнөх хугацаанд даатгалын тохиолдол нь болсон боловч даатгагчид мэдэгдээгүй байгаа даатгалын нөхөн төлбөрийг барагдуулахад шаардагдах дүнг ойлгоно.
- 2.8.7.2 Мэдсэн боловч төлөөгүй хохирлын нөөц сан (МБТХНС) гэдэгт даатгалын тохиолдол болсон тухай даатгагч мэдсэн болон төлөөгүй байгаа нөхөн төлбөрийг барагдуулахад шаардагдах дүнг ойлгоно.
- 2.8.7.3 Учирч болзошгүй хохирлын нөөц сан (УБХНС) гэдэгт тайлангийн хугацаанд даатгалын нөхөн төлбөрийн бодит түвшин нь тооцоолсон нөхөн төлбөрөөс давсан тохиолдолд тухайн хэсгийг нөхөн төлөхөд зориулсан нөөц санг ойлгоно.
- 2.9 Өөрийн хөрөнгийн дараах зүйлсийг тусад нь толилуулна:
- 2.9.1 Эздийн өмч буюу өөрийн хөрөнгө нь компанийн бүх өр төлбөрийг барагдуулсны дараа үлдэх хөрөнгө юм.
- 2.9.2 Хувьцаа: Компанид хөрөнгө оруулж, түүнийг үндэслэн санал өгөх, ногдол ашиг авах, компанийг татан буулгахад түүний эд хөрөнгөөс тодорхой хэсгийг өмчлөх эрхийг гэрчилж буй үнэт цаас юм. Хувьцаа нь энгийн болон давуу эрхийн хувьцаа гэсэн хоёр төрөлтэй байна.
- 2.9.3 Хувь нийлүүлсэн хөрөнгө: Даатгалын компаниас гаргасан нийт давуу эрхийн болон энгийн хувьцааны (НББОУС 32-ын дагуу өмчийн шалгуурыг хангасан) нэрлэсэн үнийн дүнг хэлнэ.
- 2.9.4 Нэмж төлөгдсөн капитал гэж хувьцааны нэрлэсэн үнээс илүү төлөгдсөн зөрүүг хэлнэ.
- 2.9.5 Халаасны хувьцаа: Даатгалын компанийн гаргасан хувьцаанаасаа эргүүлэн худалдан авсан хувьцааг хэлнэ.
- 2.9.6 Хуримтлагдсан ашиг: Үйл ажиллагаа эхэлсэн үеэс хуримтлагдаж, ногдол ашиг хуваарилах буюу сан байгуулсны дараа үлдэж буй цэвэр ашиг юм.

- 2.9.7 Бусад өөрийн хөрөнгө: Тусгай зориулалтын сан, тогтвортой байдлын сан, хувьцаанд суурилсан төлбөр, хувьцаа эзэмшигчдээс оруулсан бусад хөрөнгө, гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц, бусад өөрийн хөрөнгөөс бүрдэнэ.

ГУРАВ. ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

- 3.1. Орлогын дэлгэрэнгүй тайлан нь даатгалын компанийн тайлант хугацааны үйл ажиллагааны үр дүнг хэмждэг тайлан юм. Орлогын дэлгэрэнгүй тайланд орлого, зардлыг аккрузал сууриар бүртгэж, толилуулна.
- 3.2. Үйл ажиллагааны үр дүнг хэмжихтэй холбогдох элементүүд нь орлого, зардал, олз, гарз болно.
- 3.2.1 Орлого гэдэг нь тайлант хугацаанд хөрөнгийн дотогшлох урсгал болон хөрөнгийн сайжруулалт, эсвэл хувь нийлүүлэгчдээс оруулсан хөрөнгөтэй холбоогүйгээр өөрийн хөрөнгийг нэмэгдүүлж, өр төлбөрийг бууруулах хэлбэрээр гарах эдийн засгийн үр өгөөжийн өсөлт юм. Орлогын дүнг найдвартайгаар хэмжих боломжтой тохиолдолд орлогын тайланд орлого болон олзыг хүлээн зөвшөөрнө. Найдвартай хэмжих боломжгүй бол бүртгэхгүй.
- 3.2.2 Зардал гэдэг нь хувьцаа эзэмшигчдэд олгосон хуваарилалттай холбоогүй, өөрийн хөрөнгийг бууруулж буй хөрөнгийн хорогдол буюу гадагшлах урсгал эсвэл өр төлбөр үүсэх зэрэг хэлбэрээр тайлант хугацаанд бий болсон эдийн засгийн өгөөжийн бууралт юм. Зардлын дүнг найдвартайгаар хэмжих боломжтой тохиолдолд орлогын тайланд зардал болон гарзыг хүлээн зөвшөөрнө. Найдвартай хэмжих боломжгүй бол бүртгэхгүй.
- 3.3. Зардлыг холбогдох орлоготой уялдуулан орлогын тайланд хүлээн зөвшөөрөх ба үүнийг орлого, зардлыг уялдуулах зарчим гэнэ. Ингэж орлого, зардлыг уялдуулснаар аливаа зүйл эсвэл ажил гүйлгээний орлого, зардлыг хамтад нь тайлагнаж, үр дүнг нь тодорхойлон гаргах ач холбогдолтой. Гэхдээ СТОУС-ын дагуу уялдуулах зарчмыг мөрдөхдөө хөрөнгө, өр төлбөрийн тодорхойлолтонд нийцэхгүй зүйлсийг балансанд хүлээн зөвшөөрч, харуулахгүй.
- 3.4. Орлогын дэлгэрэнгүй тайланг СТ-2 загварын дагуу бэлтгэнэ. Орлогын дэлгэрэнгүй тайлангийн үзүүлэлтүүдийг дүнгээр үзүүлэх ба орлого, зардлын бус шинжтэй зүйлийг орлогын тайланд тусгахгүй. Өмнөх хугацааны дүнг тайлант хугацааныхтай яг ижил хугацаагаар тасалбар болгон харуулна. Тухайлбал, орлогын дэлгэрэнгүй тайланг 6 дугаар сарын 30-аар бэлтгэж байгаа тохиолдолд толилуулах дүн нь тайлант ба өмнөх хугацааны аль алиных нь хувьд оны эхнээс (1 дүгээр сарын 1-ний өдөр) 6 дугаар сарын 30ны (тайлагналын өдөр) хоорондох хугацаагаар тасалбар болно.
- 3.5. Даатгалын компани орлого, зардлыг үндсэн төрлөөр ангилан орлогын дэлгэрэнгүй тайлан бэлтгэж, тодруулна.
- 3.6. СТОУС бусад стандартуудын шаардлагыг хангах үүднээс орлогын тайлангийн доор дурдсан орлого ба зардлын үзүүлэлтийг эдгээр ангиллаар хязгаарлахгүйгээр оруулна.
- 3.6.1 Даатгалын компанийн үйл ажиллагаанаас буй болох орлогын үндсэн төрөлд даатгалын хураамжийн орлого, давхар даатгалын шимтгэлийн орлого, давхар даатгагчийн хариуцсан нөхөн төлбөр, буруутай этгээдийн хариуцсан нөхөн төлбөр, хөрөнгө оруулалтын орлого зэрэг орно.
- 3.6.1.1 Даатгалын хураамжийн орлого нь даатгалын компанийн тайлант хугацаанд хийсэн даатгалын гэрээний дагуу даатгуулагчаас төлсөн нийт хураамжийн орлогын дүн байна.
- 3.6.1.2 Давхар даатгалын шимтгэлийн орлогод давхар даатгагчаас давхар даатгалын борлуулалтын шимтгэл хэлбэрээр даатгагчид буцаан төлсөн төлбөрийн тайлант хугацаанд орлогоор хүлээн зөвшөөрөгдөх хэсэг хамаарна. Давхар даатгалын шимтгэлийн орлого орж ирсэн үед нь урьдчилж орсон орлогоор хүлээн зөвшөөрч давхар даатгалын хураамжийн хүлээн зөвшөөрөлттэй уялдуулан тайлант үеийн орлогоор хүлээн зөвшөөрнө.
- 3.6.1.3 Давхар даатгагчийн хариуцсан нөхөн төлбөр гэдэгт даатгалын тохиолдол болсон нөхцөлд гэрээнд заасны дагуу давхар даатгагчаас даатгагчид төлсөн болон төлөхөөр тооцсон нөхөн төлбөр хамаарна.
- 3.6.1.4 Даатгуулагчид учирсан хохирлын нөхөн төлбөрийг буруутай этгээдээр төлүүлсэн болон төлөхөөр тохирсон дүнгээр буруутай этгээдийн хариуцсан нөхөн төлбөрийн орлого болгоно.
- 3.6.1.5 Нөөц сангийн хөрөнгө, дүрмийн сангийн хөрөнгө болон тайлант үед хийх төлбөрийн хэмжээнээс давсан сул чөлөөтэй хөрөнгийг аливжуулах зорилгоор байршуулснаар олох орлого, олзыг хөрөнгө оруулалтын орлого гэж ойлгоно.

- 3.6.2 Даатгалын компанийн үйл ажиллагаанаас буй болох зардлын үндсэн төрөлд давхар даатгалын хураамж, даатгалын хураамжийн буцаалт, даатгалын гэрээний зардал зэрэг орно.
- 3.6.2.1 Даатгагч нь даатгуулагчийн өмнө хүлээсэн үүргээ бүрэн буюу хэсэгчлэн дахин даатгаж төлж байгаа болон төлөхөөр тооцсон төлбөр давхар даатгалын хураамжид хамаарна.
 - 3.6.2.2 Даатгалын хураамжийн буцаалт нь даатгалын гэрээ цуцлагдахад гэрээний үлдэх хугацаанд ногдох хураамжаас гэрээнд заасны дагуу даатгуулагчид өгөх даатгалын хураамж юм.
 - 3.6.2.3 Даатгалын гэрээний зардалд даатгалын төлөөлөгчийн шимтгэл, даатгалын зуучлагчийн төлбөрийн тайлант хугацаанд зардлаар хүлээн зөвшөөрөгдөх хэсэг хамаарна. Даатгалын төлөөлөгчийн шимтгэл, даатгалын зуучлагчийн төлбөрийг төлсөн үед даатгалын орлогын хойшлогдсон шимтгэлийн зардлаар хүлээн зөвшөөрч, холбогдох хураамжийг орлогоор хүлээн зөвшөөрсөн хувь хэмжээгээр зардлаар хүлээн зөвшөөрнө.
- 3.6.3 Даатгалын компанийн үндсэн үйл ажиллагааны ашиг болон алдагдалд дараах өөрчлөлтүүд нь нөлөөлнө. Үүнд: орлогод тооцоогүй хураамжийн нөөцийн өөрчлөлт, хойшлогдсон давхар даатгалын хураамжийн өөрчлөлт, нөхөн төлбөрийн нөөц сангийн өөрчлөлт, нөхөн төлбөрийн нөөц сангийн давхар даатгагчид ногдох хэсгийн өөрчлөлт, УБХНСангийн өөрчлөлт зэрэг байна. Эдгээр өөрчлөлтүүдийн үлдэгдэл нь эерэг (+) утгатай байвал үндсэн үйл ажиллагааны ашгийг нэмэгдүүлэх ба сөрөг (-) утгатай байвал үндсэн үйл ажиллагааны ашгийг бууруулна.
- 3.6.3.1 Орлогод тооцоогүй хураамжийн нөөцийн өөрчлөлт: Орлогод тооцоогүй хураамжийн нөөцийн дансны тайлант үеийн үлдэгдлээс эхний үлдэгдлийг хасч Орлогод тооцоогүй хураамжийн нөөцийн өөрчлөлтийг тодорхойлно.
 - 3.6.3.2 Хойшлогдсон давхар даатгалын хураамжийн өөрчлөлт: Орлогод тооцоогүй хураамжийн нөөцийн давхар даатгагчид ногдох хэсэг дансны тайлант үеийн үлдэгдлээс эхний үлдэгдлийг хасч хойшлогдсон давхар даатгалын хураамжийн өөрчлөлтийг тодорхойлно.
 - 3.6.3.3 Орлогод тооцсон хураамжийн орлого: Даатгалын хураамжийн орлогын цэвэр дүнгээс давхар даатгалын хураамж, орлогод тооцоогүй хураамжийн нөөцийн өөрчлөлт болон хойшлогдсон давхар даатгалын хураамжийн өөрчлөлтийг хасч орлогод тооцсон хураамжийн орлогыг тодорхойлно.
 - 3.6.3.4 Нөхөн төлбөрийн нөөц сангийн өөрчлөлт: Учирсан боловч мэдэгдээгүй хохирлын нөөц сан, Мэдсэн боловч төлөөгүй хохирлын нөөц сангуудын тайлант үеийн өөрчлөлт хамаарна. Дээрхи нөөц сангуудын тайлант үеийн үлдэгдлээс тайлант үеийн эхний үлдэгдлийг хасч нөөц сангуудын өөрчлөлтийг тодорхойлно.
 - 3.6.3.5 Нөхөн төлбөрийн нөөц сангийн давхар даатгагчид ногдох хэсгийн өөрчлөлт: Нөхөн төлбөрийн нөөц сангийн давхар даатгагчид ногдох хэсгийн тайлант үеийн өөрчлөлт хамаарна. Нөхөн төлбөрийн нөөц сангийн давхар даатгагчид ногдох хэсгийн тайлант үеийн үлдэгдлээс тайлант үеийн эхний үлдэгдлийг хасч энэхүү өөрчлөлтийг тодорхойлно.
 - 3.6.3.6 УБХНСангийн өөрчлөлт: Учирч болзошгүй хохирлын нөөц сангийн тайлант үеийн үлдэгдлээс тайлант үеийн эхний үлдэгдлийг хасч өөрчлөлтийг тодорхойлно.
- 3.6.4 Даатгалын үндсэн үйл ажиллагаанаас үүсэх ашиг (алдагдал) нь даатгалын үндсэн үйл ажиллагаанаас бий болсон орлого мөн зардлын зөрүүгээр тодорхойлогдоно.
- 3.6.5 Бусад орлого: Даатгалын үйл ажиллагаанаас орох орлогоос бусад бүх орлого хамрагдана. Үүнд: түрээсийн орлого, эрхийн шимтгэлийн орлого түүний хүү, бусад орлого зэрэг байна. Үйл ажиллагааны бус бусад орлогод гадаад валютын ханшийн зөрүүний олз, биет ба биет бус хөрөнгө борлуулсны болон данснаас хассаны олз, үндсэн хөрөнгийн түрээсийн орлого, торгуулийн олз, ногдол ашгийн орлого, тэнцлийн гадуурх тооцооноос хийгдсэн төлөлт, бусад орлого, олзыг хамарна.
- 3.6.6 Бусад зардал: Даатгалын үйл ажиллагааны зардлын үндсэн төрөлд хамаарахгүй даатгалын үйл ажиллагааг хэвийн явуулахад дэмжих нэгжийн зардлууд байна. Уг зардлыг ерөнхий ба удирдлагын, борлуулалт маркетингийн, санхүүгийн, үйл ажиллагааны бусад зардал болон үйл ажиллагааны бус зардал гэсэн бүлэгтэй байна.
- 3.6.6.1 Ерөнхий ба удирдлагын зардал, Борлуулалт маркетингийн зардал: Ажилтнуудтай холбоотой цалин, шагнал урамшуулал, нийгмийн

даатгалын шимтгэлийн зардал байна. Татвар төлбөр хураамжийн зардалд хуулийн дагуу төлж буй бүх төрлийн татвар, хураамж, төлбөр, даатгалын зохицуулалт үйлчилгээний зардал; томилолт нь дотоод, гадаад томилолт; бичиг хэргийн зардалд хэвлэх, олшруулах төхөөрөмжийн хор, даатгалын гэрээт баталгаа, даатгалын маягт, санхүүгийн маягт, цаас, бичгийн хэрэгсэлийн зардал; шуудан холбооны зардал хэсэгт байгууллагад ашиглагдаж буй интернет, суурин болон үүрэн утасны зардал мөн бусад шуудан холбооны зардлын шинжтэй зардал; мэргэжлийн үйлчилгээний зардалд аудитын үйлчилгээ, мэргэжлийн зөвлөх үйлчилгээ, хууль эрх зүйн үйлчилгээ, авлага болон буруутай этгээдээс авлага барагдуулахтай холбоотой зардал, бусад бусдаар гүйцэтгүүлсэн зардал; гадаад, дотоодын сургалтын зардал; мэргэжлийн ном, сонин сэтгүүлийн зардал; албан ба сайн дурын даатгалын зардал; цахилгаан дулаан, цэвэр бохир ус, бусад ажлын байрны ашиглалттай холбоотой ашиглалтын зардал; газрын сайжруулалттай холбоотой урсгал зардал, барилга байгууламжийн урсгал засвар /капиталжихгүй/, машин механизм, тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэлийн засвар үйлчилгээ, хэвлэх, хувилах төхөөрөмж, компьютер дагалдах хэрэгсэлийн засвар үйлчилгээний зардал, санхүүгийн түрээсийн зардал зэрэг засвар үйлчилгээтэй холбогдох гарах зардал; элэгдэл хорогдолын зардал; түрээсийн зардал; харуул хамгаалалтын зардал; цэвэрлэгээ үйлчилгээний зардал, тээврийн зардал; шатахууны зардал; хүлээн авалт баяр ёслол, биеийн тамир, соёлын арга хэмжээний зардал, бэлэг дурсгалын зардал; зар сурталчилгааны зардал гэх зардлууд хамаарна.

3.6.6.2 Санхүүгийн зардал: хүүгийн зардал, санхүүгийн түрээсийн хүүгийн зардал, санхүүгийн байгууллагын шимтгэл хураамжийн зардал.

3.6.6.3 Үйл ажиллагааны бусад зардал.

3.6.6.4 Үйл ажиллагааны бус зардал: Үндсэн бус үйл ажиллагаатай холбогдон гарсан зардал байна. Үүнд: хандив тусламжийн зардал; СЗХ-ны “Даатгалын компанийн активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-ын дагуу активт байгуулсан эрсдлийн сангийн зардлууд; болзошгүй өр төлбөрөөс үүссэн гарз, бондын эргэлтээс гаргалтын гарз; үйл ажиллагааны бус бусад зардлууд хамаарна.

3.6.7 Орлогын татварын зардал: тайлант хугацааны татвар ногдуулах орлогыг тодорхойлж, түүнд ногдуулж тооцсон татварын зардал (хөнгөлөлт)-ыг энэ хэсэгт тусгана.

3.6.8 Зогсоосон үйл ажиллагааны цэвэр орлого, зардал: СТОУС 5-ын дагуу зогсоосон үйл ажиллагаа гэж тодорхойлсон үйл ажиллагааны үр дүнд үүссэн орлого, зардлыг энэ хэсэгт тусгана.

3.6.9 3.6.9. Бусад дэлгэрэнгүй орлого: тайлант хугацааны цэвэр ашигт хамаарахгүй боловч эзэмшигчийн бус ажил гүйлгээгээр үүссэн хэрэгжээгүй орлого, зардал буюу үнэлгээний санд гарсан хэрэгжээгүй орлого, зардлыг харуулна. Татвар ногдуулах бүх орлого, зардалд хойшлогдсон татварыг хуримтлуулан бүртгэнэ.

3.6.10 Нийт дэлгэрэнгүй орлого: тайлант хугацаанд эзэмшигчийн бус ажил гүйлгээгээр цэвэр хөрөнгөнд гарсан нийт өсөлт, бууралтыг дараах хоёр үзүүлэлтээр төлөөлж харуулна: цэвэр ашиг, алдагдлын дүн (орлогын тайланд тодорхойлогдоно) ба бусад дэлгэрэнгүй орлого.

ДӨРӨВ. ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

4.1 Өмчийн өөрчлөлтийн тайлан нь даатгалын компанийн цэвэр хөрөнгө буюу эзэмшигчийн өмчийн хөдөлгөөнийг харуулдаг тайланг ойлгоно.

4.2 Өмчийн өөрчлөлтийн тайланд дараах зүйлсийг толилуулна:

4.2.1 тайлант хугацааны цэвэр ашиг, алдагдал;

4.2.2 хувьцаат капиталтай холбогдуулан шууд бүртгэсэн орлого, зардал, олз, гарз, холбогдох дансдын дүн;

4.2.3 нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулгын хуримтлагдсан нөлөөлөл;

4.2.4 эзэмшигчидтэй хийсэн өмчийн ажил гүйлгээ, тэдгээрийг эзэмшигчдэд хуваарилсан байдал;

4.2.5 тайлант хугацааны эхэнд болон санхүүгийн тайлагналын өдрөөрх хуримтлагдсан ашиг, алдагдлын үлдэгдэл, мөн хугацаанд гарсан өөрчлөлт;

- 4.2.6 тайлант хугацааны эх болон эцэс дэх эзэмшигчийн өмчийн ангилал тус бүрийн дансны үнэ, нэмж төлөгдсөн капитал, сангуудын тохируулга, өөрчлөлт.
- 4.3 Өмчийн өөрчлөлтийн тайланг СТ-3 загвараар бэлтгэнэ.
- 4.4 Өөрийн хөрөнгийн тайлант үеийн эхний үлдэгдлийг өмчийн ангилал бүрийн хувьд өмнөх үеийн эцсийн үлдэгдлээр тусгана.
- 4.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, үндсэн алдааны залруулгыг хуримтлагдсан ашгийн эхний үлдэгдлийг залруулах замаар тохируулж, залруулагдсан эхний үлдэгдлийг тодорхойлно.
- 4.6 Дараах зүйлсийн хөдөлгөөнийг тусад нь харуулна:
- 4.6.1 Эздийн өмч буюу өөрийн хөрөнгө нь компанийн бүх өр төлбөрийг барагдуулсны дараа үлдэх хөрөнгийг;
- 4.6.2 Нэмж төлөгдсөн капитал: хувьцааны нэрлэсэн үнээс илүү төлөгдсөн зөрүүг;
- 4.6.3 Тогтвортой байдлын сан: компани үндсэн үйл ажиллагаанаас ирээдүйд үүсч болзошгүй алдагдалыг санхүүжүүлэх зорилгоор хувь нийлүүлэгчдийн шийдвэрээр байгуулсан санг ойлгоно.
- 4.6.4 Дахин үнэлгээний нэмэгдэл: Үндсэн хөрөнгө болон борлуулахад бэлэн хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний өсөлт, бууралтыг өмчийн өөрчлөлтийн энэ хэсэгт тусгана.
- 4.6.5 Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц: дансны эхний болон эцсийн үлдэгдэл, тайлант хугацаанд гадаад үйл ажиллагааны хөрвүүлэлтээс, бүртгэлийн валютыг толилуулгын валют руу хөрвүүлснээс үүссэн валютын хөрвүүлэлтийн зөрүүг тодруулна.
- 4.6.6 Хувь нийлүүлсэн хөрөнгө: даатгалын компаниас гаргасан нийт давуу эрхийн болон энгийн хувьцааны нэрлэсэн үнийн дүнг;
- 4.6.7 Халаасны хувьцаа гэж даатгалын компанийн гаргасан хувьцаанаасаа эргүүлэн худалдан авсан хувьцааг;
- 4.6.8 Хуримтлагдсан ашиг: үйл ажиллагаа эхэлсэн үеэс хуримтлагдаж, ногдол ашиг хуваарилах буюу сан байгуулсны дараа үлдэж буй цэвэр ашгийг;
- 4.6.9 Бусад өөрийн хөрөнгө: тусгай зориулалтын сан, хувьцаанд суурилсан төлбөр, хувьцаа эзэмшигчдээс оруулсан бусад хөрөнгө, бусад өөрийн хөрөнгөөс бүрдэнэ.
- 4.7 Нийт өмчийн эхний үлдэгдэл дээр нийт нэмэгдсэн өөрчлөлтийн дүнг нэмж, нийт хасагдсан өөрчлөлтийн дүнгээр бууруулж, өмчийн эцсийн үлдэгдлийг тодорхойлно.

ТАВ. МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

- 5.1 Тайлант хугацааны мөнгөн хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийг мөнгөн гүйлгээний тайланд үзүүлнэ. Мөнгөн гүйлгээний тайлан нь санхүүгийн тайлангийн хэрэглэгчдийг мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийг бий болгох тухайн байгууллагын чадвар, эдгээр мөнгөн гүйлгээг ашиглах хэрэгцээг үнэлэх үндэс болно.
- 5.2 Мөнгөн гүйлгээний тайланг СТ-4 загвараар бэлтгэнэ. Зэрэгцүүлэх зорилгоор оруулж байгаа өмнөх хугацааны дүнг тайлант хугацааныхтай яг ижил хугацаагаар тасалбар болгон харуулна.
- 5.3 Мөнгөн гүйлгээний тайланг шууд аргаар бэлтгэнэ.
- 5.4 Мөнгөн гүйлгээний тайлан нь дор дурдсан хэсгүүдээс бүрдэнэ. Үүнд:
- 5.4.1 Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ;
- 5.4.2 Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ;
- 5.4.3 Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ;
- 5.4.4 Мөнгөн хөрөнгийн цэвэр өсөлт (бууралт).
- 5.5 **Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** нь тухайн даатгалын компанийн хувьд даатгуулагчид учирсан эрсдлийг нөхөн төлөх, бусад өр төлбөр төлөх, үйл ажиллагааны чадавхийг тогтоон барих, ногдол ашиг төлөх ба гадны санхүүжилтийн эх үүсвэрийн тусламжгүйгээр шинэ хөрөнгө оруулалт хийхэд хангалттай хүрэлцэх мөнгө бий эсэхийг илэрхийлдэг гол үзүүлэлт байна.
- 5.5.1 Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлогод:
- 5.5.1.1 Даатгалын хураамжийн орлого;
- 5.5.1.2 Давхар даатгалын хариуцсан нөхөн төлбөр;
- 5.5.1.3 Буруутай этгээдийн хариуцсан нөхөн төлбөр;
- 5.5.1.4 Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого;
- 5.5.1.5 Буцаан авсан албан татвар;
- 5.5.1.6 Улсаас авсан татаас, санхүүжилт;
- 5.5.1.7 Бусад мөнгөн орлого (тэнцлийн гадуурх тооцооноос хийгдсэн төлөлт гм) орно.
- 5.5.2 Үндсэн үйл ажиллагааны мөнгөн зарлагад:
- 5.5.2.1 Ажиллагчдад төлсөн;
- 5.5.2.2 Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн;

- 5.5.2.3 Бараа материал худалдан авахад төлсөн;
- 5.5.2.4 Ашиглалтын зардалд төлсөн;
- 5.5.2.5 Давхар даатгагчид төлсөн давхар даатгалын хураамж;
- 5.5.2.6 Нөхөн төлбөрт төлсөн;
- 5.5.2.7 Даатгалын төлөөлөгчийн шимтгэл;
- 5.5.2.8 Даатгалын зуучлагчид төлсөн төлбөр;
- 5.5.2.9 Даатгалын хохирол үнэлэгчид төлсөн төлбөр;
- 5.5.2.10 Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн;
- 5.5.2.11 Хүүний төлбөрт төлсөн;
- 5.5.2.12 Татварын байгууллагад төлсөн;
- 5.5.2.13 Бусад мөнгөн зарлага.
- 5.5.3 Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлого болон мөнгөн зарлагын зөрүүгээр үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээг тодорхойлно.
- 5.6 **Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** нь ирээдүйд олох орлого ба мөнгөн хөрөнгийг нэмэгдүүлэх зорилгоор нэмэлт хөрөнгө, нөөц бий болгоход зарцуулсан мөнгийг илэрхийлдэг. Хөрөнгө оруулалтын мөнгөн гүйлгээ нь урт хугацаанд ашиглагдах хөрөнгө болон мөнгөтэй адилтгах хөрөнгөнд ороогүй бусад хөрөнгө оруулалтыг олж эзэмших болон худалдах үйл ажиллагааг хамарна.
 - 5.6.1 Хөрөнгө оруулалтын мөнгөн орлогод:
 - 5.6.1.1 Үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгө болон бусад урт хугацаат хөрөнгө (тухайлбал ХОЗҮХХ, бусад санхүүгийн хөрөнгө) борлуулснаас;
 - 5.6.1.2 Урт болон богино хугацаат хөрөнгө оруулалт борлуулснаас;
 - 5.6.1.3 Бусад талуудад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлтөөс; (санхүүгийн байгууллагын хувьд олгосон зээл, мөнгөн урьдчилгаа нь үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээнд хамаарна);
 - 5.6.1.4 Мөнгөөр хүлээн авсан хүү;
 - 5.6.1.5 Мөнгөөр хүлээн авсан ногдол ашиг;
 - 5.6.1.6 Бусад мөнгөн орлого.
 - 5.6.2 Хөрөнгө оруулалтын мөнгөн зарлагад:
 - 5.6.2.1 Үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгө болон бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн мөнгө;
 - 5.6.2.2 Урт болон богино хугацаат хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн мөнгө;
 - 5.6.2.3 Бусад талуудад олгосон зээл, мөнгөн урьдчилгаа;
 - 5.6.2.4 Бусад мөнгөн зарлага орно.
 - 5.6.3 Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээг хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн орлого болон мөнгөн зарлагын зөрүүгээр тодорхойлно.
- 5.7 **Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** нь санхүүжилтийн бусад эх үүсвэр, орж ирэх хөрөнгө оруулалттай холбоотойгоор өр төлбөр ба өөрийн хөрөнгө өөрчлөгдөх үйл ажиллагааг хамарна.
 - 5.7.1 Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн орлогод:
 - 5.7.1.1 Банкнаас авсан урт болон богино хугацааны зээл, бүх төрлийн өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан мөнгө;
 - 5.7.1.2 Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан мөнгө;
 - 5.7.1.3 Бусад мөнгөн орлого.
 - 5.7.2 Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн зарлагад:
 - 5.7.2.1 Зээл, өрийн бичгийн төлбөрт төлсөн мөнгө, урт хугацаат өрийн тайлангийн хугацааны төлөлт;
 - 5.7.2.2 Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн;
 - 5.7.2.3 Хувьцаа буцаан худалдан авахад төлсөн;
 - 5.7.2.4 Мөнгөөр төлсөн ногдол ашиг;
 - 5.7.2.5 Бусад мөнгөн зарлага.
 - 5.7.3 Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээг санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн орлого болон мөнгөн зарлагын зөрүүгээр тодорхойлно.
- 5.8 **Мөнгөн хөрөнгийн цэвэр өсөлт, бууралтыг** үндсэн үйл ажиллагааны, хөрөнгө оруулалтын, санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний нийлбэрээр тодорхойлно. Мөн үүнд мөнгөн хөрөнгөтэй холбогдуулан үүссэн ханшийн зөрүүний нөлөөллийг багтаах ба уг нөлөөллийг тооцоолохдоо мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг валютын албан ханшаар дахин илэрхийлж, өмнөх ханшаар илэрхийлж байсан дүнгээс хасна.
- 5.9 Тайлант хугацааны мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдлээс эхний үлдэгдлийг хасч тодорхойлсон мөнгөн хөрөнгийн цэвэр өөрчлөлт нь мөнгөн гүйлгээний тайланд тодорхойлогдсон "Бүх цэвэр мөнгөн гүйлгээ"-ний дүнтэй тэнцүү байна.

- 5.10 Мөнгөн гүйлгээг нэмэгдүүлэх ба хорогдуулахад нөлөөлдөггүй ажил гүйлгээнд хувьцаа гаргаж орлогод авсан үндсэн хөрөнгө, үндсэн хөрөнгө ба санхүүгийн хэрэгслийн дахин үнэлгээ, хувьцаагаар олгох ногдол ашиг гэх мэт орно.

ЗУРГАА. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

- 6.1 Даатгалын компанийн санхүүгийн тайлангийн тодруулгад доорх зүйлсийг хамруулна:
- 6.1.1 Санхүүгийн тайланг бэлтгэх тулгуур үзэл баримтлал, ажил гүйлгээ ба үйл явдлыг бүртгэхээр сонгож авсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын талаарх тайлбарыг агуулсан байх;
 - 6.1.2 Санхүүгийн байдлын тайлан, Орлогын дэлгэрэнгүй тайлан, Өмчийн өөрчлөлтийн тайлан, Мөнгөн гүйлгээний тайлан гэх зэрэг санхүүгийн тайлангуудад тусгагдаагүй боловч СТОУС-аар шаарддаг мэдээллийг тодруулсан байх;
 - 6.1.3 Санхүүгийн байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлантай холбоотойгоор хийсэн нарийвчилсан шинжилгээ, нэмэлт тайлбар, болзошгүй үүрэг гэх мэт нэмэлт мэдээллийг санхүүгийн тайлангийн тодруулгад тусгана.
- 6.2 Санхүүгийн тайлангийн тодруулгад санхүүгийн тайлангийн зүйл тус бүрийн мэдээллийг тайлангийн дэс дарааллын дагуу толилуулна. Толилуулж, тодруулж буй дүнг зэрэгцүүлэх сууриар бэлтгэнэ (өөрөөр хэлбэл, тайлант хугацааны дүнг өмнөх хугацааны дүнтэй зэрэгцүүлнэ).

Тайлан бэлтгэх үндэслэл

- 6.3 Даатгалын компанийн үйл ажиллагаа, бүтэц, зохион байгуулалт, компанийн нэр, санхүүгийн тайлангийн дуусгавар болсон огноо, санхүүгийн тайлангийн хамарсан хугацаа, компанийн бүтэц, зохион байгуулалтанд гарсан гол өөрчлөлт, санхүүгийн тайлан СТОУС-д нийцсэн тухай тайлбар, нягтлан бодох бүртгэлийн ашиглаж буй суурь, ерөнхий бодлогын товч тайлбар зэргийг товч тодорхойлж, харуулна.
- 6.4 Шинээр гарсан бөгөөд тухайн тайлант жилийн эхнээс мөрдөж эхлэх СТОУС, дараагийн тайлант үеэс хүчин төгөлдөр үйлчилж эхлэх СТОУС, тайлбарыг тус тус анхааран үзэж, мөрдлөг болгох ба шинэ стандарт, тайлбарыг мөрдсөн жилийн ба түүнээс хойшхи жилүүдийн санхүүгийн тайланд үзүүлэх үр нөлөөллийг үнэлнэ. Энэ мэдээллийг СТОУС-д нийцүүлсэн тухай мэдэгдэл эсвэл санхүүгийн тайлангийн тодруулгын холбогдох хэсэгт дурдана.
- 6.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлогыг тодруулахдаа санхүүгийн тайланд тусгасан үзүүлэлтүүдийг бүртгэх аргуудыг тайлбарлан үзүүлнэ. Зарим зүйлсийг хүснэгтээр илэрхийлж болно. Үүнээс гадна нягтлан бодох бүртгэлийн бодлогыг тодруулахдаа дараах зүйлсийн тухай дурдаж болно:
- 6.5.1 Санхүүгийн тайланг бэлтгэж, тайлагнах арга ажиллагаа;
 - 6.5.2 Компанид мөрдөгдөж буй нягтлан бодох бүртгэл хөтлөх маягт, аргачлал;
 - 6.5.3 Бүртгэлийн ба тайлагналын валют;
 - 6.5.4 Санхүүгийн тайлангийн зүйл тус бүрээр хүлээн зөвшөөрөх зарчим, үнэлж бүртгэх арга;
 - 6.5.5 Бүх төрлийн нөөц, сан байгуулах арга;
 - 6.5.6 Бодит үнэ цэнийн үнэлгээ, тооцоолол;
 - 6.5.7 Болзошгүй зүйлс;
 - 6.5.8 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга;
 - 6.5.9 Нэгтгэсэн санхүүгийн тайлан бэлтгэх зарчим.
- 6.6 Тайлант хугацааны төгсгөлд гадаад валютаар илэрхийлэгдсэн зүйлсийг төгрөгт (бүртгэлийн валют) хөрвүүлэхэд ашигласан, Монголбанкнаас зарласан гадаад валютын албан ханшийг тодруулж болно. Энэ мэдээллийг нягтлан бодох бүртгэлийн тодруулгын аль тохиромжтой гэж үзсэн хэсэгт дурдана.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт

- 6.7 Энэ хэсэгт нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдаа, тооцооллыг өөрчлөлтийн талаар НББОУС 8-д заасны дагуу тодруулна.
- 6.8 Хэрэв компани нягтлан бодох бүртгэлийн бодлогоо өөрчилсөн бол өөрчлөх болсон шалтгаан, өөрчлөлтийн шинж чанар, шилжилтийн нөхцлийг тодорхойлж, нягтлан бодох бүртгэлийн шинэ бодлого илүү найдвартай, хамааралтай мэдээллээр хангана гэж үзсэн шалтгаан, түүний санхүүгийн тайланд үзүүлсэн нөлөөлөл зэргийг тодруулна.

- 6.9 НББОУС 8-д заасны дагуу нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлтийг гүйцээн мөрдөх горимоор хүлээн зөвшөөрч байгаа бол түүний шинж чанар, санхүүгийн тайланд үзүүлсэн нөлөө, ирээдүйд үзүүлж болзошгүй нөлөөлөл зэргийг тодорхойлох боломжтой үед тодруулна.
- 6.10 Компани өмнөх тайлант хугацаанд хамаарах алдааг илрүүлж, залруулсан бол энэ талаар тодруулна.

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

- 6.11 НББОУС 7-д заасан мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн шалгуур хангасан хөрөнгө, түүний тайлант үеийн эхний, эцсийн үлдэгдэлд гарсан өөрчлөлт, бусад шаардлагатай нэмэлт тайлбарыг тодруулна. Компанийн үйл ажиллагааны цар хүрээг өсгөх, тогтвортой байдлыг хангах зорилгоор гарсан мөнгөн гүйлгээг тусгайлан тодруулж болно.

Даатгалын авлага

- 6.12 Даатгалын авлагын ангилал тус бүрээр тайлант үеийн эхний, эцсийн үлдэгдэлд гарсан өөрчлөлтийг тодруулахаас гадна дараах зүйлсийг тодруулна.
- 6.12.1 Даатгалын авлагын барагдуулах хугацаараар ангилан харуулах;
- 6.12.2 Даатгалын авлагын найдваргүй гэж даснаас хассан дүн;
- 6.12.3 Холбоотой талаас авах даатгалын авлага;
- 6.12.4 Өмнөх тайлант хугацаанд сангаар хаасан даатгалын авлагын тайлант хугацаанд барагдуулсан дүн;
- 6.12.5 Бусад шаардлагатай нэмэлт тайлбарыг тодруулна.

Даатгалын хөрөнгө

- 6.13 Даатгалын хөрөнгийн ангилал тус бүрээр тайлант үеийн эхний, эцсийн үлдэгдэлд гарсан өөрчлөлтийг, тайлбарын хамт тодруулна. Даатгалын хөрөнгийг тооцоолсон аргыг тодруулна. Бусад шаардлагатай нэмэлт тайлбарыг тодруулна.

Хөрөнгө оруулалт

- 6.14 Хадгаламж, хадгаламжийн сертификат: Дотоод болон гадаадын банк санхүүгийн байгууллагад байршуулсан 3 сараас дээш хугацаатай хадгаламж, хадгаламжийн сертификатын хувьд дараах зүйлсийг санхүүгийн тайлангийн тодруулгад тусгана.
- 6.14.1 Дотоод болон гадаадын банк санхүүгийн байгууллагад байршуулсан 3 сараас дээш хугацаатай хадгаламж, хадгаламжийн сертификатын бүрэлдэхүүн, ангилал;
- 6.14.2 Дотоод болон гадаадын банк санхүүгийн байгууллагад байршуулсан 3 сараас дээш хугацаатай хадгаламж, хадгаламжийн сертификатын бодит үнэ цэн болон хорогдуулсан өртөг;
- 6.14.3 Дотоод болон гадаадын банк санхүүгийн байгууллагад байршуулсан 3 сараас дээш хугацаатай хадгаламж, хадгаламжийн сертификатын хүү буюу бусад өгөөж;
- 6.14.4 Даатгалын компанийн эзэмшилд байгаа боловч компани өөрөө ашиглах боломжгүй, хязгаарлагдмал хадгаламж, хадгаламжийн сертификат;
- 6.14.5 Дотоод болон гадаадын банк санхүүгийн байгууллагад байршуулсан 3 сараас дээш хугацаатай хадгаламж, хадгаламжийн сертификатын үлдэгдэлд гарсан өөрчлөлтийг тайлбарын хамт тодруулна.
- 6.14.6 СТОУС 7-д заасан бусад тодруулгад холбогдох үнэлгээний аргачлалыг ашиглан тооцсон дотоод болон гадаадын банк санхүүгийн байгууллагад байршуулсан 3 сараас дээш хугацаатай хадгаламж, хадгаламжийн сертификатын үнэ цэн бууралтыг тодруулна. Үнэлгээний аргачлалаар үнэ цэнийн бууралтыг тогтоох боломжгүй тохиолдолд хөрөнгийн чанарын талаар тодруулж, тайлбарлаж болно.
- 6.15 Үнэт цаас:
- 6.15.1 Даатгалын компани үнэт цаасны ангиллыг тодорхойлсон үндэслэлээ баримтжуулж, баталгаажуулах бөгөөд ангилал тус бүрээр санхүүгийн тайлангийн тодруулга бэлтгэнэ.
- 6.15.2 Үнэт цаасны ангилал бүрээр эргэн төлөгдөх хугацааг тодруулна. СТОУС 7-д шаардсан бусад тодруулгууд болон хөрөнгө оруулалтын үнэт цаасны чанарын талаарх тодруулга, дараах ангилал бүрээр хугацаа хэтэрсэн боловч үнэ цэн буураагүй үнэт цаасыг тодруулна: арилжааны үнэт цаас, хугацааны эцэс хүртэл эзэмших үнэт цаас.
- 6.15.3 Даатгалын компани хугацаа хэтрээгүй бөгөөд үнэ цэн буураагүй гэж ангилсан өрийн үнэт цаасны хөрөнгийн чанарын талаар дэлгэрэнгүй мэдээллийг тодруулна.
- 6.15.4 Үнэт цаасны бодит үнэ цэнийг үнэлэн, тооцсон аргачлалыг тодруулна. Үнэт цаасны арилжаатай холбоотой хүлээж болзошгүй эрсдэл, эрсдэлийн үнэлгээ, шинжилгээний талаар тодруулна.

- 6.16 Хараат, хамтын хяналттай, охин компанид оруулсан хөрөнгө оруулалт:
- 6.16.1 Хараат ба хамтын хяналттай аж ахуйн нэгж, охин компанийн саналын эрхтэй энгийн хувьцаанаас компанийн эзэмшилд буй хувь оролцоо, түүнд гарсан өөрчлөлтийг тодруулна.
 - 6.16.2 Санхүүгийн нэгдсэн тайланд хяналтын эрхгүй хувь оролцоо, түүнд гарсан хөдөлгөөнийг мөн тодруулна.
 - 6.16.3 Хараат ба хамтын хяналттай аж ахуйн нэгжид хамаарах охин компанид тогтоосон хяналтыг баримтжуулж, тодруулна.
 - 6.16.4 Хараат ба хамтын хяналттай аж ахуйн нэгжид оруулсан хөрөнгө оруулалтыг бүртгэсэн арга, уг аргатай холбогдуулан хийсэн үнэлгээ, тооцооллын нэмэлт тодруулгыг хийнэ.
 - 6.16.5 Хараат ба хамтын хяналттай аж ахуйн нэгж, охин компанид оруулсан үнэт цаасны эрсдэлийн санд гарсан өөрчлөлтийг хөрөнгө оруулалтын ангилал тус бүрээр тодруулна.
 - 6.16.6 Хөрөнгө оруулалтыг бусадтай хийх тооцоонд барьцаа болгосон бол энэ талаар тодруулна
- 6.17 Дериватив санхүүгийн хэрэглүүр:
- 6.17.1 Гадаад валют, үнэт металлыг арилжаалах хэлцэл, бусад деривативыг ангилал бүрээр нь бүлэглэж, холбогдох үлдэгдэл, тайлант хугацаанд гарсан өөрчлөлт, хүлээн зөвшөөрсөн үнэлгээний ба арилжааны орлого, зардлыг тодруулна.
 - 6.17.2 Тодруулгад форвард, своп, фьючерс, опшин хэлцэл, бусад деривативтай холбоотойгоор хүлээн зөвшөөрч бүртгэсэн деривативын бодит үнэ цэнийн тооцоолол, түүнд ашигласан үнэлгээний аргыг оруулна.
 - 6.17.3 Гадаад валют, үнэт металл, үнэт цаасыг худалдах эсвэл худалдан авахаар байгуулсан форвард, своп, фьючерс, опшин хэлцэлтэй холбоотой хүлээж болзошгүй эрсдэл, түүнд даатгалын компанийн зүгээс хийсэн үнэлгээ, шинжилгээг тодруулна.

Бусад санхүүгийн ба санхүүгийн бус хөрөнгө

- 6.18 Бусад авлага, урьдчилгаа тооцоотой холбогдуулан дараах тодруулгыг нэмж бэлтгэнэ.
- 6.18.1 Бусад авлагыг барагдуулах хугацаагаар ангилан харуулах;
 - 6.18.2 Бусад авлагын авлагын найдваргүй гэж данснаас хассан дүн;
 - 6.18.3 Бусад авлага, урьдчилгааг данснаас хасахад үүссэн олз, гарз;
 - 6.18.4 Холбоотой талаас авах бусад авлага.
- 6.19 Бараа, материал: Бараа материалтай холбогдуулан хөрөнгийн үнэ цэнийн бууралт, бараа, материалыг данснаас хасахад үүссэн олз, гарзыг нэмж тодруулж болно.
- 6.20 Өмчлөх бусад хөрөнгө: Өмчлөх бусад хөрөнгийг чанар, нэр төрлөөр нь ангилж харуулах ба дараах зүйлсийг тодруулна:
- 6.20.1 Тайлант хугацаанд зээлийн өрөнд авсан санхүүгийн бус хөрөнгийн дүн, холбогдох мэдээлэл;
 - 6.20.2 Тайлант хугацаанд нөхөн төлбөрийн тооцоонд авсан санхүүгийн ба санхүүгйн бус хөрөнгийн дүн, холбогдох мэдээлэл;
 - 6.20.3 Данснаас хассан өмчлөх бусад хөрөнгийн дүн;
 - 6.20.4 Тайлант хугацаанд худалдан борлуулсан хөрөнгийн дүн, үүссэн олз ба гарз;

Үндсэн хөрөнгө

- 6.21 Үндсэн хөрөнгийн ангилал тус бүрээр дансны үлдэгдэл, хуримтлагдсан элэгдэл, элэгдлийн зардал, тэдгээрийн тайлант хугацаанд гарсан өөрчлөлтийг хүснэгтийн дагуу харуулах ба дараах мэдээллийг нэмж тодруулна:
- 6.21.1 Ашигласан элэгдлийн арга, элэгдүүлэх хувь хэмжээ;
 - 6.21.2 Үндсэн хөрөнгийн үнэ цэнийн бууралттай холбоотой хөдөлгөөн гарсан бол хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтын зардал эсвэл буцаалт, холбогдох тооцоолол, үнэлгээ;
 - 6.21.3 Үндсэн хөрөнгийг дахин үнэлсэн бол үнэлгээ хийгдсэн өдөр, дахин үнэлгээний нэмэгдэл дансанд гарсан өсөлт, бууралт, ашигласан үнэлгээний аргачлал, эсвэл хөрөнгийн үнэлгээчнээр үнэлүүлсэн үнэлгээ;
 - 6.21.4 Санхүүгийн түрээсээр авсан хөрөнгө, холбогдох санхүүгийн түрээсийн өглөг;
 - 6.21.5 Барьцаанд байгаа үндсэн хөрөнгө;
 - 6.21.6 Бүтээн босгох ажлын үе шатанд байгаа үндсэн хөрөнгийн өртөгт хүлээн зөвшөөрсөн зардлын дүн, бүтэц;
 - 6.21.7 Үндсэн хөрөнгийн санхүүжилтэнд бүртгэсэн, хараахан хүлээн аваагүй үндсэн хөрөнгийн худалдан авалтын урьдчилгаа;
 - 6.21.8 Үндсэн хөрөнгийг данснаас хасахад үүссэн олз ба гарз.

Биет бус хөрөнгө

- 6.22 Биет бус хөрөнгийн ангилал тус бүрээр дансны үлдэгдэл, хуримтлагдсан хорогдол, хорогдлын зардал, тэдгээрийн тайлант хугацаанд гарсан өөрчлөлтийг хүснэгтийн дагуу харуулахын зэрэгцээ дараах мэдээллийг нэмж тодруулна:
- 6.22.1 Ашиглалтын хугацаа нь тодорхой биет бус хөрөнгийн хувьд хорогдол тооцоход ашигласан арга, хорогдуулах хугацаа, норм, тайлант жилийн хорогдлын зардлын дүн;
 - 6.22.2 Дахин үнэлгээний өөрчлөлтөөс гарсан өртгийн өсөлт, бууралт ба өмч, орлогын тайланд хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн өсөлт, бууралт;
 - 6.22.3 Биет бус хөрөнгийн үнэ цэнийг бууруулахтай холбоотойгоор хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтын зардал эсвэл буцаалт, холбогдох тооцоолол, үнэлгээ;
 - 6.22.4 Бүтээн босгох ажлын үе шатанд байгаа биет бус хөрөнгийн өртөгт хүлээн зөвшөөрсөн зардлын дүн, бүтэц;
 - 6.22.5 Биет бус хөрөнгийн санхүүжилтэнд бүртгэсэн, хараахан хүлээн аваагүй биет бус хөрөнгийн худалдан авалт;
 - 6.22.6 Биет бус хөрөнгийг данснаас хасахад үүссэн олз ба гарз.

Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө

- 6.23 НББОУС 40-д заасны дагуу хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгөнд ашигласан хэмжилтийн суурь, бодит үнэ цэнийн загвар ашигладаг бол бодит үнэ цэнийг тодорхойлоход ашигласан арга, бодит үнэ цэнийн тохируулгаас үүссэн олз, гарз, хэрэв түрээсэлдэг бол түрээсийн орлого, түрээсэлсэн хөрөнгөтэй холбоотой гарсан зардал, хэрэв өртгийн загвар ашигладаг бол хөрөнгийн ашиглалтын хугацаа, элэгдэл тооцох арга болон бусад тодруулгыг хийнэ.

Даатгалын өглөг

- 6.24 Даатгалын өглөгийг нэр төрлөөр нь ангилж, тайлант үеийн эхний ба эцсийн үлдэгдэлийг харуулах ба бусад нэмэлт тайлбар тэмдэглэлийг тодруулна. Дансны өглөгийн төлөгдөх хугацаандаа байгаа, хугацаа хэтэрсэн гэж ангилсан дүнг тодруулна. Шаардлагатай тохиолдолд материаллаг дүнтэй даатгалын өглөгийг тусд нь тодруулж болно.

Бусад санхүүгийн ба санхүүгийн бус өр төлбөр

- 6.25 Бусад өр төлбөрт багтсан бусдад өгөх өглөг, салбар хоорондын өглөг, бусад өглөг, татвар, НДШ-ийн өглөг (дутуу төлөлт), ажилтан албан хаагчидтай үүссэн тооцоо гэх мэт өр төлбөрийг өмнөх тайлант үеийн үлдэгдэлтэй харьцуулан тодруулна.
- 6.26 Ногдол ашгийг тайлагналын өдрөөс санхүүгийн тайланг албан ёсоор баталгаажуулж гаргах өдрийг хүртэлх хугацаанд зарласан ногдол ашгийг санхүүгийн тайланд дараа үеийн үйл явдлаар тодруулна.
- 6.27 Ажилтнуудад олгох тэтгэвэр, тэтгэмж, нийгмийн хөгжлийн сантай холбоотойгоор дараах зүйлсийг тодруулна:
- 6.27.1 Тэтгэвэр, тэтгэмжийн төрлүүд, тэдгээртэй холбогдон гарсан зардал;
 - 6.27.2 Урт хугацаат тэтгэвэр, тэтгэмжийн актуар тооцоолол, холбогдох орлого, зардал;
 - 6.27.3 Удирдах албан тушаалтнуудад олгохоор тооцоолсон нийт тэтгэвэр, тэтгэмжийн дүн;
 - 6.27.4 Ажилтнуудад хувьцаагаар олгосон шагнал, урамшуулал, тэтгэвэр, тэтгэмж ба хувьцаанд суурилсан төлбөрийн нөхцөл.

Хоёрдогч өглөг

- 6.28 Хоёрдогч өглөгийг бүрдүүлж буй хэрэгслүүдийг дурдаж, тэдгээрийн үлдэгдэлд гарсан өөрчлөлтийг тайлбарлан тодруулна.

Эзэмшигчдийн өмч

- 6.29 Хувь нийлүүлсэн хөрөнгийг бүрдүүлж буй хувьцааны тоо ширхэг, нэрлэсэн үнэ, хувьцаанд хамааралтай эрх, давуу эрх, эрхийн хязгаарлалт болон тайлант хугацаанд нэмж гаргасан хувьцааны тоо, үүссэн нэмж төлөгдсөн капитал, нэмж төлөгдсөн капиталд гарсан бусад өөрчлөлт, халаасны хувьцаанд гарсан өөрчлөлт, гаргасан хувьцааны опцион зэргийг тодруулна. Өөрийн хөрөнгөнд багтсан сангууд, тэдгээрийн зориулалтыг тодруулна.
- 6.30 Хувьцаа эзэмшигчидтэй хийсэн өмчийн ажил гүйлгээ. Тухайлбал, нэмж гаргасан хувьцаа, хувьцаа эзэмшигчдэд хуваарилсан ногдол ашиг гэх мэт.

6.31 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулгын улмаас хуримтлагдсан ашгийн эхний үлдэгдэлд гарсан залруулгын дүнг тодруулж, дэлгэрэнгүй тайлбар хийнэ. Мөн холбогдох стандартанд шаардсаны дагуу өөрийн хөрөнгөөр шууд хүлээн зөвшөөрсөн орлого, зардал, олз, гарзын дүнг зүйл тус бүрийн болон нийт дүнгийн хувьд тодруулна.

Даатгалын орлого ба зардал

6.32 Тайлант хугацааны орлого, зардлыг тодорзуулахдаа:

- 6.32.1 Орлого хүлээн зөвшөөрөхөд баримталсан нягтлан бодох бүртгэлийн бодлогыг тодруулна.
- 6.32.2 Орлогын нэр төрөл бүрээр хүлээн зөвшөөрсөн дүнг тодруулна.
- 6.32.3 Даатгалын орлогын гол нэр төрлийн талаар тодруулна.
- 6.32.4 Зардал хүлээн зөвшөөрөхөд баримталсан нягтлан бодох бүртгэлийн бодлогыг тодруулна. Зардлын нэр төрөл бүрээр хүлээн зөвшөөрсөн дүнг тодруулна.
- 6.32.5 Цалин, нийгмийн даатгалын шимтгэл, албан татвар, төлбөр, хураамж, томилолт, бичиг хэрэг, шуудан холбоо, мэргэжлийн үйлчилгээ, сургалт, сонин сэтгүүл захиалга, даатгал, цахилгаан, ус, дулаан, засвар, элэгдэл хорогдол, түрээс, харуул хамгаалалт, цэвэрлэгээ үйлчилгээ, тээвэр, шатахуун, хүлээн авалт, зар сурталчилгааны зардал зэргийг борлуулалт маркетингийн болон ерөнхий ба удирдлагын гэж ангилж тайлант оны болон өмнөх оны дүнг тодруулна.

Орлогын албан татварын зардал

6.33 Тайлант орлогын татварын зардалтай холбогдуулан дараах нэмэлт тодруулгыг бэлтгэнэ:

- 6.33.1 Татвар ногдох орлогын дүн, тооцоолсон ба бодит татварын зардлын хооронд хийгдэх тохируулга;
- 6.33.2 Ногдуулсан татварын зардлын дүн;
- 6.33.3 Татварын тооцоогоорх авлага, өглөгийн тайлант үеийн өөрчлөлт, үлдэгдэл;
- 6.33.4 Хойшлогдсон татварын хөрөнгө, хойшлогдсон татварын өглөгийн дүн, эдгээрт тайлант үед гарсан өөрчлөлт, түр зөрүүг үүсгэсэн тэнцлийн дансдын үлдэгдэл.

Болзошгүй хөрөнгө ба өр төлбөр

6.34 НББОУС 37-ын дагуу тайлагналын өдрийн байдлаар хэрэгжих магадлалтай болзошгүй хөрөнгө ба болзошгүй өр төлбөрийн шинж чанар, боломжтой бол тэдгээрийн үр нөлөөллийг харуулсан тооцооллыг тодруулна.

Тайлагналын үеийн дараах үйл явдал

6.35 НББОУС 10-ын дагуу тайлагналын өдрийн дараах үл залруулагдах үйл явдлын материаллаг ангилал бүрээр эдгээрийн онцлог шинж, санхүүгийн үр нөлөөг тодруулна. Тухайлбал, санхүүгийн тайлагналын өдөр, санхүүгийн тайланг хэвлэн нийтлэх хугацааны хооронд гарсан дараах зүйлсийг тодруулна:

- 6.35.1 Даатгалын компанийн үйл ажиллагаа, зохион байгуулалтанд гарсан томоохон өөрчлөлт;
- 6.35.2 Нөлөө бүхий үйл явдал (НББОУС 10-д заасан залруулах ба үл залруулах үйл явдал) болон нягтлан бодох бүртгэлийн зааварт багтсан дараа үеийн үйл явдлаас үүссэн олз ба гарз.

Тэнцлийн гадуурх дансд

6.36 Тайлант хугацаанд тэнцлийн гадуурх дансанд бүртгэсэн зүйлсийн үлдэгдэл, түүнд гарсан өөрчлөлтийг тодруулна. Зэрэгцүүлэх зорилгоор өмнөх хугацааны дүнг тайлант хугацааныхтай яг ижил хугацаагаар тасалбар болгон харуулна.